

Mongolian Economy



2020 оны 08 сар (167)

www.mongolianeconomy.mn

Хямрал

Эдийн засгийн ой
санамж ба хямрал

Вакцин

Хүн төрөлхтний аврал

4.84
их наяд

30.8
тэрбум

12.5
хувь

-9.8
хувь





БАЙГУУЛЛАГЫН

САНХҮҮГИЙН ЦОГЦ

ҮЙЛЧИЛГЭЭ

ХААН БИЗНЕС ҮЙЛЧИЛГЭЭ



111L

ANNIVERSARY • SINCE 1910

Samsonite

HOUSE OF SAMSONITE

- Наран Молл 2-р давхарт
/Хүүхдийн 100/
- Наран Плаза 2-р давхарт
/Энхтайваны гүүрний
баруун талд/

TRAVEL WORLD SHOP NARAN

- Наран Плэйс 2-р давхарт
/13-р хорооллын дунд зам/
- Наран Пойнт 1-р давхарт
/Засгийн газрын ордны
баруун хойно/

SAMSONITE BOUTIQUE

- Шангри-Ла Төв 1-р давхарт
/Олимпийн гудамж 19А/

УТАС: 8616-8646



МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР САР ТУТАМ



МОНГОЛ ШУУДАН
ТҮГЭЭМЭЛ ШУУДАН
-гаар дамжуулан
захиалаарай

Улирлын
захиалга
30.000₮



Утас: 7011-5477, 7011-5476

www.mongolianeconomy.mn

**Mongolian
Economy**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр (9999 4248)

РЕДАКТОР:
Н.Энхбаяр (9916 1303)

"ДЭЛХИЙ" СЭТГҮҮЛИЙН
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
Б.Энхцэцэг (9009 9880)

АНГЛИ РЕДАКТОР:
Жаклин Иветт Йстриж

СЭТГҮҮЛЧИД:
Г.Даваадорж
Г.Орхон
З.Цэлмэг
Б.Мишээл
Т.Сарангуя
(Хятад дахь сурвалжлагч)

ОРЧУУЛАГЧ:
М.Ариунзаяа

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН АЛБА:
Б.Энхцэцэг (9009 9880)
Ц.Оюун-Эрдэнэ (9915 6968)
Г.Амарсайхан (9499 2389)

ХАЯГ: Улаанбаатар,
Чингэлтэй дүүрэг, I хороо,
Экспресс таур. 1101 тоот

ВЭБ: www.mongolianeconomy.mn

И-МЭЙЛ:

info@mongolianeconomy.mn

FACEBOOK: Mongolian Economy

TWITTER: EconomyMongolia

УТАС: 7011 5476, 7011 5477

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/х-2762

СЭТГҮҮЛ ЗАХИАЛГА:
Монгол шуудан (Утас: 7007 8916)
Түгээмэл шуудан (Утас: 7011 5015)

Хямрал 6

Эдийн засгийн ой санамж ба хямрал

Ярилцлага 20

Б.Мөнхням: Ирэх оноос мөнгөгүй, улам их өртэй, ажлын байргүй улс болох вий гэдэгт санаа зовж байна

Ковид-19 ба нүүрс 24

25 саяд хүрэх үү?

Вакцин 26

Хүн төрөлхтний аврал

Сонирхолтой орчуулга 31

Ковид-19: Олон мянган хүний амь нас, олон их наядыг хэрхэн аврах вэ

The Economist 34

Абэгийн дараа

Дэлхий 2020 36

Доналд Трамп, тохиолдлоор Хятадад дайсагнагч

Үзэл бодол 38

Лукашенко: Төгсгөл ба надад үлдэх сэтгэгдэл

Хэл соёл 43

Аминаас үнэтэй эх хэл минь

Санхүүгийн боловсрол 46

“Зарлагаа хэрхэн удирдаж буйгаар нь санхүүгийн сахилга баттай эсэхийг тодорхойлж болно”

Байр суурь



Б.Баттөмөр:
Ирэх онд төсвийн ачаалал их байна



Х.Булгантуяа:
Харьцангуй давуу талууд үүсэж байна



Т.Доржханд:
Тодорхойгүй байдал ирэх онд ч үргэлжилнэ



З.Нарантуяа:
Эдийн засаг ойрын 1-2 жилд мэдэгдэхүйц тэлэхгүй



Н.Энхбаяр: Хятад улс нүүрсний импортын эрэлтийг бууруулж болзошгүй



Б.Түвшинтулга:
Цар тахлыг дотооддоо алдаагүй давуу талаа ашиглаж чадахгүй байна




Б.Мөнхсоёл: Уян хатан арга хэмжээ авбал эдийн засаг гүн хямралд орохоос сэргийлнэ



Б.Дөлгөөн:
Алсаа харсан бодлого явуулбал нүүрсний экспорт боломжийн байна




Г.Ганзориг: БНХАУ-ын боломжийг ашиглаж чадвал тэлэлтийн хамгийн том ялалт болно



Ж.Золжаргал:
Манай улс хилээ хаасан учраас австраличууд хожсон

2020 оны Төсөв (их наяд төгрөг)



Төсвийн алдагдлын санхүүжилт (тэрбум төгрөг)



2021 оны төсөөлөл

ДНБ-ий өсөлт

7.2%

Инфляц

7%

Төсвийн алдагдал ДНБ-ий

3.6%

Засгийн газрын өр ДНБ-ий

58.4%

Хямрал

Эдийн засгийн ой санамж ба хямрал



Хямралын ой санамж

Даажинтай сонсогдож мэдэх ч КОВИД-19 эдийн засгуудад “хямрал” гэдэг цаг хугацаагаар аялах “боломж” олгож байх шиг.

Дэлхийн эдийн засаг 2020 онд 6.2 хувиар агших тооцоог Дэлхийн банк гаргасан. Дэлхийн II дайнаас хойш ийм том агшилттай шийдвэр гаргагчид нүүр тулж байсангүй. 1973 оны газрын тосны хямралаар ч, 2009 оны санхүүгийн аварга донсолгооноор ч эдийн засгийн уналт энэ удаагийнхаас хоёр дахин бага байж. 1930-аад оны Их хямралаар дэлхийн эдийн засаг 17.6 хувь, 1945-1946 онд 15.4 хувиар огцом суларч байсан нь одоогийнхтой дүйх үзүүлэлт. Харин нэг хүнд ногдох ДНБ-ээр тооцож үзвэл 2020 оны тоон статистик тэртээ Аж үйлдвэрийн хоёрдугаар хувьсгал өрнөж байсан 1870 онтой эн зэрэгцэх төлөв гарсныг Дэлхийн банкны Development Prospects Group-ийн ахлах эдийн засагч Наотака Сүгавара тэмдэглэв.

Тэр цагаас хойш дэлхийн эдийн засагт 14 удаа


буюу дунджаар 10 жил тутамд хямрал тохиожээ. Наотака Сүгаварагийн тэмдэглэснээр худалдаа саарч, үйлчилгээ таг зогсож, масс ажилгүйдэл 1965 оноос хойш анх удаа ийм хэмжээнд хүрээд байна. Мөн газрын тосны хэрэглээ буурснаас нөөц нь огцом нэмэгдэж, гуравдугаар сард тохиосон үнийн уналт бүтэн сарын турш үргэлжлэв. Цар тахлын нөлөөгөөр дэлхий нийт сүүлийн 150 жилийн уналтын түүхээ эргэн харах нь тэр.

Улс орон бүр тэрхүү цаг хугацаа, он жилүүдийг эргэн харж, улирч баларсан гэлтгүйгээр түүхээс сургамж авч байна. АНУ Их хямралын үеийн эдийн засгийн үзүүлэлтүүдтэй тулж буй бол Японд Дэлхийн II дайны дараах шиг таагүй үе тохиов. Харин өмнөд хөршийн ДНБ-ий өсөлт нэгдүгээр улиралд 3.2 хувиар саарсан нь 29 жилд тохиож буй агшилт. 2009 оны санхүүгийн хямралын сүүдэр тусаагүй Австрали улс ч энэ удаад 30 жилийн тэртээхтэй адил нөхцөл байдалд орлоо.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн 37 орноос Британи хамгийн хүчтэй цохилт амсаж, 11 жилийн өмнөх таагүй түүхээ ▶

Сүүлийн 150 жилд дунджаар 10 жил тутам эдийн засгийн хямрал тохиож байв

Дэлхийд 1870 оноос хойш тохиосон хямрал



Эх сурвалж: Дэлхийн банк

- ▶ давтав. Ийнхүү цаг хугацаа хийгээд эдийн засгийн өсөлтөө дэнсэлж, цар тахлыг хамтдаа даван туулж, цаашид хэрхэхээ завгүй дэлхий эрэлхийлж байна.

Ой санамжгүй төсөв

САРС-ын дэгдэлтийн үед өмнөд хөршийн эдийн засаг 1.4 хувиар агшихад Монголын эдийн засаг 5.2 хувиар агшиж байсан түүх бий. Харин энэ удаад өмнөд хөршийн эдийн засаг 3.2 хувиар агшихад манайх 9.7 хувиар уруудлаа. Чөлөөт эдийн засагт шилжсэн 30 жилд ингэж таг зогсолт хийж, ёроолдоо тулж байсангүй. Хэдийгээр манай улс дотооддоо цар тахлыг алдаагүй ч олон сар үргэлжилсэн хагуу чанга хөл хорио, байгаа оноогүй шийдвэрүүд эдийн засгийг боомилж орхисон нь энэ. Энэ талаар олон эдийн засагч манай сэтгүүлд байр сууриа илэрхийлсэн.

Төсвийн алдагдал энэ онд ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэж байсныг шинэ УИХ 12.5 хувь болгож огцом нэмлээ. Ингэснээр төсвийн зардал өмнөхөөс 700 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдэн 14.57 их наяд, орлого хоёр их наядаар буурч 9.73 их наяд төгрөг болж, нийт 4.8 их наяд төгрөг буюу орлогынхоо тэн хагастай тэнцэх хэмжээний алдагдалтай төсөв баглав. Төсвийн ой санамжаас эрэл сурал хийвэл 2016 онд төсвийн алдагдал ДНБ-ий 15.3 хувьтай тэнцэж байсан нь 1990 оноос хойших хамгийн өндөр алдагдал. Гэхдээ мөнгөн дүнгээр тооцвол одоогийнхоос хавьгүй бага тоо гарна.

Төсвийн алдагдлыг гадаадын зээл тусламжаас гадна дотоодод Засгийн газрын бонд гаргах замаар шийдэхээр төлөвлөсөн. Үр дүнд нь 24 их наяд төгрөгөөр хэмжигдэж байгаа Засгийн газрын өр дахиад 4.8 их наяд төгрөг буюу одоогийн ханшаар 1.6 тэрбум гаруй ам.доллараар нэмэгдэнэ гэсэн үг. Үүнээс энэ

онд хоёр их наяд төгрөгийн өр төлж барагдуулна гэж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар мэдэгдсэн.

Цар тахлын улмаас уул уурхайн голтүүхий эдүүдийн үнэ буурч, эрэлт саарч, төсвийн орлого тасалдсан нь тодотгох гол шалтгаан болсон. Тодотголоор 1.3 их наяд төгрөгийг барилга байгууламж, зам талбай барьж байгуулахад зарцуулахаар төлөвлөсөн нь нийт алдагдлын 30 гаруй хувь юм. Энэ шийдвэрийг эдийн засагчид энэ хүнд хэцүү цаг үед төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашгаар нь эрэмбэлээгүй хэмээн шүүмжилж буй. Шаардлагагүй хөрөнгө оруулалтыг 1-2 жил царцааж, оронд нь ЖДҮ, бизнес эрхлэгчдээ дэмжих замаар ажлын байрыг хамгаалж, ирэх онд татварын орлогыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ аваагүй нь хуумгай, хариуцлагагүй үйлдэл болсныг МҮХАҮТ-аас эдийн засгийн сэтгүүлчдийн клубтэй хамтран есдүгээр сарын 4-нд зохион байгуулсан “Эдийн засгийн хүндрэлийг улсын төсвийн оновчтой төлөвлөлт, удирдлагаар даван туулах нь” хэлэлцүүлэгт оролцсон хувийн хэвшлийн төлөөлөл хэлж байсан юм.


Цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх хүндрэлийг даван туулах арга хэмжээг он дуустал хэрэгжүүлэхэд зориулж 673.7 тэрбум төгрөг нэмж баталсан. Гэвч Эрүүл мэндийн сайдын багцыг ердөө 100 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Энэ нь 4.8 их наяд төгрөгийн алдагдлыг зөвтгөх шалтгаан болохгүй гэдгийг эдийн засагч Б.Дөлгөөн онцолсон.

Өнгөрсөн сарын 29-нд 2020 онд төсвийн алдагдал төсвийн тодотголыг батлах орлогынхоо тэн хагастай тэнцэж байна эцсийн хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл “4.8 их наяд төгрөгийн алдагдал

бол Монгол Улс 2020 онд хэдий хэмжээний өр тавьж байгааг харуулж байна. Өнөөдөр 100 мянга орчим иргэний ипотекийн зээлийн хэмжээ 4.7 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын 200 гаруй мянган яндангийн тэн хагасыг бууруулах боломжтой мөнгө гэсэн үг. Ийм хэмжээний мөнгийг Монгол Улсын Засгийн газар нэг жилийн дотор төсвийн алдагдал болгоод баталж байна” хэмээсэн.

Тодотгол хэлэлцэх явцад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ оны төсвийн алдагдлыг ДНБ-ий 2.9 хувиас хэтрүүлэхгүй байх санал гаргаж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулах алхам хийж болохгүйг анхааруулжээ. Ирэх онд төлөх ёстой “Чингис” бондын төлбөрийг олон улсаас хөрөнгө босгох замаар эргэн төлөхөөр төлөвлөсөн. Тиймээс санхүүжилтийн өртгийг бууруулахад анхаарч, төсвийн ▶

2020 оны Төсөв (их наяд төгрөг)



Төсвийн алдагдлын санхүүжилт (тэрбум төгрөг)



- ▶ болон төлбөрийн тэнцлийн алдагдлаа хамгийн бага түвшинд байлгахыг манай гадаад түнш байгууллагууд, эдийн засагчид анхааруулж байгаа.

Гэвч цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөг бууруулах зорилгоор ихэнх улс төсвөө тэлэх бодлого баримталж, улмаар шинжээчид төсвийн алдагдал нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Манай Засгийн газар ч гэсэн халамжаар дамжуулан иргэдийн худалдан авалт, хэрэглээг дэмжиж байгаа.

Эл бодлогыг хэрэгжүүлэхийн тулд өрийн дөнгөө чангалах л сонголт хийж байгааг түүхэнд байгаагүй өндөр дүнтэй алдагдал баталсан энэ жилийн төсөв

харуулж байна. Төсөвт дарамт болоод зогсохгүй эдийн засагт асар том ул мөр үлдээх энэ удаагийн шийдвэрийн ужиг шалтгаан нь түүхий эдийн орлогыг дагаж төсвийн зардлаа тэлдэг Голланд өвчин юм. Үүнийг эрх баригчид мартсан байж магадгүй. Харин КОВИД-19 тэрхүү мартагдсан ой санамжийг буцааж сэргээв.

Хөршдөө л найдаж сууна

Ирэх онд дэлхийн эдийн засаг “V” хэлбэрийн буюу огцом уруудаад эргээд өсөх төлөвтэй. Энэ дагуу манай улс ч ирэх онд ДНБ 7.2 хувиар өсөж, төсвийн алдагдлыг ДНБ-ий 3.6 хувьд барина гэж төсвийн хүрээний мэдэгдэлд тооцжээ. КОВИД-19 цар тахлын давалгаа хэзээ намжих нь тодорхойгүй, вакцинжуулалтын үр дүнг хэзээ үзэх нь бас л бүдэг бадаг энэ цаг дор УИХ, Засгийн газар ирэх оныг дэндүү өөдрөгөөр харж байна гэсэн үг.

Ийм хэмжээний төсвийг санхүүжүүлэн, ирэх онд байдал сайжирна гэдэгт эрх баригчдын найдаж буй ганц зүйл нь өмнөд хөршийн эдийн засаг. Дэлхийн эдийн засгийн төлвийг тодорхойлдог олон улсын байгууллагуудын тооцоогоор энэ онд БНХАУ-аас бусад зах зээл агшина.

Гадаад худалдааны 90 хувь, төсвийн орлогынх нь 30 гаруй хувийг бүрдүүлдэг өмнөд хөршийн хаялгаас манай эдийн засгийн тэн хагас шалтгаалдаг. Харин өмнөд хөршийн ирээдүй хэрхэх вэ гэдэгт тус улсын дотоод бодлого, цар тахал, АНУ-тай үүсгэсэн худалдааны маргаан гол нөлөө үзүүлнэ. Хятадын тэлэлтийг хязгаарлах гэсэн геополитик цаашдаа ч өрнөх нь тодорхой байхад хэт өөдрөг төсөөлөх нь эрсдэлтэй гэж үзэх эдийн засагчид бий. Дэлхийн хамгийн том эдийн засагтай АНУ чөлөөт зах зээлд өмнөд хөршийн төрийн хэт оролцоотой эдийн засгийн бодлогыг эсэргүүцэх нь тодорхой зүйл.

Гэхдээ КОВИД-19, худалдааны дайн гэсэн хоёр том сорилттой тулгарсан өмнөд хөршийн удирдлага эдийн засгаа дотоодоосоо дэмжиж эхэлсэн. Цар тахлын шинэ голомтыг хяналтдаа оруулах, тархалтыг зогсоох чадавх нь илт сайжирснаас гадна манай коксжих нүүрсний эрэлтийг хөтлөгч гангийн үйлдвэрлэл оны хоёрдугаар хагаст илт сэргэжээ. Хятадын үндэсний статистикийн хорооны мэдээгээр нэгдүгээр улиралд 1.6 хувиар агшсан эдийн засаг хагас жилийн байдлаар 3.2 хувиар өсөхөд гангийн үйлдвэрлэл чухал нөлөө үзүүлсэн байна. Өмнөд хөрш энэ жил гангийн үйлдвэрлэлээ нэг тэрбум тоннд хүргэхээр төлөвлөсөн бөгөөд хагас жилийн байдлаар 499 сая тоннд хүрсэн талаар тус ▶

► улсын Үндэсний статистикийн хороо мэдээлжээ. Энэ бол цар тахлын улмаас Хятадын гадаад худалдааны түншүүд зогсонги байдалд орж, экспорт нь саарсан ч дотооддоо гангийн хэрэглээг дэмжиж буйн илрэл.

Засгийн газрын дэмжлэгтэйгээр орон нутгийн удирдлагууд 956 тэрбум ам.доллар буюу нийтдээ 6.7 их наяд юанийн бондын хөрөнгө оруулалтыг дэд бүтцээ дэмжихэд зарцуулаад байгаа аж. Орон нутагт 5G, хиймэл оюун ухаан зэрэг технологийг дэмжихээс гадна хурдны зам, төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтуудыг өрнүүлж байгаа нь гангийн эрэлтийг өрдөх гол хөдөлгүүрүүд. Financial Times-ийн мэдээлснээр Европ, АНУ, Энэтхэгт гангийн үйлдвэрүүд саарсан бол Хятадад өнгөрсөн жилийнхээс илүү эрчимтэй ажиллаж байна. Энэ оны эхний таван сарын байдлаар Хятадын гангийн гол үйлдвэрлэгчдийн ашиг 50.9 хувь буюу 41.9 тэрбум юань (6 тэрбум ам.доллар)-аар буурсан боловч орлого нь 81.8 хувиар нэмэгдсэн байна. S&P Global Platts энэ онд Хятадын гангийн төлвийг сайжруулж, үйлдвэрлэлийн хэмжээг 1.7-2 хувиар нэмэгдүүлжээ. Энэ нь өмнөд хөршийн гангийн үйлдвэрлэл энэ онд 1.016 тэрбум тонн болж, өнгөрсөн оны 996 сая тонноос 20 сая тонноор нэмэгдэнэ гэсэн үг юм.

Өрнийн томоохон хэвлэлүүдийн мэдээлж буйгаар өмнөд хөршийн ган үйлдвэрлэгчид цар тахлын үеийн намжмал байдлыг ашиглан дэлхийн аж үйлдвэр дэх нөлөөллөө зузаатгахаар чармайж байна. 2017 онд өмнөд хөрш дэлхийн нийт гангийн үйлдвэрлэлийн 49.2 хувийг бүрдүүлдэг байсан бол 2019 онд 54 хувь, энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар 62 хувийг эзэлж байгааг Дэлхийн гангийн нийгэмлэг мэдээлжээ. New York Times-ийн Шанхай дахь төлөөлөгч Кит Брэдшер долдугаар сард цар тахлын үеийг ашиглан Хятад улс нэг

КОВИД-19-ийн эсрэг он дуустал хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилт (тэрбум төгрөг)

	НИЙТ
НДШ-ийн хөнгөлөлт	673.7
Хүүхдийн мөнгө болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж	144.4
Хүнсний талонд	322
Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах	6
Бусад мэргэжлийн салбарын бэлэн байдлыг хангах	118.6
Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөд	6.2
Оношлуур, эм эмнэлгийн хэрэгслийг гааль, НӨАТ-ын хөнгөлөлт	40
ААНОАТ-ын хөнгөлөлт	14
Түрээсийн орлогын хөнгөлөлт	15
	7.5

Эх сурвалж: Сангийн Яам

удаагийн маск, гар ариутгагчаас эхлээд оношилгооны тестер зэрэг эрүүл мэндийн бүтээгдэхүүн, түүнийг үйлдвэрлэдэг тоног төхөөрөмжийн зах зээлд гарахаар эрчимтэй ажиллаж буй талаар нийтэлсэн. Өмнөд хөрш “Made in China 2025” аж үйлдвэрийн бодлогын хүрээнд эрүүл мэндийн салбараас эхлээд аж үйлдвэрийн гол салбаруудад импортын хамаарлыг шат дараатай бууруулж, яваандаа экспортлох амбицтай. К.Брэдшер “Эрүүл мэндийн хангамж хэрэгслээс эхлээд бичил чип, нисэх онгоцны хувьд гадаад хамаарал ихтэй байсанд Хятадын эрх баригчид санаа зовж эхэлсэн. Тиймээс татаас олгох, бодлогоор дэмжих замаар аж үйлдвэрийн чухал салбаруудаа хүчтэй гаргаж ирсэн юм. Жишээ нь, агаарын бохирдол, газрын тосны хэт хамаарлаа бууруулахын тулд нар, салхины эрчим хүч, хурдны төмөр замын технологио хөгжүүлсэн. Яг үүн шиг алхмыг ойрын ирээдүйд дараа үеийн утасгүй сүлжээ болох 5G технологийн хөгжүүлэлтэд зориулан хийнэ. Эрүүл мэндийн сэлбэг хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэдэг тоног төхөөрөмж, технологи ч мөн адил байж магадгүй” гэжээ. Тиймээс ойрын ирээдүйд биеллээ олох энэхүү стратеги нь гангийн хэрэглээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байгаа гэж Radio Free Asia дүгнэсэн нь сонирхолтой бас анхаарууштай гаргалгаа. Тэглээ гээд бид гуяа алгадвал дэндүү харалган үйлдэл болно. Улс орнуудыг цар тахалтай тэмцэж байх зуур өмнө зүгийн аварга луу дэлхийн аж үйлдвэрийн сэнтийд залрахаар хүржигнэж байгаа нь үнэн. Гэхдээ бид өөрсдөө бэлтгэл муутай, бодлого султай байснаараа луугаас улам л хамааралтай болж байна.

Компаниуд нь тамирдаж, ажлын байр устаж, иргэд улам зүдэрч байгаа нь ирэх онд эдийн засагт бараан дүр зураг буухыг зөгнөж буй нь дээрхийг улам батлах мэт.

2021 оны төсөөлөл

ДНБ-ий өсөлт

7.2%

Инфляц

7%

Төсвийн алдагдал ДНБ-ий

3.6%

Засгийн газрын өр ДНБ-ий

58.4%

Эх сурвалж: 2021-2022 оны төсвийн мэдээдэл

Байр суурь > Цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсвийн тодотголын талаар УИХ-ын гишүүд, эдийн засагч, судлаачид байр сууриа илэрхийллээ.

Б.Баттөмөр: Ирэх онд төсвийн ачаалал их байна



(УИХ-ын гишүүн)

Цар тахлын тархалт, вакцинжуулалт хэр үр дүнтэй байхаас эдийн засаг хэзээ сэргэх нь шалтгаална.

Дэлхийн банк, ОУВС-ийн гаргасан тооцооллоор өмнөд хөршийн төдийгүй дэлхийн эдийн засаг 2021 онд нэлээд тэлэх төсөөлөлтэй байгаа. Манай эдийн засгийг ч тэлнэ гэж тооцсон. Тэгэхээр халдварын тархалт буурч, ирэх онд эдийн засаг сэргэж эхэлнэ. Ер нь дэлхий нийтээрээ 2021 оныг өөдрөгөөр төсөөлж байгаа. Гэхдээ нөхцөл байдал хэрхэхээс шалтгаалж мэргэжлийн байгууллагууд төлөвөө шинэчлэхийг үгүйсгэхгүй. Ямар ч байсан УИХ-аас 2021 онд эдийн засгийг 7.2 хувиар өсгөх үүрэг даалгаврыг Засгийн газарт өгсөн.

Эдийн засгаа дэмжихийн тулд банкны зээлийн хүүг бууруулах тогтоол батлагдсантай холбоотойгоор 2023 оны эцэс гэхэд зээлийн хүү сарын нэг хувь болох буюу жилийн дүнгээр 12 орчим хувьтай болно. Одоо жилийн 16 орчим хувьтай байна. Ингээд тооцохоор бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлттэй байна.

Экспортын хувьд цар тахлын улмаас уруудсан уул уурхайн түүхий эдийн үнэ сэргэж эхэлсэн бөгөөд ирэх онд ч үнийн эерэг төлөв үргэлжилнэ гэж үзэж байна. Ялангуяа алтны үнэ

түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Нүүрс, зэсийн үнэ ч өөдрөг байгаа учраас 2021 онд түүхий эд дээр суурилсан эдийн засгийн хувьд боломж сайн байгаа. Хэдийгээр энэ жил цаг агаар тааламжтай, ургац арвин байх төлөв ажиглагдаж байгаа ч хөдөө аж ахуйгаа хөгжүүлэх нэн шаардлагатай.

Гэвч улсын төсөвт ирэх ачаалал өндөр байна. Ирэх онд төлөх бондын төлбөрөөс гадна жилд 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг тэглэх, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх шийдвэр, мөн энэ оны төсвийн тухай хуулиар 2.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэх төсвийг тодотголоор улам илүү алдагдалтай болсон, эхний хагас жилд эдийн засаг 9.7 хувиар агшсан зэрэг нь ирэх онд төсөвт ачаалал өгч болзошгүй.

Х.Булгантуяа: Харьцангуй давуу талууд үүсэж байна



(УИХ-ын гишүүн, Сангийн дэд сайд асан)

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн түүхий эдийн үнээс шалтгаалж өсөж, буурдагийг шийдвэр гаргагчдаас эхлээд хэвлэл мэдээлэл, олон нийт мэддэг болсон. Нэг удаа маш огцом өсөж, эргээд маш хүчтэй уналаа. Уул уурхайн түүхий эд өслөө гээд төсвийн зардлаа замбараагүй тавиад туучихаж болдоггүй юм байна гэдгийг хүмүүс ойлгодог боллоо. 2016 онд жилийн 11 хувийн хүүтэй

бонд босгож цалингаа тавьж байсан атлаа нөгөө талд “Сайн...” гэх мэт үр ашиггүй, өндөр зардалтай төсөл хөтөлбөр хэрэгжүүлж болдоггүйг иргэд олон нийт ч ойлгосон байна. Энэ хэрээр төсөвт тавих хяналт, сахилга бат ч гэсэн сайжирсан болов уу.

Өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд сайшааж буй хэд хэдэн зүйл бий. Хөтөлбөрийн үр дүнд Төсвийн тухай хууль маш чанга болсон. Гэхдээ ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжсэн, хэрэгжээгүй цаашид төсвийн алдагдлыг бууруулахын төлөө байх ёстой. Хэдийгээр энэ жил болон ирэх жилийн төсөв туйлын хүнд байгаа ч бид нарт харьцангуй давуу талууд үүсэж байна. Тухайлбал, зэсийн үнэ энэ оны төсөвт тооцсон 5900 ам.доллаароос хамаагүй өндөр боллоо. Тиймээс төсвийн тодотголд 6500 ам.доллаароор тооцсон. Алтны үнэ бас нэмэгдэж байна. Нүүрсний экспорт ч гэсэн овоо эрчимжлээ. Оргил үедээ өдөрт 2000 орчим машин боомтоор нэвтэрдэг. Энэ эрчээ үлдсэн хагас жилдээ барьчихвал төсвийн орлого бүрдэх боломж бололцоо харьцангуй гайгүй байна.

ОУВС-аас дэлхийн болон улс орнуудын эдийн засгийн төлөвийг дөрөв болон долдугаар сард гаргасан. Дөрөвдүгээр сард гаргах үед дэлхий даяараа шокын байдалтай, бүх зүйл тодорхойгүй байсан учраас таамаг муу байсан. Харин одоо бол дэлхий даяар new normal буюу ирэх жилийн өдий хүртэл коронавирустэйгээ амьдрах нь тодорхой болсон учраас шинэ стандарттайгаар эдийн засгаа зүтгүүлж эхэллээ. Буцаад хэрэглээ сайжирч, худалдаа идэвхжиж, эдийн засгийн үзүүлэлтүүд сэргэж байна.

Ирэх онд эдийн засгийн өсөлтийг ►

► нэлээд өөдрөгөөр тооцолсныг 2021-2022 оны төсвийн хүрээний мэдэгдлээс харсан байх. Тэгэхээр бидэнд боломж бололцоо байгаа. Оны эхний хагас жилд төсвийн бүх үзүүлэлт муу гарсан учраас энэ хагас жилд байдал нэлээд амаргүй байх болов уу. Бид дөрөвдүгээр сард тооцохдоо энэ онд эдийн засгийн өсөлт ядаж нэг хувь байх болов уу, арай ч хасах руу орохгүй байх гэж үзэж байсан. Харин долдугаар сард ОУВС эдийн засгийн төлөвөө шинэчлэхдээ бүх улс орны эдийн засгийн өсөлтийг бууруулсан.

Гэхдээ хамгийн гайгүй үзүүлэлттэй нь манай бүс нутаг буюу БНХАУ-ын ДНБ-ийг нэг хувьтай байна гэж таамагласан. Хятад улсын эдийн засаг хамгийн хурдан сэргэж байгаа нь бидэнд үүсэж буй нөгөө нэг давуу тал юм. Манай гадаад худалдааны 90 хувь Хятадтай хийгддэг учраас энэ давлагаан дээр эдийн засаг өсөх боломж бий.

Т.Доржханд: Тодорхойгүй байдал ирэх онд ч үргэлжилнэ



(УИХ-ын гишүүн)

ДЭМБ-ын гүйцэтгэх захирлын хийсэн мэдэгдлээс цар тахлын хүндрэл хоёр жил орчим үргэлжилнэ гэж ойлгосон. Вакцин гарч баталгаажсан ч түгээлт нь дор хаяж нэг жилийн хугацаа авах юм байна. Нөхцөл байдал ийм болж байгаа тул хорио цээр тогтоох, хил гаалиа хэр удаан хаах нь мөн тодорхойгүй. Гэтэл манай Засгийн газар, Сангийн

яамныхан ирэх жилээс эдийн засаг тэлэх буюу КОВИД-19 цар тахлын нөлөө эдийн засагт V хэлбэртэй байна гэж үзэж байгаа. Миний хувьд V хэлбэртэй биш, тодорхойгүй нөхцөл байдал дахиад нэг жил үргэлжилнэ гэж үзэж байна. 2021 онд эдийн засаг сэргэнэ гэдэг эргэлзээтэй.

Монголын эдийн засаг өмнөд хөршөөс шалтгаалдаг нь үнэн. Хятадын эдийн засаг бусад том эдийн засгуудаас ганцаараа эерэг гарна гэсэн төсөөллийг олон улсын банк, санхүүгийн байгууллагууд гаргасан. Засгийн газар энэ төсөөлөлд найдаад байх шиг байна. Би бол эргэлзэж байгаа. Хятадын тэлэлтийг хязгаарлах гэсэн геополитикийн бодлого, ялангуяа АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор их өрнөж байна. Цаашдаа ч энэ чигээрээ үргэлжлэх юм бол Хятад гадагшаа чиглэсэн экспортын бодлогоо өөрчлөөд дотогшоо чиглүүлэхэд хүрнэ. Гэвч дотоодын эдийн засаг нь хөөс ихтэй байна. Тухайлбал, орон сууцны үнэ байх ёстой хэмжээнээс хэд дахин өндөр, Засгийн газрын дотоод өр нь маш их байгаа зэргээс харахад Хятадын эдийн засаг тогтвортой хадгалагдах уу гэдэгт “гийм” гэдэг хариулт өгч чадахгүй.

Манай улс энэ аварга эдийн засгийн нүүрснийх нь зах зээлд багахан байр суурь эзэлдэг учраас эдийн засаг тэлэх орон зай байгаа гэж манай эдийн засагчид дүгнэж байна. Гэтэл манайх төмөр замаа тавиагүй, авто замаар тээвэрлэдэг, хил гаалийн нэвтрэх чадвар, хөл хорио хэвээрээ байгаа нөхцөлд өөдрөг төсөөлөл буухгүй, экспорт нэмэгдэнэ гэж бодохгүй байна. Экспорт сайжрахгүй бол ачаалал нь манай улсын төлбөрийн тэнцэл дээр ирнэ. Өнөөдрийн байдлаар төлбөрийн тэнцэл, төсвийн аль аль нь

их хэмжээний алдагдалтай явж байна. Ирэх жил энэ байдал үргэлжилбэл ханшаа алдах эрсдэл өндөр.

Хэдийгээр манай түүхий эдийн экспортын орлогын дийлэнх нь сүүлийн хагас жилдээ орж ирдэг нь үнэн боловч нөхцөл байдал тодорхойгүй байгаа тул урьдынх шигээ бодож, өөдрөг төлөвлөж болохгүй. Одоохондоо хилээр гарч байгаа нүүрс тээврийн машин хоёр мянгыг давсан ч энэ чигээрээ үргэлжилнэ гэдэг нь хэтэрхий өөдрөг төсөөлөл байх.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлд ирэх онд эдийн засгийн өсөлт долоон хувь байна гэж тусгасан. Төсөв ийм их алдагдалтай, төлөвлөсөн орлогоо алдсан, санхүүгийн салбарын реформууд гацсан, мөн сонгуультай жилүүд тохиож байхад эдийн засаг долоон хувиар тэлнэ гэдэг худлаа. Үнэнийг хэлэхэд энэ оны төсвөө сонгуульд зориулаад оны эхэнд тодотгоогүй шүү дээ. Ээлжит бус чуулганаар тодотгосон ч өнөө л сумын төвийн 1-2 км зам, конторын барилга, соёлын төв гэх мэт үр ашиггүй зардлуудад санхүүжилт гаргасан. Би үүнийг орон нутгийн сонгуульд зориулсан тодотгол гэж харж байгаа. Ирэх жил ерөнхийлөгчийн сонгууль болно. Сонгуулийн ачаалал бас л төсөвт ирнэ. Тэгэхээр цаашдаа экспортоо нэмэгдүүлж, гаднын хөрөнгө оруулалтыг татаж, хөрөнгийн дотогшлох урсгал бий болж чадах эсэх нь тодорхойгүй болж байгаа юм.

Халдварыг дотооддоо алдаагүй нь үнэн юм бол бизнесүүдэд саад болсон хөл хориог цуцлах ёстой. Гэтэл есдүгээр сарын 15 хүртэл хорио цээрийн дэглэм хэвээрээ л байна. Хөрөнгө, хүчээ гаднаас вирус оруулахгүй байхад хуваарилаад явах нь зүйтэй ч дотооддоо ►

► бизнесийнхээ үйл ажиллагааг нээж, ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчдээ дэмжих хэрэгтэй байна. Харамсалтай нь төсөвт энэ чиглэлд зарцуулахаар төлөвлөсөн нэг ч зүйл алга. Энэ хүнд цаг үед иргэдийн хоол, орлогыг хамгаалах нь зүйтэй ч ажлын байрыг нь давхар хамгаалах учиртай. Бизнесийн үйл ажиллагааг сэргээж, идэвхжүүлэхэд тодорхой зохицуулалтууд төсвийн бодлогоор хийх боломж бий. Энэ боломжийг ашиглахын оронд өнөөх л үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгээд байна шүү дээ.

Ирэх таван жилд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөрөнгө оруулалт хэлбэрээр 50 орчим их наяд төгрөг тусгасан. Гэтэл Монгол Улсын нэг жилийн төсвийн бодит хэмжээ 10 их наяд орчим төгрөг. Үүний төлөө аймаг аймгийн төлөөлүүд тойрогтоо ажил гүйцэтгэх ТЭЗҮ суулгаж авбал болоо гээд л үзэлцэж байна. Өөрөөр хэлбэл, 2024 онд дахин сонгогдох нь л чухал. Түүнээс биш эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа, ер нь цаашдаа яахыг бодож байгаа төрийн түшээ ховор байна даа. Тэгэхээр манай эдийн засаг хөгжихгүй байгаа эмзэг цэг нь сонгуулийн тогтолцоо гэсэн үг. Өмнө нь 76 тийшээ мөнгөний эх үүсвэр татах уралдаан явдаг байсан бол одоо 21 аймагт татах уралдаан өрнөж байна.

Уг нь Монгол Улс нэг тойрог болвол үр ашиггүй хөрөнгө оруулалт татаж, зулгаадаг нь багасна. Үндсэн хуульд тусгасан сонгуулийн системээ өөрчлөх ёстой. Гэвч найман жилийн хугацаанд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж болохгүй. Тиймээс ирэх найман жилийн хугацаанд эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа бодитой ажил хэрэг болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тойргоо эдийн засгийн

бүсчлэлдээ зориулаад таван том тойрог болгочихвол хөрөнгө оруулалт, төслүүдээ үр ашгаар нь эрэмбэлж сурна. Ингэснээр эдийн засгаа урагшлуулах нэг бодит алхам болох юм.

3.Нарантуяа: Эдийн засаг ойрын 1-2 жилд мэдэгдэхүйц тэлэхгүй



(УИХ-ын гишүүн асан, эдийн засагч)

КОВИД-19 цар тахлын нөлөө хэзээ дуусах нь тодорхойгүй байгаа учраас ойрын 1-2 жилдээ эдийн засаг мэдэгдэхүйц тэлнэ гэж үзэхгүй байна. Одоогийн нөхцөл байдал энэ он дуустал үргэлжлэх нь тодорхой. Цаашлаад КОВИД-19-ийн эсрэг вакцин, эм, эмчилгээний үр дүнгээс ирэх оны хэдийд хил гаалийн хорио цээрийг цуцлах эсэх шалтгаална. Тиймээс Монгол Улсын эдийн засагт учирч болзошгүй эрсдэлүүдийг байж болох хамгийн бага түвшинд байлгахын тулд төсөв, мөнгөний маш ухаалаг бодлого хэрэгтэй.

Төсвийн хэт үрэлгэн байдал, төрийн аппаратыг данхайлгасан хэрэггүй зардлуудаа хамгийн боломжтой доод хэмжээнд танах, тэвчиж болох бүх зардлаа хасах хэрэгтэй. 2021 оны улсын төсвийг төлөвлөж боловсруулахдаа ч ийм зарчим баримтлаасай. Хөдөө хээр, энд тэнд хэн ч ашиглахгүй, ашиг тусаа өгөх нь тодорхойгүй зүйлд мөнгө хөрөнгөө үрээд байх цаг үе биш. Хамгийн гол нь ард иргэдийнхээ амьжиргаа, орлогын түвшинг бууруулахгүй байхад л анхаарах ёстой.

Хувийн секторт ялангуяа, худалдаа, үйлчилгээ, зочид буудал, тээврийн салбарт ажилт явагдаж байна. Тиймээс хэт агшаахгүйн тулд төсөв, мөнгөний оновчтой бодлого хэрэгтэй. Засгийн газар хэрэглээгээ танах хэрэгтэй. Агентлаг шинээр байгуулах, урсгал зардлуудад мөнгө төсөвлөх хэрэггүй. Ингэж байж өр зээл бага тавьж, ойрын 1-2 жилийн эдийн засгийн бодлогыг явуулах хэрэгтэй байх.

Мэдээж байдал энэ чигээрээ байхгүй, сайхан цаг ирнэ. Тэр цагт эдийн засгийг тэлэх гол салбарууддаа бэлтгэл хангах талаар давхар бодож, төлөвлөх хэрэгтэй. Тухайлбал, экспортын гол үйлдвэрүүдээ одооноос бэлдэх, уул уурхайн салбартаа өөрчлөлт, шинэчлэлт хийх хэрэгтэй. Байгаль орчноор түрээ барьж төр засаг гэлтгүй ард иргэд хаа хаанаа улстөржсөөр уул уурхайн салбарынхаа амыг боочихлоо. Уул уурхайн салбар нь орчин үеийн шинэ технологи нэвтрүүлсэн, хамгийн үр ашигтай, үр дүнтэй менежменттэй, иргэдэд хүртээлтэй баялагийн засаглал бүхий салбар болж байж улс орны хөгжлийг авч явна. Тэгэхээр энэ салбарыг дэмжсэн дэд бүтцүүдээ одооноос хийх хэрэгтэй. Түүхий эд, бүтээгдэхүүн зөөх төмөр зам барьж байгаа нь сүүлийн 10 жилд хийж буй хамгийн зөв зүйтэй ажил. Үүнээс гадна эрчим хүчний хангамж, хил гаалийн нэвтрүүлэх чадварыг сайжруулах гэх мэт өнгөрсөн гурван жилд ярьсан ажлаа энэ Засгийн газар хийх хэрэгтэй.

Маш чухал өөр нэг зүйл бол хүний нөөцийг дэмжиж, хүнээ бодсон бодлогоор ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулбал ядуурал тэр хэмжээгээр буурна. Тиймээс өөрсдөдөө ажлын байр бий болгох чадавхыг иргэддээ суулгах тал дээр дорвитой алхам хийх хэрэгтэй. ►

► Сүүлийн үед эдийн засгийн гол судас болсон банк санхүүгийн салбар руу хэт түрэмгийлэн дайрч буйд би их эмзэглэж байна. Өнөөг хүртэл төрөөс ямар ч дэмжлэггүй хөгжсөөр энэ түвшинд хүрсэн салбар. Гэтэл ингэж оролдож байгаад бүх банкаа дампууруулчих вий гэсэн айдас, болгоомжлол надад байна. Цар тахлын дараах сэргэлтэд банк санхүүгийн салбар чухал үүрэгтэй.

Н.Энхбаяр: Хятад улс нүүрсний импортын эрэлтээ бууруулж болзошгүй



(Эдийн засагч)

Коронавирусийн халдварын тархалт, дэлхий даяар ханган нийлүүлэлтийн сүлжээ тасалдсаны улмаас улс орнуудын болон дэлхийн эдийн засаг 2020 онд ихээхэн саарах таамаглалыг Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллага гаргаад байгаа билээ.

2020 оны наймдугаар сарын 27-ны байдлаар халдварын нийт тохиолдлын тоо 24.3 саяд хүрсэн. Энэ оныг дуустал коронавирсийн вакцинжуулалт бараг эхэлж амжихгүй, халдварын тархалт зарим улс оронд өндөр хэвээр байгаа тул оны эцэс гэхэд халдварын нийт тохиолдлын тоо 50 саяг давах өндөр магадлалтай.

ДЭМБ-ын Гүйцэтгэх захирал Теодрос Аданом “Коронавирусийн халдварын тархалтыг зогсоохын тулд дахиад нэг жилийн хугацаа хэрэгтэй. Энэ хугацаанд улс орнууд тодорхой арга хэмжээ авч,

вакцинжуулалт хийснээр халдварын тархалтыг зогсоож чадна гэж найдаж байгаа”-гаа илэрхийлжээ. Эрдэм шинжилгээний байгууллагуудын таамаглалаар ч халдварын тархалт намжих цаг хугацаа болоогүй байна.

Одоогоор клиникийн гуравдугаар шатны туршилтад 6-7 вакцин байгаа гэж ДЭМБ-аас мэдэгдсэн. Өндөр хөгжилтэй улс орнууд эдгээр вакциныг бэлэн болмогц худалдан авахаар урьдчилан захиалга өгч, төлбөрөө төлсөн. Үүнээс үзвэл ирэх оны эхээр вакциныг ДЭМБ албан ёсоор бүртгэж авлаа гэж үзэхэд өндөр хөгжилтэй орнууд 2021 оны эхний хоёр улиралд вакцинжуулалтаа хийх боломжтой. Үүний дараа төлбөрийн чадвартай, хөгжиж байгаа орнуудад вакцинжуулалт хийгдэнэ. Цаг хугацааны хувьд 2021 оны 5-7 дугаар сард вакцинжуулалт хийгдэх болов уу.

Хятад, Энэтхэг зэрэг нэг тэрбум давсан хүн амтай улс оронд вакцинжуулалт хийж дуусахад багагүй цаг хугацаа, хүч хөрөнгө шаардагдана. Монгол Улсын хувьд гаднаас вакцин худалдан авах боломж 2021 оны 7-8 дугаар сарын орчимд гарч, вакцинжуулах үйл явц 8-9 дугаар сард хийгдэх магадлалтай.

Ази, Европ, Америк тивийн орнуудад халдварын тархалт өөр өөр байгаа тул дэлхий даяар нэгэн зэрэг намжихгүй, хязгаарлах арга хэмжээг илүү сайн авч хэрэгжүүлж байгаа Ази, Европын орнуудад тархалт хамгийн эхэлж намжих төлөвтэй байна. Иймд Ази, Европ хоорондын нислэг болон зорчигч хөдөлгөөн энэ оны эцсээр аажмаар нээгдэх магадлалтай. Монгол Улсын хувьд дотооддоо халдварыг тархаалгүй өдий хүргэж чадсан амжилттай байгаа тул энэхүү амжилтаа бататгах, цаашид үүсэх эрсдэлээс сэргийлэхийн тулд гадаадын аялал жуулчлалыг

нэлээд хожуу, 2021 оны хоёрдугаар хагаст л нээж болзошгүй байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Европ, Хойд Америкийн өндөр хөгжилтэй улс орнуудын эдийн засаг ихээхэн хэмжээгээр саарлаа.

ОУВС-аас зургадугаар сард танилцуулсан “Дэлхийн эдийн засгийн тойм”-д дурдсанаас үзвэл 2020 онд дэлхийн эдийн засаг 4.9 хувиар агшиж, харин 2021 онд 5.4 хувиар өсөх магадлалтай байна. Олон улсын байгууллагуудын таамаглал, судалгаанаас үзвэл өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг ирэх оны эхний хагас жилд тогтворжиж, хоёрдугаар хагаст аажим сэргэх хандлагатай.

Хятадын эдийн засаг энэ онд нэг хувийн өсөлттэй байх болов уу гэж олон улсын судлаачид үзэж байгаа. Монгол Улсын эдийн засаг 2020 онд -1.0 хувийн бууралттай байна гэсэн таамаглалыг Сангийн яам боловсруулжээ. Бүс нутгийн эдийн засаг, худалдаа хэзээ сэргэхээс хамаарч манай улсын эдийн засгийн өсөлт 2021 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр тогтворжих буюу эерэг үзүүлэлттэй гарах магадлалтай. Гэхдээ одоогоор манай улсад хэрэгжүүлж байгаа томоохон төсөл цөөн, хэрэгжиж байгаа төслүүд гол төлөв 2023-2024 онд л ашиглалтад орж, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулна.

2021 оны тухайд Оюутолгой, Эрдэнэт, Тавантолгойн ордоос гаргах экспортын түүхий эдийн тоо хэмжээ, үнийн төлөв байдлаас эдийн засгийн сэргэх цар хүрээ, өсөлтийн хувь хэмжээ ихээхэн хамаарах болно.

Одоогоор Гашуунсухайтын боомтын хүчин чадлыг өргөтгөх арга хэмжээ хангалтгүй байгаа тул 2021 онд нүүрсний экспорт огцом нэмэгдэнэ гэж найдахгүй байна. Харин Хятад дотоодын эрэлтээ дэмжих арга хэмжээ авч, өмнө ►

► хаагдсан нүүрсний уурхайнуудын үйл ажиллагааг олноор сэргээсэн нь тус улсын нүүрсний импортын эрэлтийг бууруулж болзошгүй байна. Иймд дээр дурдсан нөхцөл байдалд үндэслэж, 2021 оны манай улсын эдийн засгийн өсөлт 4-5 хувийн орчимд гарна гэсэн таамаглалтай байна.

Ирэх онд аялал жуулчлал, барилга угсралтын салбарын сэргэлт удаан, хүндрэл бэрхшээл тулгарсан хэвээр байх магадлал өндөр гэж үзэж байна.

Б.Түвшинтулга: Цар тахлыг дотооддоо алдаагүй давуу талаа ашиглаж чадахгүй байна



(Дэлхийн банкны зөвлөх, эдийн засгийн ухааны доктор)

Энэ удаагийн хямралын дараах эдийн засгийн тэлэлтийг тооцоолоход учирч буй хамгийн том бэрхшээл бол хямралын үргэлжлэх хугацаа. Зарим оронд КОВИД-19 халдвар багассан ч хөл хорио үргэлжилж байгаа бол цар тахал буурах нь бүү хэл дахин ихсэж, хөл хорио илүү урт удаан үргэлжилж байгаа орнууд ч байна. Ийм учраас дэлхийн эдийн засгийн сэргэлт өмнө тооцсоноос илүү удаашралтай байх төлөвтэй.

ОУВС дэлхийн эдийн засаг 2021 оноос тэлж эхлэнэ гэж мэдэгдсэн. Гэвч 2020 оны эдийн засгийн уналт өмнө тооцсоноос илүү хүчтэй байх нь тодорхой боллоо. Энэ оны эхний улиралд гаргасан тооцоогоор дэлхийн эдийн засаг гурван хувиар агших байсан бол хагас жилийн төгсгөлд тооцоо өөрчлөгдөж, энэ ондоо 4.9 хувиар унах төлөв гарсан. Харин

2021 оноос эдийн засгийн уналт тогтворжиж, 5.4 хувь өсөх чиглэлтэй гарч байна. Гэхдээ энэ бүхэн КОВИД-19 цар тахал тогтворжино гэсэн асар том таамаглал дээр үндэслэж гаргасан тоонууд. Одоогийн байдлаар КОВИД-19-ийн эсрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн вакцин гараагүй байгаа нь сэргэлтийн хугацааг тодорхойгүй болгож байна.

Манай улсын хувьд эдийн засаг энэ онд -1.9 хувьтай гарч, 2021 онд 4.7 хувиар тэлэх төлөвтэй байгаа. Бид хямралыг даван туулж, тэлэлтэнд хурдтай хүрч чадах эсэх нь юуны өмнө уналттай үед хэрэгжүүлж буй төсвийн бодлого, экспортын орлого, олон улсад КОВИД-19-ийн тархалт хэзээ тогтворжихтой холбоотой.

Өмнө нь бидэнд тулгарсан хямралууд олон улсад үүссэн санхүүгийн зах зээл, эдийн засаг, эрдсийн үнийн хэлбэлзэлтэй уялдаж байсан бол энэ удаад КОВИД-19 цар тахлаас улбаалсан эдийн засгийн хямралтай тулгарч байна. Энэ хямрал манайд бусад улсаас маш ондоогоор явагдаж байгаа. Монгол Улс халдварыг дотооддоо тогтоож чадсан боловч энэ давуу талаа ашиглаж чадахгүй, эдийн засаг нь доройтож байна. Хэрвээ бид төсвийн зөв бодлого явуулж чадвал дотооддоо эдийн засгийн хүндрэлээ тогтоох боломж байсан. Гэвч сонгуультай жил таарснаас төсвийн бодлого ажилгүйдлийг бууруулах хөтөлбөр, жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр гэсэн хоёр чухал асуудлыг тоохгүй өнгөрлөө. 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталж буй атлаа байшин барилга барихад 3.4 их наяд төгрөг зарцуулахаар оруулсан. Энэ жагсаалтанд сумын төвийн спорт цогцолбор, тамгын газрын байрны өргөтгөл зуу, зуугаараа байгаа. Өөрөөр хэлбэл, 4.8 их наяд төгрөгийн алдагдал батлана

гэдэг нь Засгийн газар яаж ийгээд мөнгө босгоод, боломж үүсгээд байгаа атлаа энэ нөөц бололцоогоо нийгмийн эмзэг давхарга, эдийн засгаа сэргээх бодлогод зориулаагүйг, энэ нь эргээд эдийн засгийн уналтад нөлөөлж байгааг харуулж байна.

Манай улсын валютын орлогын ихэнх нь дан ганц уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай. Үнэт металлын үнэ өсөхөд манай валютын орлого нэмэгдэж, эдийн засаг тэлдэг. Буурахад нь эдийн засаг хямардаг. Гэтэл бид 30 жилийн турш эдийн засгаа солонгоруулж чадаагүй, ядаж хөдөө аж ахуй, аялал жуулчлалаа хөгжүүлж чадаагүйгээс зөвхөн Хятад улсад уул уурхайн бүтээгдэхүүн зарж амьдарч ирлээ. Хятадын эдийн засгийн өсөлтийн хурд ба хоёр улсын улс төрийн харилцаанаас манай экспортын орлого шууд хамаарна. Хэрвээ энэ хоёр үзүүлэлт тогтвортой байвал дотоодын эдийн засагт эерэг нөлөөтэй.

2020 онд валютын орлого огцом буурсан ч, манай улсын гаднаас авч буй худалдан авалт ердөө буураагүй. Тиймээс маш их хэмжээний доллар гадагшаа гарч байгаа. Энэ байдал удаан үргэлжилбэл төгрөгийн ханш хүчтэй унах эрсдэлтэй байна. Бид дан ганц уул уурхайдаа бүх найдвараа тавьдаг, зэрэгцээд төсвийн буруу бодлого барьдагтай энэ бүхэн холбоотой. Уул уурхайн хажуугаар бусад салбараа хөгжүүлснээр валютын орлогын тэнцэл сайжирч, ажлын байр эрс ихэснэ.

Харин дэлхийн хэмжээнд цар тахлын нөхцөл байдал тодорхойгүй байгаагаас манай улсад мөн тодорхойгүй хүчин зүйлүүд үүсэж байгаа. Вакцинжуулалт эхлэхэд нэг жил, бүрэн тараахад 1-2 жил, нийтдээ 2-3 жилийн дараа тогтворжино гэсэн олон улсын таамаг бий. Айдас бүрэн алга болж байж хөл хорио тавигдана, ►

► мөн түүнийг дагаад эдийн засгийн тэлэлт эхлэнэ.

Бүх хямралын дараа эдийн засгийн хөдөлгөөн ихэсдэг тул макро том тоонууд бүгд өсөлттэй гардаг. Гэхдээ том тоонуудыг хараад бид тайвширч болохгүй. Нийгмийн дунд болон эмзэг давхарга энэхүү тэлэлтээс ямар хэмжээгээр хүртэх нь Засгийн газрын хэрэгжүүлэх бодлогоос шууд хамаардаг. Хөгжингүй орнуудын Засгийн газар хямралын дараа эмзэг ба дунд давхаргад хүчтэй эерэг нөлөө бий болгохын тулд ажиллах хүчний чадвар ба эдийн засгийн төрөлжилтийг ихээхэн дэмждэг. Харин манай улс ганц уул уурхайгаас хамаардаг тул том дүр зургаараа эдийн засаг тэлж байгаа мэт харагдавч эмзэг болон дундаж давхаргынхны амьдралын түвшин сайжрахгүй үлддэг. Энгийн жишээ хэлэхэд, Монголын ДНБ 1993 онд 768 сая ам.доллараас 2019 онд 13.6 тэрбум ам.доллар болж, 18 дахин өссөн. Гэтэл Дэлхийн Банкны тооцоогоор 1995 онд ядуурлын түвшин 36 хувь байсан бол 2019 онд 29 хувьтай болсон. Өөрөөр хэлбэл, ядуурлын түвшин яльгүй буурсан болохоос бараг өөрчлөгдөөгүй. Эдийн засгийн тэлэлт ядуурал бууралттай огт хамаагүй гэдгийг энэ энгийн жишээ өгүүлж байна.

1990-ээд оноос хойш манай эдийн засаг хөгжиж, төрөлжөөгүй, харин бидний гадагшаа зөөдөг уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ л ихэссэн. Энэ удаагийн хямрал мөн адил. КОВИД-19-ийн вакцин гарлаа, эдийн засаг тэллээ гээд манай уул уурхайн бүтээгдэхүүний экспорт ихсэж, эдийн засгийн тоонууд сайжирна, гэвч ажилгүйдэл, ядуурлын түвшин маш өндөр хэвээр байх дүр зурагтай байна. Бодлогын түвшинд ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг багасгах

арга хэмжээнүүдээ ядаж төсөвтөө суулгахаас нааш эмзэг ба дунд давхаргын иргэд энэ хямралд удаан хугацаанд нэрвэгдэх магадлал өндөр.

Тиймээс эдийн засгийн тэлэлтэд бэлдэхийн тулд эдийн засгийн бусад хөшүүрэг салбарууд, жижиг дунд бизнесүүдээ дэмжсэн бодлого явуулах ёстой. Тэгж байж ажлын байрны тоо нэмэгдэж, иргэдийн дунд ядуурал багасна.

Б.Мөнхсоёл: Уян хатан арга хэмжээ авбал эдийн засаг гүн хямралд орохоос сэргийлнэ



(Эдийн засагч, судлаач)

Эдийн засаг тэлэх эсэх нь хэд хэдэн зүйлээс хамаарна. Эхний бөгөөд илүү хялбар хувилбар бол цар тахлын хоёр дахь давлагаанаас сэргийлэн зөвхөн эрүүл мэндээ хамгаалсан бодлого барьж, өмнөх шиг эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг гүн хорьсон хөл хориог урт хугацаагаар үргэлжлүүлэх. Хэрэв энэ замыг сонговол манай эдийн засгийн тэлэлт ойрын нэгээс хоёр жилээс наашгүй байх.

Удаах хувилбар бол хөл хорионы хатуу дэглэм тогтоосноос дотооддоо вирус алдаагүй нь амжилт гэж дүгнэж байгаа. Гэтэл хилээ нээсэн Европын орнууд, өмнөд хөрш Монгол Улсын иргэдийг оруулахгүй байх шийдвэр гаргасан шалтгаан юу вэ? Манай улсад эргэлзэж байгаа хэрэг үү. Иргэдээ эх орондоо ирэхийг, гадагшаа зорчихыг нь хориглож, хилээ гэнэт хааж, экспортоо зогсоох гэх мэт нарийн бодлого, оюун ухаан

шаардахгүй, механик, автомат арга хэмжээ аваад байвал манай эдийн засгийн тэлэлт жил хагас байтугай урт хугацаа авна.

Тиймээс цар тахлын үеийн бодлого, арга хэмжээ өмнөх шиг биш, харин вирус тархах магадлалтай хэсэг хаана байгааг тогтоож, түүнд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж, хувийн салбараа дэмжиж, илүү уян хатан ажиллавал нэг талаар эрүүл мэндийн эрсдэлийг хааж, нөгөө талаар бизнес, эдийн засгийн үйл ажиллагааг гүн хямралд орохоос сэргийлж чадна. Хэрэв ийм бодлого хэрэгжүүлж чадвал магадгүй ойрын нэг жилд одоогийнхоос эрчтэй ахиц гарах боломжтой. Төсвийн хүрээний мэдэгдэлд одоогийн байдлаар 9.7 хувийн агшилттай байгаа эдийн засгийг ирэх онуудад 7.2, 4.4 хувиар тэлж, ДНБ-ий 12.5 хувьтай тэнцэж байгаа төсвийн алдагдал эрс буурна гэж тооцсон байна.

Гэтэл КОВИД-19 гарахаас өмнөх эдийн засгийн нөхцөл байдлаа аваад үзвэл, Засгийн газрын өр өндөр, төсвийн алдагдал сүүлийн жилүүдэд тэлсээр ирсэн. Өөрөөр хэлбэл, бид төсөв, санхүү нөөц хөрөнгийн маш их хомсдолтой явж ирлээ. Нөөц боломж ийм хязгаарлагдмал нөхцөлд эдийн засгаа тэлэх буюу мөчлөг сөрсөн бодлого явуулах боломж хомс. 2021-2024 онд Засгийн газрын барагдуулах ёстой бондын өр 2.9 тэрбум ам.доллар. Харамсалтай нь, эргээд харахад бидэнд арвижуулж хуримтлуулсан, зөв хөрөнгө оруулалт хийсэн төсөл, түүнээсээ авч буй өгөөж бараг л алга. Тийм учраас дахиад л олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгох шаардлагатай болж байна. Нэг ёсондоо өрөөс өр дамжсан ийм чөтгөрийн тойргоосоо гарч чадахгүй нь.

Зөвхөн дотоодын эдийн засагчид гэлтгүй олон улсын санхүү, эдийн ►

► засгийн шинжээчдийн анхааруулж буйгаар Монгол Улсын нөхцөл байдал 2017 оныхоос харьцангуй сайжирсан ч шийдэх ёстой хэд хэдэн асуудал байгаагийн нэг нь банк, санхүүгийн салбарын реформ. ОУВС 2017 онд манай улсад Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ байгуулсан гэрээнд банк, санхүүгийн салбартаа реформ хийх тухай заалт оруулсан. Манай улс энэ үүргээ биелүүлээгүй учраас КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засагт үүссэн хүндрэлийг даван туулах дараагийн хөтөлбөрийг ОУВС оруулж ирэх эсэхэд тээнэгэлзэж байна. Тиймээс банк, санхүүгийн реформ зэрэг далд биш, иргэн бүрт хамааралтай энэ мэт асуудлыг зөв бөгөөд эрүүлээр шийдэх шаардлага бий.

Хэрэв үүнийг хийж чадвал олон улсын зах зээлээс өртөг зардал багатай хөрөнгө босгох боломж нэмэгдэнэ. Эдийн засгийн өсөлт өндөр үед босгосон “Чингис” бондын хүүгийн өгөөж 4.125 хувь байсан бол хямралтай үедээ босгосон “Мазаалай” бондынх 10.875 хувь байсан. Тиймээс энэ цаг үед бид аль болох өртөг багатай байлгахад анхаарахгүй бол өндөр дүнтэй үндсэн өр зээл, хүүгийн төлбөрөөс гадна ханшаас шалтгаалан ам.доллараар авсан тул давхар зардлын эрсдэл өндөр байна.

Манай улсын гадаад валютын нөөц дөрвөн тэрбум ам.доллар руу дөхөж байсан ч одоо эргэж багасаад 3.6 тэрбум ам.доллар болсон. Цаашид ч багасах нөхцөл бий. Ийм үндсэн гурван шалтгаанаар манай улсын төгрөгөөр илэрхийлсэн өр зээлийн хэмжээ өсч байна. Харин суурь шалтгаан нь төсвөө сахилга баттай, оновчтой зарцуулж чадахгүй, мөнгө, төсвийн бодлогоо төсөвтэй сайн уялдуулж чадахгүй байгаагаар

холбоотой. Тийм учраас эдийн засгийн үндсэн нөхцөл байдал, мөн тооцоогүй байсан цар тахал, өрх гэр, аж ахуйн нэгж, өрх гэрийн хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагаа царцанги байдалд орсон зэрэгт нарийн шинжилгээ хийж энэ цаг үед төсөв, мөнгөний оновчтой бодлого хэрэгжүүлж, банк санхүүгийн шинэчлэл зэрэг асуудлыг цогцоор нь шийдэж байж эдийн засгийн тэлэлтийн тухай илүү сайн ярина.

Урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх замаар бид хүндрэлтэй цаг үед хэсэг хугацаанд тэсдэг ч эргээд харахад эдийн засаг маань эмзэг хэвээрээ л байдаг. Монгол Улсын эдийн засаг, экспортын салбар дорвитой төрөлжиж чадаагүй, уул уурхай, олборлох салбар нь өмнөд хөршийн эрэлт, худалдан татан авалт, түүхий эдийн үнээс ихээхэн хамаардаг. Үнэ өндөр, эрэлт өсөлттэй үед валютын урсгал нэмэгддэг, доллар орж ирдэг, үгүй бол урууддаг. Тиймээс эдийн засгаа тэлэхийн тулд бид зөв бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Б.Дөлгөөн: Алсаа харсан бодлого явуулбал нүүрсний экспорт боломжийн байна



(Эдийн засагч)

Цар тахлын эсрэг хөл хорионы улмаас аялал жуулчлал, уул уурхай, цаашлаад жижиглэн худалдааны салбарууд уналтад орсон нь эдийн засаг уруудахад гол нөлөө үзүүлсэн. Том утгаараа олон нийтийн хэрэглээ болон Засгийн газрын зарцуулалт нэмэгдэж, экспорт нэлээд уналттай

байна. Экспортын уналт Хятадын эдийн засагтай холбоотой хэдий ч манай тал цар тахлаас сэргийлсэн хөл хорио тогтоож, хилээ хаасан нь хамгийн гол нөлөө үзүүлсэн. Тухайн үед хөл хорио тогтооход Хятадын талаас нүүрс авахгүй гэж мэдэгдээгүй. Манай тал л хилээ шууд хаасан, гэтэл Австралийн нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэн. Хэрэв эрх баригчид алсаа харсан бодлого явуулж чадвал ирэх онд нүүрсний экспорт боломжийн хэмжээнд байна гэсэн хүлээлт бий.

Дунд болон урт хугацаанд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг авч үзэхгүйгээр арга хэмжээ аваад байна. Төсвийн тодотголыг харахад 2021 онд эдийн засгийг маш өөдрөгөөр буюу ДНБ 7.2 хувиар өснө гэж тооцоолжээ. Олон улсын байгууллагуудын төсөөлөл 4.7-7 хувь байгаа. Эдгээр тооцоолол бүгд таамаглалд суурилдаг. Таамаглалыг КОВИД-19 цар тахлын хоёр дахь давалгаа гарахгүй, мөн вакцин ойрын хугацаанд буюу жилийн дотор гарна гэх мэт хэд хэдэн төсөөлөлд тулгуурлан хийдэг. Хэрэв хоёр дахь давалгаа гарвал ирэх онд эдийн засгийн өсөлт бидний төсөөлснөөс хоёр дахин буурч магадгүй, бүр хасах түвшинд ч хүрэх эрсдэлтэй. Энэ бүх эрсдэлийг давхар тооцоолж, эрсдэл удирдах нөөц бололцоогоо бүрдүүлж буй эсэх нь өнөөдөр бид өөрсдөдөө, ялангуяа Засгийн газарт тавих чухал асуулт юм.

Дэлхийн банк болон ОУВ анх гаргасан дэлхийн эдийн засгийн төлөв цар тахлын нөхцөл байдалтай уялдаж өөрчлөгдсөөр байгаа. Тэгэхээр өнөөдөр гаргасан тэрхүү таамаглал аравдугаар сард өөрчлөгдөхийг үгүйсгэхгүй учраас Монгол Улсын хувьд ч гэсэн ирэх оны төсөөллөө өөрчлөх шаардлага тулгарч мэдэх юм. Цар тахал дэгдсэн энэ цаг үед ►

► тодорхойгүй байдал бүр л нэмэгдсэн. Энгийн үед тодорхойгүй байдал нэмэх, хасах 1-2 хувьд хэлбэлздэг бол одоо интервал нь өсөж байна гэсэн үг. Энэ бол бүгдийг өөдрөгөөр бодох нь зөв хэдий ч энэ өвөл, ирэх жил хамгийн муу тохиолдолд ч гэсэн бэлтгэлтэй байх түвшинд тооцооллоо хийх ёстойг илтгэж буй дохио.

Хэдийгээр өмнөд хөрш цар тахлын голомт боловч тус улсын Засгийн газар КОВИД-19-ийн хоёр дахь давлагаа гарахад мужаар нь, хотоор нь хөл хорио тогтоож, өмнөхөөс илүү хурдан арга хэмжээ авч чадах байх. Тухайлбал, Бээжингийн Шинфиди бөөний худалдааны төвд халдварын тохиолдол илрэхэд шууд хавьталд орсон 3-4, шууд бус хавьталд орсон 20 мянган хүнийг илрүүлж, хөл хорио тогтоож, шинжилгээ хийсэн зэргээс харвал коронавирус анх гарч байсан үетэй харьцуулахад хариу арга хэмжээний чадавх илт сайжирсан байна. Тэгтэл бид бүх газраа хаахаас өөр ямар ч арга хэмжээ авахгүй байна. Ялангуяа сэжигтэй тохиолдлуудыг илрүүлэх ажил болхи байна.

Монголд бараг хүн бүр ухаалаг утастай. Тусгай апп гаргаад хавьталд орсон хүмүүсийн датаг цуглуулдаг, хүн бүр тэрхүү апп-ийг ашигладаг, дотооддоо тархалтыг алдлаа гэхэд зардалгүй, цаг алдалгүй илрүүлэхэд ямар арга хэмжээ авах талаар өнөөдрийг хүртэл юу ч хийгээгүй байна. Мөн гадаадаас иргэдээ татахад сард 2-3 мянгаар л хязгаарлаж байна. Бүхэл бүтэн найман сарын хугацаа өнгөрчихөөд байхад хариу арга хэмжээний хурд ийм л байна. Хэрэв улирлын томуу дэгдвэл яах вэ? Өнгөрсөн хугацаанд гэрийн даалгавраа хэр хэмжээнд хийснийг Засгийн газраас бид асуух хэрэгтэй.

Бид Хятад шиг шуурхай арга

хэмжээ авч чадаж байвал бүхнийг хааж, хориод байх шаардлага эдийн засаг талаасаа харагдахгүй байна. Эрх баригчид эдийн засгаа золиослоод эрүүл мэндээ хамгаалж байгаа нь хамгийн муйхар арга. Бэлтгэлгүй байсан бол ийм арга хэмжээ авах ёстой.

Дэлхий нийтээр эдийн засгаа золиослохгүйгээр эрүүл мэнд, эдийн засгаа хамтад нь авч явах боломжийг эрэлхийлж, арга хэмжээгээ чиглүүлж байгаа. Дотооддоо алдсан улс орнууд ч хөл хориогоо цуцлаад эхэлсэн. Өнөөдөр Уханьд хүүхдүүд хичээлдээ сууж байхад манайхан дотооддоо алдаагүй атлаа хоёр настай хүүхдүүдийг цэцэрлэгт явуулахгүй байна. Цар тахлын эрсдэлийг бууруулах бодлого нь хүндээ огт ээлгүй байгаа юм.

Г.Ганзориг: БНХАУ-ын боломжийг ашиглаж чадвал тэлэлтийн хамгийн том ялалт болно



(Эдийн засагч, “Мандал даатгал” ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал)

Аливаа эдийн засаг унасан бол буцаад өсдөг жамтай. ОУВС-аас гаргасан таамаглалын дагуу 2020 онд дэлхийн эдийн засаг 4.9 хувиар агших бол 2021 онд 5.4 хувиар сэргэхээр харагдаж байна. Одоогийн байдлаар хоёр вакцин тодорхой хүрээнд хэрэглэгдэж болно гэж зөвшөөрөгдсөн, найман вакцин энэ шатанд орохоор хүлээгдэж байгаа. Тэгэхээр миний хувьд эдийн засгийн нөхцөл байдлын талаар харьцангуй эерэг хүлээлттэй байна. Монголын эдийн засаг ч үүнтэй адил

динамиктай байх болов уу.

Зунаас эхлэн нүүрсний экспорт нэмэгдэж байна. Түүнчлэн манай экспортын гол худалдан авагч БНХАУ-ын эдийн засаг аль хэдийнэ сэргээд эхэлчихлээ. Дэлхий даяар эдийн засаг нь агшиж байхад БНХАУ-ын эдийн засаг оны эхний хагаст 3.2 хувийн өсөлт үзүүллээ. Хятадын үйлдвэрлэл сайн сэргэж байгаа бөгөөд удахгүй хэрэглээ мөн сэргэнэ. Энэ бол манайд шинэ боломж юм. Манай улсын эдийн засгийн өсөлт, бууралтыг гадаад хүчин зүйл талаасаа нэг л зүйл удирддаг. Тэр бол таваарын ханш. Зэс, нүүрсний ханш өндөр байвал манай улс мөнгөтэй болж, өсөлт ирдэг. Энэ удаа ч тус нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Манай улсын сэргэлтийн суурь хүчин зүйл нь БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, таваарын эрэлт л байна.

Нөгөө талаас манайд дотоод асуудал их байна. Хамгийн том нь яахын аргагүй гадаад өрийн эргэн төлөлт. 2021 онд манай улс 500 сая ам.долларын бонд төлж барагдуулна. Цаашлаад улстөрчдийн элдэв поп үйлдлүүд эдийн засагт аюул тарьж байна. Гэхдээ өрийн дарамт, популизм зэрэг нь манай улсад хэвийн зүйл болж дээ. Иймд сөрөг зүйлсээс үл хамааран БНХАУ-ын өсөлтийг дагаад манай улс 2021 он гэхэд эдийн засгийн сэргэлтийг мэдрэх нь дамжиггүй.

Микро буюу компанийн түвшинд харвал дижитал шилжилтийг л онцлох хэрэгтэй болов уу. Их Британид нийт компанийн 80 хувь эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор тодорхой хэмжээний дижитал шилжилтийн төлөвлөгөө гаргасан ба 18 хувь нь бодитоор хэрэгжүүлсэн. Манай улсад ч мөн адил зайнаас ажиллах боломжийг туршиж үзлээ. Түүнчлэн автоматжуулалт, онлайн худалдаа ►

► гээд олон дэвшил гарлаа. Галт тэрэг нэгэнт хөдөлсөн тул эдгээр шилжилт сэргэлтийн үед улам л эрчимжинэ. Энэ л хамгийн том онцлог байх болов уу.

Гэвч манай улсын бий болгосон капитализмд эдийн засгийн хүртээмжтэй өсөлт бий болгоход төвөгтэй. Энэ удаагийн эдийн засгийн тэлэлтээр ч ялгаагүй байх болов уу л гэж айж байна.

Эдийн засаг тэлэх нь нэгэнт тодорхой учраас Засгийн газар юуны өмнө бодит бус амлалтуудаасаа салж, бодитой реформууд хийх шаардлагатай. Ингэж гэмээ нь хүртээмжтэй эдийн засгийн өсөлт бий болох суурь тавигдана. Жишээ нь, тэтгэврийн реформыг хийх цаг нь яахын аргагүй мөн. Бизнесийн хувьд дотоод хүчин зүйл талаасаа дижитал шилжилтээр дамжуулан бүтээмжээ нэмэгдүүлэх нь зөв байх болов уу. Гэхдээ энэ миний зөвлөх хэсэг биш. Харин гадаад хүчин зүйл талаасаа БНХАУ-аас ирэх боломжуудыг анах ёстой болов уу. Тэнд л зах зээлийн маш их боломж гарч ирнэ. Энэ бүхнээс бага ч болов бид ашиглаж чадвал дараагийн тэлэлтийн хамгийн том ялалт болох болов уу даа. Харин үүнд төр засгаас хүндрэл учруулахгүй байх, дэд бүтцийг шийдэх, эцэст нь, эрх зүйн орчноо сайжруулах гэсэн гурван том тус хүргэх хэрэгтэй.

Ж.Золжаргал: Манай улс хилээ хаасан учраас австраличууд хожсон



(Монгол нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирал)

Хятадын эдийн засаг оны эхэн үед царцсан ч гэсэн хямраагүй, нүүрсний хэрэглээ нь буураагүй. Хөл хорионоос болж нүүрсний уурхайнууд нь оны эхэнд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадаагүй, ажилчид нь цагаан сараас хойш буцаж ирэх гэж нэлээд цаг алдсан. Харин энэ хугацаанд импортоор авах кокжсон нүүрсний хэмжээгээ нэмэгдүүлсэн. Гэтэл яг энэ үеэр манай улс хилээ хаасан учраас австраличууд хожсон. Бид айхтар өвчин гарснаас сандраад тийм шийдвэр гаргасан нь одоо эргээд харахад түргэдсэн үйлдэл байж. Одоо алдаагаа засахын тулд хил дээр “Ногоон гарц” түр журам хэрэгжүүлж, хилээр гарч буй нүүрс тээврийн машины тоо нэмэгдэж байна. Хагас жилийн байдлаар 8.6 сая тонн нүүрс экспортолж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 250 сая орчим ам.долларын нүүрсний экспортын орлогоо алдсан байна.

Өмнө төлөвлөсөн шиг оны эцэс гэхэд 42 сая тонн нүүрс гаргах боломж яагаад ч байхгүй. Харин төсвийн тодотголоор 25 сая тонн болгож бууруулсан нь арай бодитой сонсогдож байна. Хэрэв болдог бол хил гаалиар нэвтрэх хугацааг уртасгаж, нүүрсний дээжийн шинжилгээг заавал улсын гэлтгүй нүүрсний ордын ойролцоо эсвэл хил орчимд байгаа итгэмжлэгдсэн хувийн лабораториудад гаалийн хяналтын байцаагчийн хяналт доор хийлгэвэл нүүрсний экспорт цаг алдалгүй явагдана. Тэгвэл 25 сая тонноос илүү нүүрс гаргах бүрэн боломжтой. Эрэлт нь байна.

Гэхдээ урьд жилүүд шиг аравдугаар сараас экспорт саарах байх. Өмнөд хөршийн кокжсон

нүүрсний хэрэглээ нь 500 сая тонн буюу дэлхийн нийт хэрэглээний тал хувь. Нийт хэрэглээнийхээ 10 гаруй хувийг л гадаадаас авдаг. Өнгөрсөн жил 74.6 сая тонн кокжсон нүүрс импортолсон нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр үзүүлэлт. Ер нь импортын дундаж хэмжээ 60-70 сая тонн байдаг. Энэ жилийн хувьд 72 сая тонныг импортлохоор төлөвлөсөн. Хэдийгээр цар тахал дэгдсэн ч гэсэн энэ тоог өөрчлөх том хэлбэлзэл эдийн засагт нь гараагүй.

КОВИД-19-өөс болоод бүтээн байгуулалт, барилга угсралт, автомашины үйлдвэрлэл саарч, гангийн хэрэглээ буурч улмаар нүүрсний үнэд нөлөөлнө гэсэн хүлээлт байсан боловч харьцангуй тогтвортой байна. Энэ нь Хятадын эдийн засаг КОВИД-19-өөс болж их хэмжээгээр агшаад байхаар биш, инерц томтой байгаагийн илрэл. Энэ эрчээрээ явсаар өвчний ард гарчихаасай гэж найдаж байна.

Нөхцөл байдал ийм байгаа учраас кокжсон нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байх болов уу. Нөгөөтээгүүр, хятадууд өөрсдөө 400 гаруй сая тонн нүүрс олборлодог учраас дотоодын уурхайнуудаа ажиллуулж байх ёстой. Нүүрсний үнэ хэт унавал уурхайнууд нь хүнд байдалд орно. Засгийн газрын зохицуулалттай зах зээл учраас гадаадаас аль болох хямд, сайн чанарын нүүрс аваад дотоодын хэрэглээгээ дэмждэг. Тиймээс ирэх онд ч кокжих нүүрсний үнэ тогтвортой байна. Энэ оны хагас жилээр авсан мэдээллээр нүүрсний үнэ жилийн дүнгээрээ өнгөрсөн жилтэй харьцуулахад 10 гаруй хувиар буурна гэж байсан. Өөрөөр хэлбэл, харьцангуй буурах хэдий ч огцом савлагаа байхгүй гэсэн үг. ■



/by Biznetwork.mn/

МОНГОЛЫН ИРГЭН БҮРД АЖЛЫН БАЙР!



4,000 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА




300,000 ХЭРЭГЛЭГЧ



20,000 АЖЛЫН ЗАР

АПП-АА ТАТААД АЖЛЫН БАЙРНЫ
ЗАРАА ОРУУЛААРАЙ



GET IT ON
Google Play



Download on the
App Store



Ярилцлага

Б.Мөнхням: Ирэх оноос мөнгөгүй, улам их өртэй, ажлын байргүй улс болох вий гэдэгт санаа зовж байна

“Mongolian Economy” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт УИХ-ын гишүүд, эдийн засагчид, салбарын төлөөллүүд төсөв, Засгийн газраас онцгой нөхцөлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар өөрсдийн санал бодол, зөвлөгөө, шүүмжээ харамгүй илэрхийллээ. Эдгээр сэдвээр бид АНУ-д “MCN Consulting Group” компанийг үүсгэн байгуулагч, эдийн засгийн шинжээч Б.Мөнхнямтай ярилцсан юм.

-Сайн байна уу. Юуны өмнө бидний урилгыг хүлээн авч, ярилцлага өгч байгаад уншигчдынхаа өмнөөс талархал илэрхийлье. Та манай уншигчдад өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулна уу?

-Сайн байна уу. Намайг Баатарын Мөнхням гэдэг. Би “Brigham Young” их сургуулийг төгсөөд Харвардын их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Дунд нь Вашингтонд Жоржтауны их сургуульд сурч байв.

Ажил мэргэжил гэвэл АНУ-д оюутан байх үедээ аяга угаахаас эхлээд бүх л ажил хийдэг байлаа. Улмаар их сургуулиа төгсөөд анх орсон байгууллагадаа гүйцэтгэх захирал болтол албан тушаал ахиж, удирдлагын түвшинд ажиллах анхны гарагааг эхлүүлсэн. Түүнээс хойш 150 ажилтантай компаниас 10 мянган ажилтантай компанид, мөн дээр нь АНУ-ын конгрессын дэргэдэх Эрүүл мэндийн байнгын хорооны хууль бэлддэг компанид нийт 10 гаруй жил санхүү удирдсан захирал хийсэн.

Хэдэн жилийн өмнө өөрийн бизнес консалтинг компани байгуулаад, гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байна.

-Цар тахлын үед компаниуд маркетинг, сурталчилгааг өмнөхөөс огт өөр байдлаар явуулах зайлшгүй шаардлагатай болж байна. Таны бодлоор компаниуд маркетингийн ямар шинэлэг эсвэл дасан зохицсон арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зүйтэй вэ? Аялал жуулчлал,



үйлчилгээний салбар зэрэг цар тахалд хамгийн хүндээр нэрвэгдсэн бизнесийн салбарынханд хандсан таны зөвлөгөө юу вэ?

-Цар тахлын үеэр хамгийн эхэнд ажиглагддаг нэг зүйл бол хүмүүс юм худалдаж авахаа больдог. Юу гэсэн үг вэ гэхээр танай үйлчлүүлэгчдийн тоо таниас шалтгаалахгүйгээр буурна. Энэ үед авах маркетингийн хамгийн анхны алхам бол "customer acquisition" буюу "өрсөлдөгчийнхөө үйлчлүүлэгчдийг авах" явдал. Үүний тулд өрсөлдөгч чинь танай компаниас дээр юу хийж байна, ямар үйлчилгээ үзүүлж байна, ямар бүтээгдэхүүн борлуулж байна, түүнийг нь бүр өөрөөр, бас илүү өндөр түвшинд хий гэсэн бизнесийн дүрэм байдаг.

Аялал жуулчлалын хувьд энэ жил маш хэцүү болж байна. Өдөрт дунджаар зуугаад мянган нислэг дэлхий даяар үйлддэг байсан бол дөрөвдүгээр сар гэхэд 25 мянга болтлоо буурсан. Үүнээс аялал жуулчлалын салбар ямар их хямарсныг харж байгаа биз ээ. Ийм үед ихэнх аялал жуулчлалын салбарын компаниуд үйлчилгээ, бүтээгдэхүүнээ хямдралтай үнээр зарж байна. Дараа жилийн нислэг, зочид буудлуудыг одоо авбал илүү хямдхан, бас олон хүнд зарах боломжтой. Гол нь шууд бас урсгал зардлаа багасгаж чадвал дараа жилээс салбараа, бизнесээ аврах боломжтой. ►

► - Цар тахлын энэ хүнд үеийг ямар компаниуд тэсч гарах боломжтой вэ? Тэд ямар бизнес стратеги баримтлах нь зүйтэй вэ? Ийм нөхцөлд та харилцагч нартаа ямар зөвлөгөө өгч байна вэ?

-Хамгийн тэсч гарах магадлалтай компаниуд бол нэгдүгээрт, ухаалаг маркетинг, стратегийг одооноос нэвтрүүлсэн, хоёрдугаарт, зардлаа багасгасан (гэхдээ зөв зүйлдээ хөрөнгө оруулалт хийхтэй андуурч болохгүй), гуравдугаарт, үйлчилгээний чанарыг эрхэмлэдэг, дөрөвдүгээрт, ажилчдын чанар, сэтгэл хангамж сайн (ууртай ажилтан хэзээ ч таньд мөнгө хийхэд туслахгүй) байх ёстой.

-Засгийн газраас эдийн засаг, бизнес, ард иргэдээ дэмжих цөөнгүй арга хэмжээ авсан ч “байндаа” туссан эсэхэд эргэлзэх хүн улам олширч байна. Та тэдгээр арга хэмжээг хэр үр дүнтэй гэж үзэж байна вэ? АНУ-д авч хэрэгжүүлж буй цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээнээс авууштай практикууд юу байж болох вэ?

-Маш зөв асуулт асуулаа. Монгол Улс одоогийн байдлаар бараг 2.4 их наяд төгрөг цар тахалтай тэмцэхэд зарцуулжээ. Мэдээж ямар нэгэн арга хэмжээ авч байгаа нь сайшаалтай хэрэг. Гэтэл үүний 86 хувийг нийгмийн халамжинд, мөнгө тараахад зориулсан. Энэ мөнгийг бид гадаадын өр, зээлээр авсан шүү дээ. Зөвхөн есөн хувь нь л аж ахуйн нэгжүүдэд, татвараас хөнгөлөх зэрэгт ороод таарсан. Бид энэ мөнгөө арванхоёрдугаар сар хүртэл тараана. Дараа нь нэг сараас яах вэ? Тараах мөнгө байхгүй. Улам л их өртэй, ажлын байр ч байхгүй сууж байх болно.

АНУ харин 3.3 их наяд долларыг цар тахлын эсрэг зарцуулсан. Мэдээж энэ том улс их мөнгө гаргах чадвартай. Гэхдээ би мөнгөний тоон дээр биш, хэдэн хувийг юунд хөрөнгө оруулсныг хэлье.

1) 56 хувийг нь бизнесийн салбарт зориулсан. Ажлын байр бий болгоход анхаарсан.

2) Эрүүл мэндийн салбарт 10 хувийг зориулсан.

3) 10 орчим хувийг мужуудын захиргаагаар дамжуулж цэцэрлэг, сургуулиудад зарцуулсан.

4) Үлдсэн 23 хувь нь манайхаар бол нийгмийн халамжинд явсан.

Монголчууд биднийг 86 хувиа тараагаад ажлын байр ч үгүй сууж байхад, "айлын айхтар хүүхдүүд" 56 хувь, дээр нь нэмээд 20 хувиа мужийн захиргаагаар дамжуулаад ажлын байр бий болгоход хөрөнгө оруулсан байгаа юм. Тэгэхээр ирэх оны нэгдүгээр сард хэн нь ажилтай байх нь ойлгомжтой байгаа биз.

-Монгол Улсын эдийн засаг хямрах дүр зураг бодитой харагдаж байна гэж та үзэж байна уу? Хэрэв тийм бол тэрхүү хямралаас сэргийлэх мөн гарахын тулд Засгийн газар болон бизнесүүд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авах нь чухал байна вэ?

-Хямрахаар барах уу, Монголын эдийн засгийг тайлбарлаад хэлэх үг надад үнэхээр алга. Гэвч бид ийм байдлаас гарахын тулд ямар арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой талаар санал, бодлоо хэлье. Нэгдүгээрт, мөнгө тарааж, инфляц үүсгэж, зээлийн тоог нэмэгдүүлж, эдийн засгаа улам доройтуулахаа зогсоох хэрэгтэй байна. Хоёрт, “бүтээн байгуулалт” нэртэй хөшөө дурсгалууд барихаа өнөөдөрөөс зогсоож, тэр мөнгөө богино хугацаанд өгөөж өгөх төслүүдэд зориулах хэрэгтэй байна.

Татвар төлдөг цөөхөн хэдхэн хүнтэй, гэтэл нийгмийн халамж авдаг, улсаас цалин авдаг албан хаагчдын тоо нь тэднээсээ хэт их болчихсон. Ийм нөхцөлд бид хэзээ ч тогтвортой өсөлттэй эдийн засаг гэж яриад хэрэггүй.

Эрх баригчид хамгийн түрүүнд ажлын байр ярих ёстой байсан. Бизнес эрхлэгчдээ дэмжих ёстой байсан.

-Сүүлийн үед улс төр, бизнесийн салбарт мөн иргэдийн дунд эрчимтэй яригдаж байгаа нэг сэдэв бол зээлийн хүү. Монгол Улсад зээлийн хүүг нэг оронтой болгож бууруулахын тулд таны бодлоор ямар бодитой алхмууд хийх боломж байна вэ?

- Үүнд төрийн ухаалаг оролцоо маш чухал гэж бодож байна. Юу хийвэл зүйтэй талаар хоёр санал байна. Өнөөдөр үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх цаг болсон. Би зургаан жил public компанийн (манайхан төрийн компани гэдэг) зүүн эрэг хариуцсан санхүүгийн захирал хийсэн. Манай үнэт цаас Нью-Йоркт үнэт цаасны арилжааны зах дээр зарагддаг байсан. Бидэнд мөнгө хэрэг болоход банкнаас гуйх шаардлага гардаггүй байлаа. Оронд нь IPO хийгээд өөрсдөө мөнгөө босгодог. Хэрвээ Монголд үнэт цаасны хуулиа сайжруулаад, тогтолцоог нь бүрдүүлээд хийвэл энэ бол банкны хүүг бууруулах шилдэг арга.

Хоёрт, банкинд мөнгөө хүүтэй хадгалуулж ►

Монголчууд биднийг 86 хувиа тараагаад ажлын байр ч үгүй сууж байхад, "айлын айхтар хүүхдүүд" 56 хувиа шууд, 20 хувиа мужуудаар дамжуулаад ажлын байр бий болгоход хөрөнгө оруулсан.

► байгаа хүмүүст ашгийн өндөр татвар ногдуулах хэрэгтэй. Гэхдээ зөвхөн хадгаламжийн ашгаас нь шүү. Тэгсэн тохиолдолд мөнгөтэй хүмүүс мөнгөө зүгээр хадгалуулахаа болиод бизнес хийж, ажлын байр бий болгоно, мөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулна.

-Цар тахлын үед ийм их алдагдалтай төсөв баталсныг та юу гэж үзэж байна вэ? Үүний эерэг болон сөрөг дагавруудыг та нэрлэнэ үү?

-2020 онд дэлхийн олон орон алдагдалтай төсөв баталж байна. Тийм учраас би үүнд нэг их эмзэглэхгүй байгаа. Гэхдээ хоёр зүйлд маш их санаа зовж байна.

Юуны өмнө, Их хурлын гишүүдийн эдийн засгийн мэдлэгийн цар хүрээнд. Саяхан би нэг гишүүний бичлэг үзэж байхад, яагаад юмны үнэ нэмэгдээд байна аа гээд гайхаад сууж байсан. Мөнгө тарааж байгаагаа мартсан уу, эсвэл мөнгө тараахын

хор уршгийг мэдэхгүй юу. Тийм хүмүүс гурван сая хүний хувь заяаг шийднэ гэхэд санаа зовмоор л байна.

Хоёрдугаарт, юунд мөнгө зарцуулахаар баталж байгаа нь бас их хэцүү. Энэ хавар Улаанбаатарт усан оргилуур барьсан. Дэлхийн хөгжсөн орны хүйтэн хотуудад ихэнхдээ усан оргилуур

байдаггүй. Яагаад жилийн 12 сарын гуравхан сард нь дулаан байдаг хотод усан оргилуур барьдаг юм бэ? Тэр мөнгийг ажлын байр бий болгоход зарцуулсан бол өнөөдөр хэдэн хүн Улаанбаатарт ажилтай байх вэ?

- Бүх хүнийг баян, ядуу ялгалгүй хамарч байгаа цар тахлын үед, нэн ялангуяа дундаж давхарга муутай Монгол Улсын иргэд санхүү, мөнгөний асуудлаа хэрхэн зохицуулж, юунд их анхаарах ёстой вэ?

-Брэндийн хувцас хөөхөө өнөөдрөөс эхлээд боль. Ер нь брэндийн компаниуд ядуу буурай орнуудыг онилж бараагаа зарах сонирхолтой байдаг. Энэ бол факт. Баян хүмүүст баян харагдах гэж ядах шаардлага байдаггүй.

-Та АНУ дахь монголчуудад тулгарч буй бэрхшээлийн талаар товч мэдээлэл өгнө үү? Энэ ташрамд асуухад тусгай нислэг, гадаад дахь иргэдийн татан авалт, Улсын онцгой комиссын

үйл ажиллагааны талаар та ямар сэтгэгдэлтэй байна вэ?

-Гадаадад байгаа монголчууд маань үнэхээр хэцүү байна. Долоо, найман сар хүний нутагт байгаад, одоо зарим нь гэртээ харих гэхэд билетний мөнгөгүй гацаж байна. МИАТ хуучин билетээр нь биш, шинээр билет авахуулж нисэх зөвшөөрөл өгч байгаа.

Гэр орныхоо тавилгыг зараад дуусаж байна. Тэгтэл Улсын онцгой комисс хариуцлага огт хүлээхгүй, удирдлага нь муу ажиллаж байгааг хараад гайхаж байна. Удирдлага сайн бол энэ хэмжээний хүмүүсийг гэрт нь ирэх боломжийг аль эрт гаргаж өгч болох байсан.

Өдийг хүртэл төсөв байхгүй гээд сууж байсан атал хотын удирдлага нэг, нэгэндээ 21 сая төгрөгийн шагнал хүртэл бичээд өгчихсөн л байна шүү дээ.

-Монгол бол дотооддоо коронавирусийн халдвар алдаагүй тун том давуу талтай улс. Бид энэ давуу талаа ашиглаж чадалгүй, бизнесүүдээ, эдийн засгаа хүнд байдалд орууллаа?

- Монгол Улс маань эдийн засгийн энэ боломжоо ашиглаж чадаагүйд би маш их харамсаж байгаа. Гэхдээ үүнд Монголын ард түмэн буруутай биш л дээ. Ер нь улс бол нэг айл л гэсэн үг. Айл явал баян амьдрах вэ? Ямар нэгэн бизнес хийж, бараа бүтээгдэхүүн юм уу, үйлчилгээг бусдад зарж байж тэр айл баян амьдарна. Монгол Улс ч ялгаагүй. Гол нь гаргаж байгаа бүтээгдэхүүн чинь зах зээлийн үнэтэй харьцуулахад ямар байна, үйлдвэрлэлийн зардал, урсгал зардал, хүссэн ашгаа авч чадсан уу гэх мэт олон зүйлийг бодох хэрэгтэй л дээ.


Бидний урд Хятад гээд агуу том хөрш байна. Бид түүнийг өөрсдийнхөө талд ашигтайгаар ашиглаж болох олон боломж байсан ч харамсалтай нь зээл авч, өр тавихаас хэтрэхгүй байна даа.

-Ярилцлагын төгсгөлд та компанийнхаа талаар манай уншигчдад танилцуулна уу? Монголд үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдэд танай компани зөвлөгөө өгдөг үү?

-Манай "MCN Consulting Group" компани маркетинг, татвар, бизнес менежментийн гурван төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Манай багууд Америкийн зах зээлээр илүү мэргэшсэн болохоор бид одоохондоо Америкт үйлчилгээ үзүүлж байна.

Гэхдээ Монголоос Америкийн зах зээлд нэвтрэх сонирхолтой компаниудад зориулсан үйлчилгээг манай компани санал болгох боломжтой. ■

Улсын онцгой комисс хариуцлага огт хүлээхгүй, удирдлага нь муу ажиллаж байгааг хараад гайхаж байна



www.mongolianeconomy.mn

Вэб хуудас шинэчлэгдлээ;

- **The Economist** булан
- Mongolian Economy-онлайн захиалга
- Агуулга баяжсан

Telephone: **7011-5476**

Ковид-19 ба нүүрс

25 саяд хүрэх үү?



хугацаанд 30 хүртэлх ажилтантай хайгуул, олборлолтын 86 компани сул зогсож, 51-213 ажилчинтай 11 компанид хүндрэл учирсан байна. Харин төрийн өмчит болон хувийн томоохон компаниуд хүндрэлийг харьцангуй бага гарзтай туулж, ажлын байраа хадгалж чадсан байна.

Боомтуудын үйл ажиллагааг ээлж дараалан хэвийн болгосноор зогсолтод ороод байсан нүүрсний экспорт гуравдугаар сараас сэргэж эхэлсэн боловч хяналт, шалгалт болон тусгаарлалтын улмаас дорвитой өсөөгүй. Тавдугаар сард л гэхэд дөрвөн боомтоор гарч буй нүүрс тээврийн машины тоо өдөрт 700 хүрэхтэй үгүйтэй байсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар нүүрсний экспорт өмнөх оныхтой харьцуулахад 52 хувиар бууржээ. Ингэснээр нүүрсний экспортын орлого оны эхний хагас жилийн байдлаар 690 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 850 сая ам.доллараар буурсан байна. Хэдий тийм боловч сарын дүнгээр авч үзвэл зургаадугаар сард 2.3 сая тонн нүүрс экспортолсон нь он гарснаас хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон нь экспорт сэргэх эхлэл болсон юм.

Урсгал нээсэн гарц

Ковид-19 цар тахалтай тэмцэх, сэргийлэх Монгол, Хятадын хамтын ажиллагааны механизмын хүрээнд “Ногоон гарц” түр журмыг наймдугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр олон улсын ачаа тээврийн жолооч, худалдаа, ложистик, үйлдвэрлэл, техникийн үйлчилгээний салбар болон бүтээн байгуулалтын төслүүдийн үйл ажиллагаанд оролцох инженер, техникийн ажилтнуудыг хил нэвтрүүлэх боломж нээгдсэн юм. “Ногоон гарц” журмаар жолооч нарт урьдчилж коронавирусийн шинжилгээ өгсний дараа хоёр улсын боомтод тусгай заасан бүс нутгаас гарахгүй тээвэрлэлт хийх боломжийг олгожээ. Тус журам хэрэгжиж эхэлснээр Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг гол боомтууд хэвийн ажиллаж эхэллээ. ►

Цар тахал сураг ч үгүй, урд хөршийн эрэлт тогтвортой байхад Монгол Улс 2020 онд 42 сая тонн нүүрс экспортолно хэмээн “ам гаржээ”. Гэтэл энэ оны эхээр дэлхийн эдийн засгийг тэр чигт нь савлуулсан коронавирусийн давлагаа дэгдсэнээр бидний хэт өөдрөг төсөөлөл биелэхгүй нь баттай болов. Цар тахлаас өмнөх эдийн засгийн таатай үед хамгийн ихдээ 36.4 сая тонн нүүрс экспортолж байсан атал экспорт буураад жилийн хагасаас илүү нь өнгөрчихөөд байхад бид сая л зорилгоо 25 сая тонн болгож бууруулав. Гэвч бодит байдалд илүү ойртсон энэ зорилгодоо ч хүрч чадах эсэх нь эргэлзээ төрүүлсээр.

Вируст хашигдсан нүүрс

Цар тахлын дэгдэлтээс сэргийлэх зорилгоор хөл хорио тогтоосон нь нүүрсний экспорт эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60 хувиар буурахад хүргэв. Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Х.Буянжаргалын хэлснээр энэ

Экспорт эхний улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60 хувиар бууржээ

► Тухайлбал, долдугаар сард өдөрт дунджаар 900 орчим тээврийн хэрэгсэл хилээр гарч байсан бол наймдугаар сарын дундаас энэ тоо хоёр дахин өссөн байна.


Нүүрсний экспорт цар тахлын өмнөх хэмжээндээ хүрээд зогсохгүй наймдугаар сарын 26-ны өдөр 2233 машин нүүрс гарснаар нэг өдрийн хамгийн өндөр экспортын хэмжээ болжээ. “Ногоон гарц” журмын хүрээнд хилээр гарч буй тээвэрчдийн буудаллах газар болон тэдэнтэй зүй бус харьцсан зэрэг асуудлууд гарсныг холбогдох байгууллагын төлөөлөл цаг тухайд нь шийдвэрлэж буйг онцлууштай.

Корона ганцаараа буруугүй

Зогсонги байдалд ороод байсан нүүрсний экспорт энэ оны хоёрдугаар улирлаас сэргэж, хилээр өдөрт гарах тээврийн хэрэгслийн тоо хэвийн хэмжээндээ очсон хэдий ч төлөвлөсөн хэмжээнийхээ талд ч хүрээгүй хэвээр байна. Монгол Улс эхний долоон сарын байдлаар нийт 11.2 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.4 хувиар буурсан үзүүлэлт юм.


Цар тахлын улмаас хорио цээрийн арга хэмжээ авсан нь энэ жилийн нүүрсний экспорт буурахад ихээхэн нөлөөлсөн ч дотоодын хүчин зүйл гол асуудал болсон хэвээр байна. Үүний нэг бол баригдаж дуусдаггүй нөгөө л төмөр замын асуудал. Бид дэд бүтцийн энэ “жигжигхэн” асуудлаа шийдэж чадах юм бол БНХАУ-ын талаас эрэлт тогтвортой, хүлээн авах олон зам нээлттэй байгааг өнгөрсөн жилийн “Coal Mongolia” арга хэмжээний үеэр тус улсын төлөөлөгчид удаа дараа илэрхийлж байсан. Цар тахал БНХАУ-ын эдийн засагт багагүй сөрөг нөлөө үзүүлсэн нь дамжиггүй ч тус улсын эрэлт, тэр дундаа манай улсаас импортоор авах нүүрсний хэмжээнд төдийлөн өөрчлөлт гараагүй нь асуудал бидэнд байгааг дахин бататгаж байх шиг. Эдийн засагч Б.Дөлгөөн “Экспортын уналт Хятадын эдийн засагтай холбоотой хэдий ч манай тал Ковид-19 цар тахлаас сэргийлсэн хөл хорио тогтоож, хилээ хаасан нь хамгийн гол нөлөө үзүүлсэн. Тухайн үед хөл хорио тогтооход Хятадын талаас нүүрс авахгүй гэж мэдэгдээгүй. Манай тал л хилээ шууд хаасан, гэтэл Австралийн нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэн. Тиймээс хэрэв эрх баригчид алсаа харсан бодлого явуулж чадвал ирэх онд нүүрсний экспорт боломжийн хэмжээнд байна гэсэн хүлээлттэй байна” гэж хэлсэн нь нэгийг өгүүлэх биз ээ.

Нүүрсний экспорт /сая тонн/



Эх сурвалж: ГЕГ


Нүүрсний экспортын орлого /сая ам.доллар/



Экспортын хурдыг сааруулж буй дараагийн шалтгаан бол шинжилгээ, лабораторийн асуудал болохыг “Монгол Нүүрс Ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал Ж.Золжаргал онцолсон юм. Томоохон компаниудын итгэмжлэгдсэн хяналтын лабораториуд хилийн орчимд байдаг хэдий ч дээжийг заавал нийслэл дэх гаалийн лабораторид илгээж, хариу хүлээдэг нь экспортын хурдыг сааруулдаг байна. Үүний оронд гаалийн лабораторийн мэргэжилтнийг томилж ажиллуулбал цаг хэмнэх боломжтой. Үүнээс гадна хилийн боомтуудын ажиллах цагийг сунгаснаар экспортыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой болохыг тэрбээр онцолсон. Энэ мэтчилэн жигжиг боловч оновчтой шийдэл, зохицуулалтыг хийсэн цагт хоёр жил дараалан хүрч чадаагүй 42 сая тонн “мөрөөдөл” биш бөгөөд биелэх бүрэн боломжтой зорилт болох юм. ■

Вакцин

Хүн төрөлхтний аврал



Коронавирус + вакцин

“Ковид-19-ийн тархалтыг зогсоохын тулд дэлхийн хүн амын 30-60 хувь вакцинд хамрагдах шаардлагатай” гэж тэрбумтан Б.Гейтс хэлжээ. Эрдэмтэд Ковид-19-ийн эсрэг 165 гаруй вакцин бүтээж буй. Тэдгээрээс 32 вакцины эмнэлзүйн туршилт явагдаж буйгаас найм нь эцсийн буюу гуравдугаар шатанд долоо, наймдугаар сард шилжсэн байна. Ихэнх тохиолдолд вирусийг илрүүлснээс зургаан жилийн дараа вакциныг гуравдугаар шатны туршилтад шилжүүлдэг атал энэ удаад зургаан сарын дотор эцсийн шатны туршилтыг эхлүүлсэн нь гайхалтай гэж Оксфордын их сургуулийн Женнер институтийн захирал, профессор Адриан Хилл онцолжээ. Дөрвөн жил зарцуулсан гахай хавдарын вакцин нь хүн төрөлхтний хамгийн хурдан бүтээсэн вакцинд тооцогддог. Ийнхүү эрдэмтэд 2021 оны эцэс гэхэд үр дүнтэй вакцин гаргаж авахаар ханцуй шамлан ажиллаж байна.

Коронавирус нь тосон (lipid) бүрхүүлтэй ба

савангийн молекул хүрэхэд задардаг тул эмч мэргэжилтүүд гараа сайтар угаахыг зөвлөж буй. Вирус нь хүний хамар, ам, нүдээр дамжин амьсгалын замын бүрхүүл эсийн ACE2 рецепторт сууж, хүний биеийн эсэд нэвгэрдэг. Үүний дараа тосон бүрхүүл задарч удамшлын мэдээлэл бүхий рибонуклейн хүчлийг (РНХ) чөлөөлөн хүний биеийн эсийг ашиглан үрждэг байна (Зураг 1). Коронавирусын гадаргуу нь титэм мэт сэртэнгийн уурагтай учраас “coronavirus” буюу “титэм вирус” гэж нэрлэжээ. Ковид-19-ээс гадна зургаан төрлийн коронавирус хүнд халдварладаг ба үүнд амьсгалын цочмог хам шинж (SARS), Ойрх Дорнодын амьсгалын цочмог хам шинж (MERS) багтдаг.

Вакцины туршилт

Вирусийн сэртэнгийн уурагт бэхлэгдэж, вирусийг саармагжуулдаг эсрэг биетийг вакцин үүсгэдэг юм. Өөрөөр хэлбэл, вакцин хийлгүүлсний дараа коронавирус биед нэвтрэхэд: ►

- Дархлаа хариу урвал үзүүлж коронавирусийн эсрэг биетийг ялгаруулна,
- Эсрэг биет коронавирусийн сэртэнгийн уурагт бэхлэгдэнэ,
- Коронавирус ACE2 рецепторт сууж эзэн биеийн эсэд нэвтрэх буюу үржих боломжгүй болно,
- Бусад дархлааны хариу урвал идэвхжиж Т-лимфоцит зэрэг эс ялгарна,
- Т-лимфоцит зэрэг нь эсрэг биетээр тамгалагдсан коронавирусийг устгана.

Харин вакцин хийлгээгүй хүн коронавирусийн халдвар авсны дараа дархлааны дээрх хариу урвал явагдахад хэдэн хоног шаардагддаг. Ингэснээр эсрэг биет ялгарах хүртэл коронавирус эсэд нэвтрэн үржиж, халдварласаар байдаг юм.

Вакцин бүтээх үйл явцыг эмнэлзүйн туршилтын өмнөх тест ба гурван шатлалаас бүрдэх эмнэлзүйн туршилт гэж ангилдаг.

Эмнэлзүйн туршилтын өмнөх тест: Эрдэмтэд вакциныг хулгана, сармагчин зэрэг амьтанд тарьж, дархлааг нь өдөөж буй эсэхийг мөн хүн дээр туршихад аюулгүй эсэхийг нягтална.

1-р шат: Ойролцоогоор 10-50 эрүүл хүнийг вакцинд хамруулж, дархлааны системийг нь

дэмжиж буй эсэх, аюултай эсэх, тунгийн хэмжээ зэргийг шалгадаг.


2-р шат: Эхний шатны туршилтаас ялгаатай нь олон зуун хүнийг нас, хүйс зэргээр нь ангилан бүлэглэж, бүлэг тус бүрт вакцин хэрхэн нөлөөлж буйг судалдаг. Мөн дархлааг дэмжиж буй эсэх болон сөрөг нөлөөг нь үргэлжлүүлэн хянана.

3-р шат: Олон мянган хүнийг вакцинд хамруулж, хэдэн хувийг нь вирусээс хамгаалж буйг вакцинд хамруулаагүй хүмүүстэй харьцуулна. Зургадугаар сард АНУ-ын Хүнс, эмийн албаны (FDA)-мэдээлснээр вакцинд хамрагдсан хүний 50 хувийг вирусээс хамгаалсан тохиолдолд тус вакциныг үр дүнтэйд тооцдог аж. Өмнөх туршилтаар илрээгүй сөрөг нөлөө зэргийг гурав дахь шатны туршилтаар илрүүлдэг байна.

Зөвшөөрөл: Туршилтын үр дүн, судалгаанд үндэслэж вакцинд зөвшөөрөл өгөх эсэхийг тухайн улсын холбогдох агентлаг, байгууллага эсвэл Олон улсын байгууллага шийднэ. Зөвшөөрөл өгсний дараа ч гэсэн вакцины үр дүн, аюулгүй байдлын судалгааг эрдэмтэд үргэлжлүүлэн хийсээр байдаг.

Холимог шат: Вакцины туршилтыг хурдасгахын тулд нэг/хоёр эсвэл хоёр/гуравдугаар шатны туршилтыг нэгэн зэрэг хийх боломжтой. Тухайлбал, коронавирусийн зарим вакцины нэг, хоёрдугаар шатны туршилтыг хамтатган 10-50 бус олон зуун хүн дээр туршиж эхэлжээ. ►

Зураг 1. SARS-CoV-2 вирусийн үржлийн явц



1. Сэртэнгийн уураг эсийн ACE2 рецепторт сууж TMPRSS2 ферментийн тусламжтай эс рүү нэвтрэнэ 2. Вирус задарч РНХ-г чөлөөлнө 3. Эзэн биеийн эсийг ашиглан уураг үүсгэнэ 4. Зарим уураг нийлэгжиж РНХ-г олшруулна 5. Гольджийн комплекс дотор РНХ, уураг эвлэж вирус шинээр үүснэ 6. Вирус эсээс гадагшиж бусад эс рүү нэвтрэнэ

Эх сурвалж: The Economist

► Боломжит вакцинууд

ГЕНЕТИКИЙН ВАКЦИН:

Коронавирусийн удамилын мэдээллийг
ашиглан дархлааны хариу урвалыг
өдөөх вакцин

Туршилтын шат: 3

Вакцины нэр: mRNA-1273

Вакцины төрөл: Генетикийн вакцин

moderna

“Moderna” компани мэдээллийн РНХ (рибонуклейн хүчил)-д суурилсан вакцин бүтээж байгаа юм. Эл вакцин сармагчныг коронавирсийн халдвараас сэргийлж буйг Үндэсний эрүүл мэндийн институт, “Moderna” компани тогтоосон байна. Энэ оны гуравдугаар сард хүн дээр хийсэн туршилт амжилттай болж, хоёрдугаар шатны туршилтыг 300 гаруй хүн дээр хийж дуусгаад сүүлчийн шатны туршилтыг долдугаар сарын 27-нд эхлүүлжээ. Гуравдугаар шатны туршилтыг одоогоор АНУ-д 30 мянга орчим хүнийг хамруулан хийж буй.

Вакцины захиалга: АНУ-ын Засгийн газар 1.5 тэрбум долларыг 100 сая тун авах нөхцөлтэйгөөр наймдугаар сарын 11-нд олгожээ. Мөн Европын хороотой 80 сая вакцин нийлүүлэхээр наймдугаар сарын 24-нд тохиролцсон байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Тус компани 2021 оны эхээр 0.5-1 тэрбум вакцин үйлдвэрлэх бололцоотой гэж мэдээлсэн.

ВЕКТОР (ЗӨӨГЧ) ВАКЦИН:

Үржих боломжгүй болсон вирусийг ашиглан
коронавирусийн удамилын мэдээллийг эсэд хүргэж
дархлааны системийг өдөөх вакцин

Туршилтын шат: 2 / 3

Вакцины нэр: ChAdOx1 nCoV-19

Вакцины төрөл: Вектор вакцин



Их Британи-Шведийн “AstraZeneca” компани, Оксфордын их сургуулийн Женнер институт болон тус сургуулийн вакцины группийн хамтран судалж буй тус вакцин шимпанзегийн аденовируст суурилсан юм. ChAdOx1 вакцины технологийг ашиглаж томуу, Зика вирус, Ойрх Дорнодын амьсгалын цочмог хам шинж өвчний эсрэг вакциныг Оксфордын их сургууль бүтээж байжээ. Аденовирусийг хоргүйжүүлж, сулруулсан учраас хүний биед үржих чадваргүй. Эл вакциныг сармагчин дээр туршиж үзэхэд коронавирсээс хамгаалж байжээ. Нэг, хоёрдугаар шатны туршилтаар аюулгүй, ноцтой сөрөг нөлөөгүй нь батлагдсан. Энэхүү вакцины хоёр, гуравдугаар шатны туршилтыг Англи, Энэтхэгт хийхийн сацуу эцсийн туршилтыг Бразил, Өмнөд Африк, АНУ-д хийж байгаа аж.

Вакцины захиалга: Их Британийн Засгийн газар есдүгээр сарын эхээр 100 сая тун авах захиалга өгчээ. Франц, Герман, Итали, Нидерланд улсуудын байгуулсан “Inclusive Vaccines Alliance” 2020 оны эцэс гэхэд 400 сая тун нийлүүлэх гэрээ хийжээ. Харин аравдугаар сарын эхээр 300 сая тун нийлүүлэх хэлэлцээр АНУ-тай байгуулсан байна. Наймдугаар сарын 17-ны байдлаар хамгийн их вакцины захиалгыг (нийт 1.2 тэрбум тун) AstraZeneca, Оксфордын их сургууль аваад байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Эл компани жилд хоёр тэрбум тун үйлдвэрлэх хүчин чадалтай. ►

Туршилтын шат: 2 / 3

Вакцины нэр: BNT162b2

Вакцины төрөл: Генетикийн вакцин



Германы “BioNTech”, АНУ-д төвтэй “Pfizer”, Хятадын “Fosun Pharma” эм үйлдвэрлэгч компаниуд хамтран вакцин бүтээхээр тохиролцсон. Энэ оны тавдугаар сард нэг, хоёрдугаар шатны туршилтыг зэрэг эхлүүлсэн бөгөөд хүний биед эсрэг биет үүсгэж, дархлааны Т-лимфоцит ялгарч буйг тогтоожээ. Тэр дундаа халуурах, сульдах зэрэг гаж нөлөө багатай тул BNT162b2 нэртэй вакциныг нь хоёр, гуравдугаар шатны туршилтад шилжүүлэхээр сонгосон аж. Эдгээр компани хоёр, гуравдугаар шатны туршилтыг АНУ, Аргентин, Бразил, Герман зэрэг орны 30 мянган хүнийг хамруулна гэж долдугаар сарын 27-нд мэдээлсэн.

Вакцины захиалга: Арванхоёрдугаар сар гэхэд 100 сая тун авахаар 1.9 тэрбум долларыг Д.Трампын засаг захиргаа олгосон байна. Мөн нэмж 500 сая тун нэмж авах эрхтэй болсон. Түүнчлэн Япон улс 120 сая, Их Британи 30 сая тунг урьдчилан захиалжээ.

Үйлдвэрлэлийн хүчин чадал: “Pfizer” компани 2020 оны аравдугаар сард вакцины зөвшөөрөл авахаар төлөвлөж буйгаа наймдугаар сард мэдээлжээ. Хэрэв зөвшөөрөл авбал 2020 онд 100 сая тун, 2021 оны эцэс гэхэд 1.3 тэрбум тун үйлдвэрлэх хүчин чадалтай юм.

► **Туршилтын шат:** 3 / Тусгай зориулалтаар ашиглах зөвшөөрөлтэй

Вакцины нэр: Ad5-nCoV

Вакцины төрөл: Вектор вакцин



Хятадын “CanSino Biologics” компани Анагаахын шинжлэх ухааны армийн академийн харьяа Биологийн институттай хамтран Ad5 аденовируст суурилсан вакцин бүтээжээ. Эхний шатны туршилт амжилттай болсон тухай тавдугаар сард мэдээлсэн ба хоёрдугаар шатны туршилтаар дархлааны хүчтэй хариу урвал үзүүлж буйг илрүүлэв. Тус вакциныг цэргийн зориулалтаар ашиглахыг зургадугаар сарын 25-нд Хятад улсад зөвшөөрчээ. Гэвч цэргүүдэд сайн дураар эсвэл албадан вакцин хийх эсэх нь тодорхойгүй. “CanSino Biologics”-ийн гуравдугаар шатны туршилтыг Саудын Арабт хийнэ гэж Саудын Арабын Эрүүл мэндийн сайд наймдугаар сарын 9-нд зарласан.

Вакцины захиалга: Тодорхойгүй

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Жилд 70-80 сая тун үйлдвэрлэх боломжтой.

Туршилтын шат: 3 / Зөвшөөрөлтэй

Вакцины нэр: Гам-Ковид-Вак-Лин/ Спутник V

Вакцины төрөл: Вектор вакцин



ОХУ-ын Эрүүл мэндийн яамны харьяа Н.Ф.Гамалеин нэрэмжит Эпидемиологи, микро-биологийн үндэсний судалгааны төв Ad5 болон Ad26 аденовируст суурилсан вакцины эхний шатны туршилтад 76 хүнийг хамруулсан ба наймдугаар сарын 1-нд туршилтаа дуусгасан. Гуравдугаар шатны туршилт эхлэхээс өмнө тус вакциныг ашиглах зөвшөөрлийг ОХУ-ын Эрүүл мэндийн яам наймдугаар сарын 11-нд олгосон юм. Мөн тухайн вакцины шинжлэх ухааны баримтыг олон нийтэд дэлгээгүй байна. Удалгүй эл зөвшөөрлийг тусгай нөхцөлтэй зөвшөөрөл хэмээн заруулж, гуравдугаар шатны туршилтад 18-аас дээш насны 40 мянган иргэнийг хамруулж байгаа гэж наймдугаар сарын 24-нд мэдээлсэн юм. 2020 оны есдүгээр сараас эхлэн их хэмжээгээр үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа аж.

Вакцины захиалга: Тодорхойгүй

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Тодорхойгүй

АМЬД ВАКЦИН:

Сулруулсан эсвэл идэвхгүйжүүлсэн коронавирусийг ашиглан дархлааны системийг өдөөгч вакцин

Туршилтын шат: 3

Вакцины нэр: Тодорхойгүй

Вакцины төрөл: Амьд



вакцин

“Wuhan Institute of Biological Products” компани сулруулсан коронавирусийг ашиглан вакцин бүтээсэн ба эмнэлзүйн туршилтыг нь төрийн өмчит “Sinopharm” хийж буй. Нэг, хоёрдугаар шатны туршилтад хамрагдсан хүмүүсийн биед эсрэг биет ялгарсан. Зарим хүмүүст халуурах зэрэг сөрөг нөлөөлөл илэрчээ. Гуравдугаар шатны туршилтыг Арабын Нэгдсэн Эмират, Перу, Марокко улсад долдугаар сард эхлүүлсэн бөгөөд 2020 оны эцэс гэхэд тус вакцин олон нийтийн хэрэглээнд очно гэж “Sinopharm” компанийн ТУЗ-ийн дарга хэлсэн байна.

Вакцины захиалга: Тодорхойгүй

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Зургадугаар сард шинэ үйлдвэр барьснаар үйлдвэрлэлийн хүчин чадал нь жилийн 200 сая тун болов.

Туршилтын шат: 3

Вакцины нэр: BBIBP-CorV

Вакцины төрөл: Амьд вакцин



“Beijing Institute of Biological Products”-ийн бүтээсэн вакцины туршилтыг мөн “Sinopharm” компани хариуцан хийж байгаа аж. Арабын Нэгдсэн Эмиратад 5000 хүн дээр тус вакцины гуравдугаар шатны туршилтыг хийж эхлээд буй.

Вакцины захиалга: Тодорхойгүй

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Жилд 200 сая тун вакцин үйлдвэрлэх боломжтой.

Туршилтын шат: 3

Вакцины нэр: CoronaVac

Вакцины төрөл: Амьд вакцин



“Sinovac Biotech” компанийн CoronaVac вакцины нэг болон 743 хүнийг хамруулсан хоёрдугаар шатны туршилтаар хүчтэй сөрөг нөлөө илрээгүй ба дархлааны системийг өдөөсөн гэж зургадугаар сард мэдэгджээ. Иймд тус компани гуравдугаар шатны туршилтаа долдугаар сард Бразил, наймдугаар сард Индонез улсад эхлүүлсэн байна. Одоогоор нийт 11 мянган хүн туршилтад хамрагдаж буй.

Вакцины захиалга: Хэрэв туршилт амжилттай болвол Бразилд 120 сая тун, Индонез улсад 50 сая тунг 2020 оны арваннэгдүгээр сараас 2021 оны гуравдугаар сарын хооронд нийлүүлэхээр тохиролцжээ.

Үйлдвэрлэлийн хүчин чадал: Хүчин чадлаа 100 сая тун хүртэл нэмэгдүүлэхээр ажиллаж буй. ►

► Монголчууд ба вакцин

Ийнхүү АНУ, Их Британи, Япон, Европын холбооны орнууд хэд хэдэн эм үйлдвэрлэгч компанитай хэлэлцээр байгуулж, коронавирусийн вакцин захиалаад байна. Хэдийгээр цар тахлыг дарахын тулд вакциныг дэлхий нийтэд тэгш хуваарилах нь хамгийн зөв шийдэл боловч зарим улс үндэсний эрх ашгаа эн тэргүүнд тавих эрсдэлтэй. Тухайлбал, АНУ ДЭМБ-аас гарах хүсэлтээ 2020 оны долдугаар сарын 6-нд хүргүүлэв. Мөн 2021 оны нэгдүгээр сар хүртэл АНУ-ыг 300 сая вакцинаар хангах “Operation Warp Speed” санаачилгыг тавдугаар сарын 15-нд эхлүүлжээ. Харин коронавирусийн вакциныг Европын холбооны гишүүн орнуудад хүртээмжтэй болгох зорилгоор Франц, Герман, Итали, Нидерланд улс “Inclusive Vaccines Alliance”-ыг байгуулсан юм. Мөн 2009 онд H1N1-ийн вакциныг баян орнууд худалдаж авч нөөцөлсөн түүхтэй ба нийт хүн амаа вакцинжуулж дуусах хүртэл вакцин экспортлохыг Австралийн Засгийн газар хориглож байсан удаатай.

Энэ удаад буурай орнуудыг орхигдуулахгүйн тулд олон улсын хамтын ажиллагааны COVAX түншлэлийг “Global Alliance for Vaccines and Immunizations”, “Coalition for Epidemic Preparedness Innovations”, ДЭМБ тэргүүлэн гишүүн орнуудын өмнөөс вакцин үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, COVAX нь дэлхийн улс бүрт вакцин хүртээмжтэй, тэгш хуваарилалтыг хангахаар байгуулагдсан юм. Тус түншлэлд хамрагдаж буй 172 орны 80 нь вакцин худалдаж авах хөрөнгөтэй бол үлдсэн 92 орон нь бага, дунд орлоготой, үүнд Монгол Улс багтаж буй. Тиймээс ядуу, буурай орнуудад зориулан COVAX-ийн “Advance Market Commitment”-ээр дамжуулан баян орнууд хандив өгөх боломжтой бөгөөд одоогоор 600 сая долларын хандив цуглараад байна. Эл түншлэл нь үр дүнтэй, аюулгүй вакциныг шуурхай нийлүүлэхийн тулд вакцин үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, мөн түүнчлэн нийт есөн вакцины хөгжүүлэлтэд (үүнд, эмнэлзүйн гуравдугаар шатанд буй “AstraZeneca”, “Moderna”-ийн вакцин багтсан) хөрөнгө оруулж байна. 2021 оны эцэс гэхэд COVAX-аар дамжуулан хоёр тэрбум тун вакцин худалдан авч, 172 орны хүн амын 20 хувийг вакцинд хамруулахаар төлөвлөжээ. Гэхдээ эхний ээлжинд ямар бүлгийн иргэдийг вакцинжуулахаа COVAX бус тухайн улс шийдэх юм. Үүний дараа тухайн орны нөхцөл байдал, эрүүл мэндийн тогтолцоо зэргээс хамаарч нэмэлт вакциныг хуваарилах юм. COVAX одоогоор “AstraZeneca”-тай 300 сая вакцин нийлүүлэх Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулжээ.

Монгол Улс хэзээ вакцин хүлээж авах нь аль улс эхэлж вакцин гаргахаас ихээхэн хамаарна. Хэрэв Хятад улсын вакцины гуравдугаар шатны туршилт амжилттай болж 9-12-р сарын хооронд ДЭМБ-аас зөвшөөрөл авбал Монгол

Улсад 2021 оны эхэн эсвэл дундаас вакцин нийлүүлэгдэх магадлалтай. Учир нь БНХАУ-ын бүтээсэн Ковид-19-ийн вакциныг ДЭМБ баталгаажуулбал эхний ээлжинд Монгол Улсад нийлүүлнэ гэж тус улсаас манай улсад суугаа Элчин сайд Цай Вэньруй хэлж байв. Хэдийгээр ОХУ-ын тал Монгол Улсад вакцин нийлүүлнэ гэж албан ёсоор мэдэгдээгүй ч хөрш орнуудад Ковид-19-ийн халдвар тархсаар байх нь Оросын иргэдийн эрүүл мэнд, эдийн засагт сөрөг нөлөөтэй. Иймд ОХУ-ын “Спутник V” вакцины гуравдугаар шатны туршилт амжилттай болвол 2021 эхэн эсвэл дундаас Монголд вакцин нийлүүлэх магадлалтай.

Нөгөөтээгүүр, вакцин бүтээсэн туршлагаас үзвэл АНУ, Европын эрдэмтэд түрүүлж вакцин гаргах магадлал өндөр. Хэрэв АНУ-ын “Pfizer”, “BioNTech” компанийн вакцин эмнэлзүйн эцсийн туршилтаар үр дүнтэй нь нотлогдвол нийт 600 сая тунг АНУ-д, 30 сая тунг Их Британид, 120 сая тунг Японд захиалгын дагуу нийлүүлсний дараа бусад орны зах зээл рүү гаргах юм. Эл компани COVAX-д нэгдвэл 2021 оны эцэс хавиар манай улс вакцинтай болно гэсэн үг. Харин “Moderna” компани COVAX-д хамрагддаг тул 9-12 сард вакцины зөвшөөрлөө авбал 2021 оны дунд эсвэл эцэс гэхэд COVAX-ийн дүрмийн дагуу хүн амын 20 хувьтай дүйцэх буюу 640 мянган тун вакциныг Монголд нийлүүлэх боломжтой.

Их Британийн “AstraZeneca” компани, Оксфордын их сургуулийн Женнер институт, Оксфордын вакцины группийн тухайд 2021 онд COVAX-т эхний ээлжинд 300 сая тун нийлүүлэх хэлэлцээр байгуулсан. Тиймээс Монгол Улсын хүн амын 20 хувийг 2021 оны дунд эсвэл эцсээр Оксфордын вакцинд хамруулах боломж гарах юм.

Товчхондоо, эмнэлзүйн гуравдугаар шатанд буй вакцинууд 9-12 дугаар сард зохих байгууллагуудаас зөвшөөрөл авч, 2020 оны эцэс эсвэл 2021 оны эхэн үеэс вакцин үйлдвэрлэж эхлэнэ гэж тооцвол:

- Хятад, ОХУ-ын вакциныг 2021 оны эхэн эсвэл дунд;
- АНУ-ын “Pfizer”, “BioNTech” компанийн вакциныг 2021 оны эцэс;
- АНУ-ын “Moderna” компанийн вакциныг 2021 оны дунд эсвэл эцэс;
- Их Британийн Оксфордын их сургууль, “AstraZeneca”-ийн вакциныг 2021 оны дунд эсвэл эцсээр Монголд нийлүүлэх төлөвтэй байна.

Монгол Улсын иргэдийг вакцинжуулах хүртэл хилийн хориг, 21 хоногийн карантиныг цуцлах магадлал бага тул 2021 оны дунд эсвэл эцэс хүртэл аж ахуйн нэгж хэвийн амьдралдаа орохгүй. Үүнийг иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого зэрэг цар тахлын эсрэг арга хэмжээ боловсруулахдаа Монгол Улсын төр, засаг анхаарах нь зүйтэй. ■

Сонирхолтой орчуулга

Ковид-19: Олон мянган хүний амь нас, олон их наядыг хэрхэн аврах вэ

Хорио цээрийн дэглэмийг цуцлах нь дангаараа бизнесийн итгэл эсвэл эдийн засгийн өсөлтийг сэргээж чадахгүй. Цар тахлыг хяналтад оруулсан цагт л эдийн засаг өсөж эхэлнэ


Хүмүүсийн амь нас, тэдний амьжиргааг хамгаалах хоёр чухал арга хэмжээ болон эдийн засгийн мөн Ковид-19-ийн үр дагаврыг тодорхойлсон есөн хувилбарыг “McKinsey & Company” энэ сарын 23-нд танилцуулсан (Зураг 1). Тухайн үед бид коронавирусийн тархалтыг 2-3 сарын дотор хяналтад оруулахуйц түргэн, үр дүнтэй арга хэмжээ авах нь хамгийн зөв гэж бичиж байв. Түүнчлэн бид тавдугаар сард вирусийн тархалтыг тэг болтол багасгах замаар тодорхойгүй байдлыг арилгах нь ихэнх эдийн засгийн хувьд том “боломж” болно гэж үзсэн. Өдгөө гарын таван хуруунд багтахар тооны улс вирусийг хяналтдаа оруулж чаджээ (Ихэнх бүс нутагт эдийн засгийн сайн хариу арга хэмжээ авснаар эхний багананд дурдсан дүр зураг бараг л биеллээ олсонгүй). Бодит байдал дээр авч үзвэл вирусийг нэгэнт хяналтдаа оруулсан орнууд л “эхний эгнээний үр дүн”-д хүрсэн (хувилбар A3, A4) агаад ингэснээр ДНБ-ийг 2020 оны сүүлчээр 2019 оны эцсийн эсвэл түүнээс илүү түвшинд аваачих боломжтой. Вакцин гараагүй байгаа учир ихэнх улс “хоёрдугаар эгнээний үр дүн”-д (хувилбар A1 эсвэл A2) хүрэх нь дамжиггүй бөгөөд энэ нь эдийн засгийн сэргэлт нь 1-2 жилээр удаашрахыг дохиолж байна. Олон улсын томоохон компаниудын захирлууд ч үүнтэй санал нэг байгааг долдугаар сард явуулсан санал асуулгаас тэдний дийлэнх сөрөг хүлээлттэй байгаагаас харж болно.

Тоон үзүүлэлтүүд тодорхой байна. Улсууд хоёрдугаар улирлын ДНБ-ий үзүүлэлтийг мэдээлж эхэлсэн. Герман, АНУ-д 2019 оны дөрөвдүгээр улиралтай харьцуулбал 10.6 хувиар буурсан бол Испани, Их Британи улс бараг төсөөлөхийн аргагүй буюу 22.7, 22.1 хувийн бууралтыг үзүүлжээ. Ийм доод цэгээс гарахын тулд хоёр улирал дараалан 5-12 хувь өсөж байж ДНБ энэ оны эхний түвшинд хүрэх юм.

Өсөлт ингэж сэргэх боломж вирусийг хяналтдаа авсан орнуудад л тохиох боломжтой гэдгийг бидний шинэ судалгаа харуулж буй. Хэрэглэгч, бизнесийн итгэлийг сэргээх, өсөлтийг дэмжих нөхцөлүүдийг бий болгох эхний алхам бол энгийн түр зуурын хөл хорионоос илүүтэйгээр нийгмийн эрүүл мэндийн олон талт, цогц хариу арга хэмжээ авах явдал гэдгийг баримтууд нотолж байна.

Ингэх нь хямд тусахгүй. Вирусийг хяналтдаа оруулах зардал олон тэрбум, эсвэл хэдэн зуун тэрбум доллароор хэмжигдэх болов уу. Гэхдээ эл хүлээлтээс үүдэх алдагдсан боломжийн өртөг нь ►

Зураг 1. Ковид-19-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөний боломжит хувилбарууд



► хэдэн мянган хүний амь нас, их наядаар хэмжигдэх нь тодорхой. Хүлээлтийн нөлөө нь шугаман биш. Вирусийг хяналтдаа оруулалгүй өнгөрүүлсэн гурван сар тутамд ДНБ-ийг хямралын өмнөх

түвшинд аваачих хугацаа зургаан сараар хойшлох юм. Хүний амь нас, амьжиргааны аль альны дайсан нь цаг хугацаа болжээ.

Өсөлтийг өдөөхийн тулд юу хийх ёстой вэ

Коронавирус болон түүнээс үүдэлтэй хөл хорио нь эдийн засгийн идэвхийг урьд хожид байгаагүйгээр

доголдуулав. Улс, бүс нутгийн хэмжээнд 1994 оны Мексикийн песо, 1997 оны Азийн валютын хямралаас хойш, харин дэлхий даяар Дэлхийн II дайнаас хойш ийм ноцтой үр дагавартай үйл явдал

болж байгаагүй. Эдийн засагт цар тахлын үзүүлж буй нөлөөг хэмжихийн аргагүй бөгөөд хөл хориог цуцлах нь үүнтэй дүйцэх сэргэлтийг өдөөнө гэж үзэх нь гарцаагүй юм. Гэвч бодит баримтуудаас харвал эдийн засгийн нөлөө нь зөвхөн хөл хориог цуцалснаар хэмжигдэхгүй бөгөөд хөл хорио нь эдийн засагт ялгаатайгаар нөлөөлж байна. Хөл хорионы дэглэмийг цуцлах нь дангаараа хэрэглэгчдийн итгэл эсвэл эдийн засгийн өсөлтийг сэргээж чадахгүй.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн орнуудын ДНБ-ий бодит эсвэл хүлээгдэж буй уналт нь хөл хорионы чанга дэг, хугацаатай шууд холбогдохгүй байгааг бидний судалгаа харуулав. Хөл хорионы дэглэм чанга, сул байсан эсэх нь эдийн засгийн өсөлтөнд цар тахал ялгаатай нөлөөлж буйн зөвхөн нэг хэсгийг тайлбарлаж байна (Зураг 2).

Үүнтэй төстэйгээр удаан хугацаанд хөл хорионы дэглэм баримталсан болон хөл хориог харьцангуй эрт цуцалсан АНУ-ын мужуудын датанаас харахад ажил эрхлэлт, худалдан авагчдын зарцуулалтад төдий л ялгаа харагдаагүй.

Улс болон бүс нутгийн ялгаанаас илүүтэйгээр аж үйлдвэрийн бүтэц болон Засгийн газрын бодлогын хариу үйлдэлд их зүйл нуугдаж байгаа бололтой. Өөр бусад хүчин зүйл ч мөн нөлөөлж байна. Германы Төв банк зургадугаар сард мэдэгдсэнчлэн “Худалдан авагчид, бизнесүүдийн зан авир улам бүр болгоомжтой болж эхэллээ. Орлогын төсөөлөлтэй холбоотойгоор тодорхойгүй байдал өсөн нэмэгдэж, цар тахлын нөлөөнд өртөөгүй олон бүтээгдэхүүнийг ч худалдаж авах сонирхол нь суларсан” ажээ. Ковид-19 цар тахлын бий болгосон “тодорхойгүй байдлын шок” нь 2020 онд АНУ-ын ДНБ-ий бууралтын тал хувийг бүрдүүлнэ гэж нэгэн судалгаанд дурдсан нь бий.

“McKinsey”-ийн хийсэн шинэ судалгаанаас үзвэл нийт худалдан авагчдын тал хувь нь өдөр тутмын тогтсон хэв журмаа сэргээхээс “болгоомжилж” эсвэл “түгшиж” байгаа аж. Тэднийг тогтсон хэв журмаа сэргээхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг ч эл судалгаа олж тогтоосон юм. Судалгаанд оролцогчдын дөрөвний гурван хувь нь системийн шийдэл буюу вакцин, эмчилгээ шаардлагатай гэж үзсэн бол 30 орчим хувь нь хөл хориог цуцлахад өөрсдийгөө аюулгүй болсон гэж үзнэ хэмээжээ. Тэдний хариулснаар өөр гурван ►

Зураг 2. Хөл хорионы дэглэм чанга, сул байсан эсэх нь эдийн засгийн өсөлтөнд хэрхэн нөлөөлөв


Хөл хорионы дэглэм, индекс

100= хамгийн чанга, 2020.III-VI


Хамгийн чанга 4 долоо хоногийн дундаж

4 сарын дундаж

Улсуудын хамгийн чанга 4 долоо хоногийн дундаж



ДНБ-ий өөрчлөлт, 2019 IV улирал-2020 II улирал, %



► хүчин зүйл шийдвэр гаргалтанд нь нөлөөлөх бөгөөд тэд бол: хүмүүс маск өмссөн байх (75 хувь), хот, мужид нь халдвартай хүмүүсийн тоо буурах (65 хувь), үндэсний хэмжээний эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд өдөр тутмын үйл ажиллагааг сэргээхийг зөвлөх.

Эндээс хийж болох зайлшгүй нэг дүгнэлт бол Ковид-19 болон холбогдох эрүүл мэндийн эрсдэл нь маш олон хувь хүн, өрх айл, бизнесүүдийг албан ёсны хориг байхгүй байгаа үед ч хэвийн үйл ажиллагаа эрхлэхээс татгалзахад хүргэсэн явдал юм. Тэрхүү тодорхойгүй байдлыг үгүй хийх нь эдийн засгийг дахин сэргээхэд нэн чухал юм.

Өсөлтөд итгэл чухал

Олон нийтийн итгэлийг олох мөн таван итгэлийг (шинээр халдвар авагсдын тоо цөөн байх; хүндээр өвдсөн иргэдийг үр дүнтэй эмчлэх; найдвартай, үнэн зөв мэдээллээр хангах; үр дүнтэй, хангалттай эрүүл мэндийн арга хэмжээ авах; эдгээр арга хэмжээ нь эдийн засаг сэргэхэд саад болохгүй байх) бий болгох “жор” тодорхой бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхэд 12 орчим долоо хоног шаардагддаг байна. Иргэдийн итгэлийг сэргээсэн, эсвэл ингэхэд тун дөхсөн улсуудын эдийн засгийн идэвх дахин сэргэж эсвэл хямралын өмнөх түвшинд хүрч эхэлж байна. Коронавирусийн халдвар болон тестлэх үйл явцын анализуудыг харьцуулж үзэхэд вирусийг хяналтдаа оруулах ялгаатай стратегиуд нь эдийн засгийн маш ялгаатай үр дүнд хүргэснийг харж болно. Вирусийн тархалт бага улсууд нь тархалтыг эрчимтэй тогтоон барьж, халдварлах боломжийг аль болох багасгасан нь гэнэтийн дэгдэлтийг хянахад хялбар болгожээ. Эдгээр улсын удирдагчид олон нийтийн итгэлийг бэхжүүлж, үүний хариуд иргэд нь эдийн засгийн идэвхээ сэргээсэн байна. Эдгээр улс эхний баганын үр дагавар буюу А3 эсвэл А4 хувилбарт хүрэх боломжтой юм. Харин “тогтворжуулах арга” стратегийг баримталсан улсууд эрүүл мэндийн системийн хүчин чадлын хэмжээнд өвчтөнүүдийн тоог барихыг хичээх, халдварын тоо их байхыг хүлээн зөвшөөрөх, эдийн засгийг хязгаарласан эрүүл мэндийн арга хэмжээ авахаас өөр аргагүй болдог. Ийм нөхцөлд тухайн улсын удирдагчдын хувьд ард иргэдийнхээ итгэлийг бий болгох, тогтоон барих нь тун адармаатай байх болно. Иргэдийн идэвх хямралаас өмнөх үеийн 40

Зураг 3. Удах тусам олон тэрбум доллар алдаж, олон мянган хүний амь хохирно

ECD улсуудын ДНБ-ий нийт алдагдал ¹, индекс (1=А3 хувилбар)

Хувилбар А3	-1.0	
Хувилбар А2	-3.5x	
Хувилбар А1	-5.5x	
Хувилбар В2	-9.0x	

¹Улирал тус бүрийн алдагдлыг цар тахлын өмнөх 2020 оны нэгдүгээр сарын таамагтай харьцуулав
Эх сурвалж: McKinsey Analysis, Oxford Economics

орчим хувьтай тэнцүү байна. “Тогтворжуулах арга” стратегийг хэрэглэж буй улсууд А1 зэрэг хоёрдугаар баганын үр дагавартай нүүр тулах магадлалтай.

Эл стратегийг ашиглаж буй улсууд хэрэв шуурхай ажиллаж чадвал 2020 оны эцсээр “вирусийн тэг түвшин” стратеги руу шилжиж, иргэдийнхээ итгэлийг сэргээх боломжтой юм. Эдийн засгийн идэвх хэсэг хугацаанд сул хэвээр байх бөгөөд эдгээр улс коронавирсийн тест, халдвартай хүмүүсийг олж тогтоох, хянах зэрэгт олон арван эсвэл олон зуун тэрбум долларын шууд зардал гаргахаас өөр аргагүй юм. Гэвч алдагдсан боломжийн өртөг үлэмж их. Жишээлбэл, OECD-ийн гишүүн орнууд вирусийг хяналтдаа оруулалгүй алдах гурван сар тутамд ДНБ нь хямралын өмнөх түвшинд очих хугацаа зургаан сараар хойшилно (Зураг 3) гэдгийг бид тооцоолсон юм.

2020 оны нэгдүгээр сартай (хямралын өмнөх үе) харьцуулахад OECD-ийн гишүүн орнууд 2024 он гэхэд нийт ДНБ-ээс 10 их наяд орчим доллар алдах аж. Энэ бол А1, А2, А3 хувилбаруудын хувьд дундаж үзүүлэлт болно. Эдгээр хувилбар бүрийн ялгаа нь асар их: хэрэв тухайн улс А1 хувилбарт багтвал А3 хувилбараар явснаас 5.5 дахин их алдагдал хүлээх юм.

“Тогтворжуулах арга”-ыг хэрэгжүүлж буй улсуудын хувьд иргэдийнхээ амь нас, амьжиргааг илүү дээр байдлаар авч гарахад нь хугацаа бас ч гэж бийг эцэст нь сануулья. ■

“McKinsey & Company”-ийн бэлтгэсэн “COVID-19: Saving thousands of lives and trillions in livelihoods” судалгааг товчлон орчуулав.

Абэгийн дараа

Японы шинэ Ерөнхий сайд үлэмж их өр, цөөрч буй хүн ам, ширүүн Хятад, тааварлашгүй Америктай тулна.

Абэ Шинзо наймдугаар сарын 28-нд Токио хотод зарласан хэвлэлийн бага хурал дээр эрүүл мэндийн шалтгаанаар албан тушаалаа орхиж буйгаа зарлав. Эрх баригч Либерал ардчилсан нам (ЛАН) шинэ даргаа сонгох санал хураалт явуулах хүртэл тэрбээр Ерөнхий сайдын үүрэгт ажлаа гүйцэтгэсэн хэвээр байх юм. Өнгөрсөн долоо хоногийн эхээр ноён Абэ эцгийн авга ах Эйсакү Сатогийн амжилтыг эвдэж, Япон улс XIX зуунд Ерөнхий сайдын албыг бий болгосноос хойш эл албан тушаалыг хамгийн олон жил дараалж хашсан (2006-07 онд мөн энэ албыг

Өнгөрсөн сард эмнэлэгт хоёр ч удаа үзүүлснийх нь дараа ноён Абэгийн эрүүл мэнд олон нийтийн анхаарлыг татсан. Тэрбээр Ерөнхий сайдаар анх сонгогдон ажиллаад нэг жил ч болоогүй байхдаа бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн улмаас албаа орхиж байсан юм. Гэвч энэ удаагийн шийдвэр нь түүний хамгийн ойрын хүмүүст ч шок болсон аж. “Би хэнтэй ч зөвлөлгүй шийдвэрээ гаргасан” хэмээн ноён Абэ хэлсэн бөгөөд үүний шалтгаан нь өвчин нь байнга дахих болсноос үүдэлтэй гэж тэмдэглэн хэлсэн юм. Түүний ажлын албаныхан хэлэх үгийг нь телепромптерт ч оруулж амжаагүй аж.

Абэгийн залгамжлагчийг сонгох нь ЛАН-ын дотоод хэрэг байх болно. Намын даргыг сонгох сонгууль ойрын хэдэн долоо хоногт явагдах хүлээлттэй байна. Сонгуульд ялагч нь ноён Абэгийн үүрэгт хугацаа дуусах хүртэл Ерөнхий сайдын албыг хаших юм. Үүний дараа буюу ирэх оны есдүгээр сард намын даргын дахин сонгууль явагдана. Түүний үнэнч шадрууд болох Ерөнхий сайдын орлогч Асо Таро, Сайд нарын танхимын дарга Сүга Ёшихидэг ноён Абэгийн бүрэн эрхийн хугацааг дуустал Ерөнхий сайдын албыг хаших боломжтой нэр дэвшигчдээр эн тэргүүнд нэрлэж байна.

Гэвч энэ нь Японы улс төр, тус улсын бүхий л үйл хэргийг баттай атгасан тус намын удирдлагын төлөөх илүү том өрсөлдөөнийг түр хойшлуулах юм. Батлан хамгаалах болон Хөдөө аж ахуйн сайд асан Ишиба Шигэрү сонгогчид болон ЛАН-ын гишүүдийн дунд нэр хүндтэй нэгэн боловч парламентын гишүүдийн дунд танил биш. ЛАН-ын

хашиж байсныг нь тооцвол түүнийг аль хэдийнэ дээд амжилт тогтоосон байсан гэж үзэж болно) эрхэмээр тодорсон билээ. Намын даргаар ажиллах хугацаа нь өндөрлөхөд нэг жил хүрэхгүй хугацаа үлдээд байсан тэрбээр албан тушаалаа ийн гэнэт орхисноор эх орноо тодорхойгүй үе руу түлхэн оруулав.



► бодлого хариуцсан захирал Кишида Фүмиог ноён Абэ өөрийн залгамжлагчаар сонгох магадлалтай гэж яригддаг ч тэрбээр олон нийтийн дэмжлэгийг өнөөг хүртэл авч чадаагүй л байна. Бусад боломжит нэр дэвшигчдийн тоонд Батлан хамгаалахын сайд Коно Таро, Гадаад хэргийн сайд Мотэги Тошимицү орж буй. Тэдний өрсөлдөөн бодлогын гэхээсээ тооны болон хувь хүний шинжтэй байх болов уу.

Ноён Абэ Японы эдийн засаг, олон улсад эзлэх байр суурийг нь сэргээх чин хүсэлтэйгээр 2012 онд Ерөнхий сайд болсон. Тэрбээр 2013 онд Вашингтонд үг хэлэхдээ “Япон эргэж ирлээ” гэж мэдэгдэж байв. Тэрбээр эл албыг бараг найман жил хашихдаа мөнгөний бодлогыг зөөллөх, төсвийг тэлэх, бүтцийн эрс шинэчлэлт хийсэн нь “Абэномикс” хэмээн нэршсэн юм. Эдгээр бодлогын үр дүнд эдийн засгаа дефляцаас гаргасан (гэхдээ инфляцын хэмжээ Японы төв банкны зорилтот хоёр хувьд огт хүрээгүй). Түүнчлэн эдийн засгийг бэхжүүлэх, он удаан жил төрийн ивээлд байсан фермерүүдийг өрсөлдөөнд оруулах, ажиллах хүчний дутагдлыг нөхөхийн тулд улам олон цагаачдыг хил нэвтрүүлэх зэрэг амаргүй реформыг тэрбээр гардан гүйцэтгэсэн билээ.

Ноён Абэ батлан хамгаалахын төсвийг нэмж, цэрэг армия өөрийн улсын хилээс гадна үүрэг гүйцэтгэх боломж олгосон хуулийг батлуулах зэргээр Японы Өөрийгөө хамгаалах хүчнийг бэхжүүлсэн. Америктай, ялангуяа Дональд Трампыг Ерөнхийлөгч болсны дараа харилцахдаа тэрбээр гаргуун байлаа. Түүний манлайлал дор Япон улс Европын холбоотой Эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ үзэглэж, Америк гарсны дараа Транс-Номхон далайн түншлэлийг аварч, Хятадын сэргэлтийг сөрөхийн тулд Азийн улсуудтай харилцаагаа улам батжуулах замаар чөлөөт худалдаа, мультилатерализмын аварга болж чадсан. Ноён Абэ албан тушаалаасаа огцорсны дараа Австралийн Ерөнхий сайд Скотт Моррисон “Тэр бол манай бүс нутаг төдийгүй дэлхийн хэмжээний мундаг улс төрч” гэж мэдэгдсэн юм.

Гэвч ноён Абэ амаргүй цаг үед үүрэгт ажлаа орхиж байна. Уг нь тэрбээр ялгуусан 2020 оныг төсөөлж байсан. Япон улс энэ зун зуны олимпын наадмыг зохион байгуулж, Ерөнхий сайдын суудлаа орхих нөхцөлийг тэр өөрөө тодорхойлох ёстой байв. Гэтэл цар тахлын улмаас олимпын наадам хойшилж, эдийн засаг нь уналтад оров. Дотоодын нийт бүтээгдэхүүн энэ оны хоёрдугаар

улиралд эхний улиралтай харьцуулахад 7.8 хувиар буурсан нь түүхэн дээд үзүүлэлт болж, инфляцыг тооцож үзвэл эдийн засгийн өсөлт түүнийг 2012 онд Ерөнхий сайд болсон үеийнхээс доогуур түвшинд хүрэв. Ноён Абэ өөрийн мэдэгдэлдээ дурдсанчлан, тэрбээр хэд хэдэн чухал зорилтоо биелүүлж амжсангүй: Дэлхийн II дайны дараа Японд ногдуулсан Америкийн зарим пасифист журмуудад өөрчлөлт оруулах, олон жил үргэлжилж буй газар нутгийн маргааныг Оростой тохиролцон эцэслэх, Хойд Солонгост хулгайлагдсан япон иргэдийг эргүүлэн авчрах. Үүн дээр ноён Абэг шүүмжлэгч нар бүтцийн реформ нь, нэн ялангуяа дижиталчлал, бизнес болон Засгийн газарт албан тушаал дэвших боломжийг эмэгтэйчүүдэд илүүтэй олгох зэрэг нь тэр бүр амжилттай болоогүй, Японы милитарист түүх нь Өмнөд Солонгостой харилцах харилцаанд сөрөг нөлөөтэй байсныг үл тоомсорлосон гэж нэмж буруушаах биз ээ.

Түүнийг залгамжлагчийн эн тэргүүний үүрэг нь Ковид-19-ийн нөлөөг зохицуулахад оршино. Энэ нь шинэ Ерөнхий сайдын өвлөж авах урт хугацааны сорилтуудаас, тухайлбал үлэмж хэмжээний өр, тасралтгүй буурч буй хүн ам, Хятад хэмээх ширүүн хөрш, Америк хэмээх таамаглахын эцэсгүй хамтрагчаас ч илүү хялбар байж мэднэ. Энэ бүх асуудлыг шийдвэрлэх арга замыг олоход ноён Абэгийн үлдээж буй хамгийн чухал өв тус болно. Тэр бол шийдвэр гаргах эрх мэдлийг Ерөнхий сайдын албанд төвлөрүүлсэн нь юм. Түүх сөхвөл хэн нэгэн Ерөнхий сайдаар олон жил ажилласны дараа богино настай, иргэдийн итгэлийг хүлээгээгүй Засгийн газрууд Японд ээлж дараалан солигддог аж. Ноён Абэ 2012 онд албан тушаалдаа суухаас өмнө Япон улс зургаан жилийн хугацаанд зургаан Ерөнхий сайдын (үүнд ноён Абэ өөрөө орно) нүүр үзсэн билээ. Япон улсыг дахин ийм тогтворгүй байдал отоож байж ч мэдэх юм. ■

© 2020 The Economist Newspaper Limited. Бүх эрх хамгаалагдсан.

The Economist сэтгүүлээс олгосон лицензийн дагуу **Mongolian Economy** орчуулав. Нийтлэлийн эхийг англи хэлээр www.economist.com сайтаас уншина уу.

Энэ бүх асуудлыг шийдвэрлэх арга замыг олоход ноён Абэгийн үлдээж буй хамгийн чухал өв тус болно. Тэр бол шийдвэр гаргах эрх мэдлийг Ерөнхий сайдын албанд төвлөрүүлсэн нь юм.

Доналд Трамп, тохиолдлоор Хятадад дайсагнагч

Шинжаанаас Тайвань хүртэл Хятадын хязгаар нутгууд таахын
аргагүй эрсдэл, аюулын эх үүсвэр болно

Давид Ренни

Бээжин
салбарын
тэргүүн, Чагуан
тоймч, The Econ-
omist БЭЭЖИН



Ерөнхийлөгч Доналд Трамп олон жил Хятадад дайсагнагчийн дүрд тоглосоор ирэв. Бээжин хэмжээлшгүй их эрх мэдлээ тогтоох гэж зүдэрдэг Хятадын хязгаар нутгууд, хилийн бүс, маргаантай газар нутагт 2020 онд өрнөх үйл явдлууд түүнийг Хятадын улс төр, үзэл санааны эх үндсийг үгүйсгэх жинхэнэ дайсагнагч бодлого руу түлхэж магадгүй. Ноён Трампыг

Хятадад зөөлөн ханддаг гэх нь хачирхалтай санагдаж магадгүй. Америкийн эдийн засгийг “хүчиндэх”-ийн тулд валютын ханшаа зориудаар удирддаг гэж тэрбээр Хятадыг буруутгасаар сонгуульд оролцсон. Харин ерөнхийлөгч болоод тарифын дайн зарлав. Үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулах эрсдэлтэй гэж үзсэн Хятадын компаниудад, тэр дундаа технологийн ►

► аварга Хуавэйгийн эсрэг хориг тавихыг түрэмгий туслах, албатууддаа тэрбээр зөвшөөрсөн. Мөн Хятадын тагнуулч, нөлөөллийн агентуудыг баривчилж, Хятад өөрийн нэг мужаа гэж зарладаг 24 сая хүн амтай Тайваньтай цэргийн харилцаагаа шинэ түвшинд гаргав.

Хятадын орчин цагийн мандан бадралыг залуурдсан зарчмууд бол гадаадын өрсөлдөгчдийг дээрэлхэх эсвэл хөөх зуураа дотоодын ялагчдыг гаргаж ирэхийн тулд засгийн газрын зузаан түрийвч, хуулийн эрх мэдлийг ашиглах байлаа. Үүнийг болон авторитар улс төрийн системээс төрийн капитализм руу шилжсэн явдлыг эсэргүүцэхийг хэрэв түрэмгий зан гэж үзэх юм бол ноён Трамп үнэндээ уламжлалт төрлийн дайсагнагч биш юм. Харин ч ноён Трамп Хятадыг худалдааны ов мэхийнх нь төлөө шүүмжилдэггүй, удирдагчдыг нь ухаантай гэдэг. Энэ нь ерөнхийлөгч болон Хятадын хийх ёстой бүтцийн өөрчлөлт, жишээ нь зах зээлээ гадаадын фирмүүдэд нээх ёстой гэх мэт зүйлийн жагсаалтыг гаргасан түшмэлүүдийнх нь хоорондох ялгааг харуулж байна. Гэтэл үүний эсрэгээр өөрийнх нь ногдуулсан тариф Америкийн бизнесийг Хятадаас гаргах сэдэл төрүүлж байна гэж тэрбээр онгирч буй. Үндэстэн дамнасан компаниудад шинэ зах зээлд гарах нь гол зорилго биш мэт санагдах аж. Ноён Трамп илүү нарийн асуудлаар хөөцөлдөж буй. Тодруулбал, хятадуудыг Америк бараа, нэн ялангуяа арваннэгдүгээр сард ахин сонгогдохын тулд фермерүүд голлосон мужуудаас худалдаж авахыг, ингэснээр худалдааны алдагдлыг бууруулахыг тэр хүсэж байна.

Америкт сонгууль болох жил Хятадтай ширүүн харьцлаа гээд улс төрийн хувьд алдах зүйл үгүй бол өнөөг хүртэл түүний зайлсхийж ирсэн хүйтэн дайны үеийнх шиг сөргөлдөөн рүү өөр үйл явдал хөтөлж магадгүй. Америк иргэдийн санал бодлыг татахад төгс нийцсэн хямралд автаад буй Хонконгоос эхэлье. Либерал үзэл бодолтой, англиар ярьдаг оюутан залуусаас голдуу бүрдэх ардчиллын төлөө тэмцэгчид бороохой агссан цагдаа нартай тулж байна. Хонконгийн жагсаалыг Бээжин хариуцах ёстой “үймээн” хэмээн 2019 онд үл хайхарсан алдаагаа ноён Трамп давтвал ардчилсан намынхан түүний энэ алдаан дээр ажиллана. Хэрэв эх газрын цэрэг халдаж, цус урсгасан аймшигт хэрэг үүсвэл конгрессийн

бүгд найрамдах намынхан ардчилсан намын гишүүдтэй нэгдэж Хятадын албаны хүмүүст хориг тавих, Британийн колони асан улсад үзүүлсэн худалдааны таатай байдлыг ахин авч үзэхийг шаардах болно.

Хятадын алс баруун хязгаар болох Шинжаанд уйгур болон исламын шашинт үндэсний цөөнхийг харгис, хэрцгий аргаар хяхан хавчиж байгаа нь хүний эрхийн талаарх маргааныг сонгуулийн жилд улам дэвэргэнэ. Мөн ноён Трамп яагаад тэдний талаар бараг ам нээдэггүй талаар маргаан дэгдэж, доодох хүмүүс нь үүнд хариулах шаардлагатай болно. Төвөдөд дараалсан хямрал гарвал тэрхүү гаслантай, алслагдсан нутаг ахин олны анхааралд ирнэ. Төвөдийн оюун санааны удирдагч Далай лам 2020 онд 85 нас хүрнэ.

Америкийн ардчилсан холбоотнуудын аюулгүй байдлыг хамгаалахад ноён Трамп (сул) анхаарч буй нь 2020 оны нэгдүгээр сард ерөнхийлөгчийн болон хууль сахиулах байгууллагын сонгууль болох Тайванийн асуудлаар сорилтод орно. Тайванийг эх газрын Хятадын нэг хэсэг болгох уриалгыг эсэргүүцдэг, “нэг улс, хоёр систем” гэсэн уриан дор автономит эрх амлаж буй Бээжингийн амлалтад итгэхгүй байх шалтгаан нь Хонконг болж байна гэж үздэг одоогийн ерөнхийлөгч Цай Ин-вэнд Хятадын засгийн газар дургүйлхдэг. Трампын төлөө ажилладаг дайсагнагчид Тайваньтай харилцаагаа бэхжүүлэхээр ажиллаж буйд Хятад бухимдсаар ирсэн. Хэрэв Цай ахин сонгуульд ялвал Хятадын түрэмгийлэл нэмэгдэж, Америк үүнд хариу өгөх ёстой болно. Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын армийн өдөөн хатгалгыг ноён Трамп үл хайхарвал түүнийг шүүмжлэгчдийн бах ханаж, сэргэнэ. Учир нь либерал, хуульд суурилсан дэг журмын маргаангүй хамгаалагч нь Америк гэсэн ойлголтыг Америкийн ерөнхийлөгч үл тоомсорлодог.

Товчхондоо Хятадын хязгаар нутгууд тааварлахын аргагүй эрсдэл, аюулын эх үүсвэр болно. Америк-Хятадын харилцааны гол цөмд байгаа худалдааны дайн дээр эдгээр аюулыг нэмэх ёстой. Хятад улс Айова мужаас буурцаг авах боловч эдийн засгийн шинэчлэлээс бултсан тааруухан худалдааны хэлэлцээр Трамп байгуулна гэж шүүмжлэгчид анаж буй. Өөрийгөө Хятадыг өвдөг сөхрүүлж чадах “сонгомол” удирдагч гэж зарласандаа Трамп 2020 онд харамсах болно. ■



Д.БАЯРХҮҮ

(Олон улсын харилцааны судлаач,
профессор)

Лукашенко: Төгсгөл ба надад үлдэх сэтгэгдэл

"Чи хэний талд вэ?" гэх айхтар тулгалтын сүүлчийн даваа!



Д.Баярхүү, А.Лукашенко нар 2015 оны есдүгээр сард Нью-Йорк хотод болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүндэтгэлийн 70-р чуулганы үеэр уулзаж, ярилцаж байв.

Энэ хүн хэзээ ч бууж өгөхгүй. Хорин хэдэн жил ганцаар засагласны үр дүн нь хэзээ ч бууж өгөхгүйгээр нь илрэх болно. АК буугаар зэвсэглэж, хүүгээ өвч бүрэн цэрэгжүүлээд нисдэг тэргээр нисч яваа нь эгэл бус, бүр стандарт бусын шинж. Галын шугамд зогсож буй цагдаа нар дээр очиж гараа гозолзуулан АК-гаа өргөж харагдав. Хилэнтэйгээр хашгичин занана. Улаа бутарсан баргар царай, арслан барсын зориг. Галын шугам дээр үхэхэд яг бэлхэн. 1973 онд Чилийн Ерөнхийлөгч С.Альенде Кубын удирдагч Ф.Кастрогийн бэлэглэсэн АК-аар зэвсэглэн хунтынхантай тулалдаж байгаад хорвоогоос хальсан түүх гэнэт санагдах шиг.

Лукашенко өөрийгөө маш чухал хүнд тооцчихсон, төр улсаа босгогч, бүтээн байгуулагч, тогтвортой байдлын баталгаа, хэрэв тэр албан тушаалаасаа явчихвал эх орон нь сөнөнө гэж хээвнэг ярьж чадна. Харин одоо өөртөө тэсч үлдэх (орогнох) орон зайгаа үеэ өнгөрөөсөн аргаар эрж хайж байна. Тэгсэн хэрнээ постсовет орон зайд нэг их санаа тавигч. Оройтсон л байх аа даа.

Румыний Н.Чаушеску, Египетийн Х.Мубарак, Иракийн С.Хусейн, Ливийн М.Каддафи, Хойд Солонгост гурван үеийн Ким шиг л ард түмнээ харааж загнаад, уурлаж бухимдаад, бурууг ард түмэндээ тохоод, цэрэг армия хөдөлгөөд сууж байх үйлтэн.

Олон улсын мэдээллийн их далайн зах сэжүүрээс эшилье. Ихэнх судлаач, эксперт, аналитууд ганц л дүгнэлт хийж байна: "Беларусийн эрх баригчдын хоногийн тоо дууссан, тэсч тогтох тун бага хугацаа үлдлээ!"

Оросын "Стратегия" аналитик төвийн захирал Виктория Василевич шуудхан "Александр Лукашенкогийн толгойлж буй дэглэм нас барчихлаа. Лукашенко Европт персон нон-грата гэдгээр зарлагдсан. Түүнийг сонгогдсон Ерөнхийлөгч гэж Европын улсууд үзэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй, олон улсын тавцан дээр тэр нөхөр улс орноо бүрэн эрхтэй, нэр нүүртэй төлөөлж чадахгүй" гэжээ.

Нэг. Москватай юу, эсвэл Вашингтон-Брюссельтэй юу?

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров ингэж ярьдаг, Беларусьг өрнөсөн саяхны үйл явдлыг ч тэгж дүгнэсэн. Юу гэвэл "Өнөөдөр хуучин СССР-ийн орон зайг хэн нь эзэгнэх вэ гэсэн геополитикийн тэмцэл өрнөж байна. Энэ бол Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудал биш, эсэргүүцлийн хөдөлгөөн биш, энэ бол Москватай ►

► хамт уу, эсвэл Вашингтон, Брюссельтэй хамт уу гэдэг сонголт хийх, хийлгүүлэхийн төлөөх тэмцэл. Ийм тулгалтын эсрэг Оростойгоо хамт итгэлтэй сөрөн зогсож буй беларусь ахан дүүсийнхээ үйл ажиллагааг Москва өндөр үнэлж байна”.

Беларусьт өрнөсөн үйл явдлын утга санаа ердөө л энэ.

Кремлийн үзэж буйгаар ардчиллын төлөө тэмцлийн тухай яриа байхгүй, Орос эргэн тойрныхоо ах дүү, түнш, холбоотон орнуудыг (Гүрж, Украин хоёр эргэлтгүй цаашаа харсан, Армени магадлалтай, одоо Беларусь?) дараа дараалан алдаж байгаа, нэг ёсондоо Орос орны үхэх сэхэхийн төлөө тэмцлийн салаа салбар нь Минскт дэгдээд ирсэн тухай С.Лавров битүүхэн ярьсан болов уу.

Хайр сэтгэлээсээ хагацаж байгаа хартай эхнэрийн авир гаргах Оросын байр суурийг бид ойлгож байна. Олон талаасаа хавчигдаад, шүүмжлүүлээд, боорлуулаад ирэхийн цагт маш эмзэг болчихдог хүний араншин Кремлийг нөмөрчихсөнд би хувьдаа үнэхээр харамсаж байна. С.Лавровын байр суурь үүнийг хэлээд өгч байгаа юм биш үү?

Чи хэний талд вэ, Москвайтай хамт уу, эсвэл Вашингтон, Брюссель рүү эргэх үү гэхэд бүгдийг нь сонгоод, улс төр-батлан хамгаалахын харилцаагаа сүүлийн хоёр руу нь залчихсан “гэмтэн” бол монголчууд бид юм. Оростой харилцаад, бусадтай нь бүр болих хэрэгтэй, ШХАБ-д жинхэлж аваад Орос, Хятадтайгаа хамтран хөгжих хэрэгтэй гэх зарим монголчуудын хүслийг Беларусь дээр жишээлээд үз дээ.

Хэрэв Лукашенко энэ удаа тэсч тогтоод үлддэг юм бол бараг энэ жилдээ ШХАБ-д жинхлэх өргөдлөө өгөөд Орос лоббидоод удахгүй жинхлүүлчихнэ. Белоруссын халуун өдрүүдтэй давхцаад Москвад ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын зөвлөлийн хуралдаан тохиож, тэр хуралд Хятадын Гадаад хэргийн сайд Ван И үг хэлэхдээ ШХАБ-ын бичигдээгүй нэг зорилгыг илээр зарлав. Юу гэвэл ШХАБ-ын гишүүн орнуудын дотоод хэрэгт оролцохыг хүлээн зөвшөөрөхгүй, бүс нутагт өнгөт хувьсгал дэгдэхийг гаргуулж болохгүй гэв. Ганц энэ л Лукашенкод ялалтын итгэл өгсөн болов уу.

Гадаад байдал нь тун таагүй байгаа Иран, дотооддоо лалын алан хядагчдаа барахаа байсан Афганистан ШХАБ-д жинхлэх тухай олон жил

мөрөөдөн буй. Нэгэнт л өнгөт хувьсгалыг тас хорино гэсэн уриатай нь тодорхой болсон бол Белорусс ШХАБ-д жинхлэхэд буруу нь юу байна. Одоо гурвууланг нь жинхлүүлээд авбал мөн ч сайн санж. ШХАБ өргөжин тэлэхийг туйлаас дэмжиж байна. Монгол бол тэртэй тэргүй ШХАБ-ын маш идэвхтэй ажиглагч улс хэвээрээ нэг хэсэгтээ үлдэж болно. Жинхлэх эсэх нь манай бүрэн эрхэд хамаарна. Газар нутгийн маргаанаасаа болоод хоёр биенээ сөнөөх шахааж буй Армени, Азербайжан хоёр ШХАБ-ын ажиглагч больё гэж уйгагүй лоббидож буй. 2012 онд энэ хоёр улс, мөн Бангладеш, Балба, Шри-Ланка тавуулаа ШХАБ-ын ажиглагч болохоор өргөдлөө өргөн барьсныг бид дэмжих хэрэгтэй. Манайтай зэрэгцээд ороод ирэг, олуулаа болох сайхан. Цаашлаад ажиглагчийн нөөцөнд Египет, Сири, Израиль, Мальдив, Украин, Ирак, Саудын Араб, Бахрейн, Катар гээд жагсаж байна. Беларусь Монголоос түрүүлж ШХАБ-д жинхлэхийг үзэх хувьтай төрсөндөө би л лав баярлах болно.

Хоёр. Беларусь анхнаасаа л Оросын эргүүлгийн улс

Энд СССР-ийн үеийн Зөвлөлт Беларусийн тухай ярихгүй. СССР тарлаа, суурин дээр нь орон зайг нь хуваагаад 15 улс тусгаар тогтнолоо зарлалаа. Тэгш эрхтэй, харилцан ашигтай, харилцан хүндэтгэсэн, найрсаг харилцаат түншүүд байх болов уу, тэд бүгд ардчиллын зам сонгох болов уу хэмээн ертөнц тэр чигтээ харж хүлээсэн. Нэг хэсэг буруу замаар будилсан Орос бэхжээд ирмэгцээ тэдгээр улсуудыг өрнө ба дорно гэсэн хоёр замын аль нэгийг сонгохыг, хоёр дахь зам руу ханараад ороод ирсэнийг нь холбоотноороо зарлахыг тулгасан. Оросын итгэлийг 100 хувь олсон, ёстой эргэлтгүй болсон цорын ганц улс нь Беларусь болж таарсан.

Эдүгээ Орос өөрөө түншүүддээ хатуу шалгуур тавьдаг, цаадуул нь тэр шалгуурыг давах гэдэггүй, ерөөсөө даяаршсан, интеграцчилагдсан өнөөгийн ертөнцөд ганц Москвагаас хамааралтай байа гэдэггүй. Америкийн профессор Стефен Бланкийн үздэгээр бүслэлтийн менталитет ►

Хайр сэтгэлээсээ хагацаж байгаа хартай эхнэрийн авир гаргах Оросын байр суурийг бид ойлгож байна. Олон талаасаа хавчигдаад, шүүмжлүүлээд, боорлуулаад ирэхийн цагт маш эмзэг болчихдог хүний араншин Кремлийг нөмөрчихсөнд үнэхээр би хувьдаа харамсаж байна

► Оросыг нөмөрчихсөн, “дайсагнагч капиталист хүрээлэлд бүслэгдсэн, Оросоос бусад ертөнцтэй үргэлжлэн дайны байдалд оршиж байх ёстой” гэсэн сэтгэхүйтэй. Иймээс Орос нь бусад хөршдөө хяналт тавихын төлөө л ажиллаж байдаг. Энэ бол их гүрний араншин, их гүрний геополитик!

Ийм өнцгөөс Беларусийг харах хэрэгтэй. ОХУ-тай хамтран Холбооны улс байгуулах гэрээтэй, хэтдээ нэг улс болох тавилантай Беларусь өнөөг хүртэл оршиж байна. Европын Холбоо ба НАТО-г сөрөхүйц, Европын Холбоо ба НАТО-г бүдгэрүүлэгч их хүч байгаасай хэмээн оросууд үзэж, ОДКБ (Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага), ШХАБ, Евразийн эдийн засгийн холбоог байгуулж төлөвшүүлсэн. ШХАБ-аа Орос, Беларусь, Казахстан, Армени, Киргизийн гишүүнчлэлтэй Евразийн эдийн засгийн холбоо–Гаалийн холбоо гэгчтэй холбохыг зорьсон. Бараг ч холбочихсон болов уу. Ингээд Оросыг тойрсон бат цул орон зай үүсээд бүрэн бэхжүүлж амжаагүй байтал Беларусь өнгөт хувьсгалын босгон дээр тулж ирэв ээ. Оросын хувьд ёстой гай!

Хэрэв өнгөт хувьсгал тус орныг нэрвэбэл Оросын геополитикийн баталгаанд ноцтой байдал үүснэ. Славяны ертөнц дэх сүүлчийн гол холбоотноосоо хагацахаас гадна шууд хил залгаа бүс нутгаа Европын, НАТО-ийн хамар дор сул хаяж өглөө гэсэн үг болно. “Европын Беларусь” засгийн эрх авбал дуусах нь тэр.

Яг одоо оросуудын сэтгэлийг юу зовооно вэ? “Европын Беларусь” гэх ерөнхий им тамгатай. Өрнөдийн тал баримтлагч “Засгийн эрхийг шилжүүлэн авах, зохицуулах зөвлөл”-д засгийн эрх шилжвэл хэрэг бишдэнэ. Тэд Беларусийг ОДКБ гэх цэргийн эвслээс, улмаар Холбооны улсаас гаргана, Оросын телевизийн сувгуудыг хаана, орос хэлийг хэвлэл мэдээллээс хасна, дараа нь Оросын баруун хил дээр “санитарный кордон” буюу “ариун цэврийн зурвас” буй болгоно. Энэ бүхэн Орост тун ноцтой тусна хэмээн Оросын улс төр судлаач Ростислав Ищенко үзэж байна. Түүний олж харснаар, засгийн эрх солигдох нь асуудал биш, түүнд олон хувилбараар Москва бэлтгэлтэй байгаа, гэхдээ л А.Лукашенкогийн дэглэм унавал Оросын хувьд Украины араас бичигдэх үндсэн асуудал болох ажээ.

Миний ажигласнаар Беларусьт Донбасс шиг орос хэлтэн, орос үндэстэн хэдэн саяараа

оршин суудаг муж байхгүй тул Орос тэнд бамбай жийргэвч бүс байгуулж чадахгүй. Беларусь нь хойшоо ч, баруушаа ч шууд НАТО-той хиллэнэ. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл, Евразийн эдийн засгийн холбоо, ОДКБ, Гаалийн холбооноос тус улсыг гаргахыг уриалагчид засгийн эрх авахгүй гэх баталгаа байхгүй. Өөрөөр хэлбэл Оросын хувьд эцсийн найдвар нь “Батка”!

Гурав. Өнгөт хувьсгал айсуй!?

Беларусьт үе үе улс төрийн тэмцэл өрнөж, дарагдаж, нууцаар бугшиж, дараа нь ил болж ирсэн. А.Лукашенкод В.Путиных шиг цараа, зангараг илт дутаж байгаа нь саяхны Ерөнхийлөгчийн сонгуулийн дараах тэмцэл хөдөлгөөний үед тод харагдлаа. Тэрбээр Ерөнхийлөгчөөр удсан уу гэвэл удсан. Түүнийг удлаа гээд улс нь хөгжсөн үү (ядаж Казахстан шиг) гэвэл үгүй. Үе үе эр зориг гарган Оросыг өдөн дуудаж, элдэв муу үгээр дайрч шоглох маягаар Оросоос эдийн засаг-худалдааны ашиг хүртдэгийг нь үгүйсгэхгүй. Оросуудын дургүйг элдвээр хүргэхдээ гаргуун энэ нөхөр харин ойрмогхоноос Орост хошуу дэвсэн тусламж, ивээл хүсэх нь тун хачирхалтай.

Энэ улсын газар зүйн байршил, үндэстнийх нь бүтцийг аваад үзвээс яалт ч үгүй Европ ба Евразийн зааг дээр, тодорхой хэлбэл Өрнөд ба өрнөджиж буй Дорнод Европ, Оросын яг зааг дээр оршдог. Тэрхүү байршил нь дараагийн “Майдан” Беларусь болно гэх таамгийг аяндаа дэвшүүлээд гаргаад ирдэг болов уу. Тус улсын сөрөг хүчний нэг лидер, “Европын Беларусь” иргэний хөдөлгөөний зохицуулагч, “Хартия-97”-г үндэслэгч, одоо шоронд суугаа Дмитрий Бондаренко хэдэн жилийн өмнө “2017 он”-ыг “Беларусь Майдан” болно хэмээн ёрлож байсныг санаж байна. Мөн ондоо багтан Лукашенкогоо хөөж буулгана хэмээн тэрбээр хэв нэг ярьж байсансан. “Залхуурсны төлөө татвар” гэгчийг ард түмэндээ ногдуулсан, тэр нь ард олны дургүйцлийг дэвэргээд “Батка”-гаа үзэн ядах дээрээ туллаа хэмээн “Европыг хүсэгч” тэр нөхөр ярьж байв.

Сэдвээс түр хазайа. “Залхуучуудад ногдуулах татвар” гэдгийг тус улсад 2015 оны хавраас мөрдсөн. Насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвартай, гэхдээ хөдөлмөр эрхлээгүй бол жил бүр 250 ам.доллар төлж байх тухай, хэрэв эс ►

► төлбөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг энэ хуулийг уг нь манай Монголд хуулбарлаад хэрэгжүүлчихмээр санагддаг юм. Ингэх нь буруу биш, энэ цаг үед Монголд яг тохирно гэж би үзэж байна. Ажилгүйдэл, ядуурал, ажил хийх дургүйцлийн түвшинг хэмжиж үзэх аваас манай улс Беларусаас үлэмж дор муу байгаа.

Харин “Батька” маань эл хуулиа эх орондоо доозыг нь хэтрүүлээд ширүүлчихсэн бололтой, тиймдээ ч өнгөт хувьсгалын босгон дээр Беларусь орноо чирээд ирэх шиг. Үнэндээ тус улсын эдийн засаг барагтайхан байгаа. Хүмүүс ядуурч, үй олноороо ажилгүй, жижиг хотуудыг ажилгүйчүүд дүүргэсэн. Гэтэл А.Лукашенко иргэдийнхээ асуудлыг шийдвэрлэж чадалгүй олон жилийг үдсэн байх юм. Эдийн засаг сул, ард иргэд ядуу байвал нийгэм хэзээ ч тогтворжихгүй. Энэ бүхэн улс төржилтийг өөгшүүлнэ. Беларусь даяар сөрөг хүчний байгууллага, эвсэл холбоод борооны дараах мөөг шиг урган цэцэглэжээ. Тэмцэгчид нь урд өмнөхөөсөө илүү эр зоригтой, түрэмгий, өнгөт хувьсгалын технологид суралцсан аятай аяглана.

Дөрөв. “Батька”!

Аляксандр Рыгоравіч Лукашэнка гэж төрөлх хэлээр нь дууддаг, бичдэг энэ эрхэм буюу Батька (Агаа гэсэн утгатай) 1954 оны наймдугаар сарын 30-нд төрсөн. 1994 оноос хойш халаагүйгээр тус улсыг тэргүүлж буй нэгэн. Ерөнхийлөгчөөс гадна БНБелУ-ын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Үндэсний олимпын хорооны Ерөнхийлөгч. Албан тушаалд ажилласан жилээрээ Европт ганцаараа толгой цохино. Харин ТУХН-ийн орнууд дотроо Тажикистаны Э.Рахмон энэ хоёр тэргүүлнэ.

“Лукашэнка” гэх энэ нөхөр 1991 оны хавар (СССР тарах дөхөж байх үе) тус улсын Дээд Зөвлөлд “Ардчиллын төлөө коммунистууд” фракц байгуулан улс төрд тодорч эхэлжээ. Багшийн дээд сургууль төгссөн, хилийн цэрэгт улс төрийн ажилтан, халагдаад комсомолын хурган дарга, дараа нь танкийн цэрэгт сумангийн улс төрийн орлогч, цэргээс халагдаад мужийн эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, хамтралын дарга явсан гэснээс өөрөөр А.Лукашенкогийн намтарт гялтайх юм алга.

Коммунист намыг Зөвлөлт даяар хориглосны

дараа тэрбээр “Ард түмний зөвшилцлийн нам” байгуулсан нь бүтэлгүйтсэн. СССР-ийг тараах тухай Беловежийн хэлэлцээрийг Беларусийн Дээд Зөвлөл батлахад цор ганцаараа эсэргүүцсэн депутатаар А.Лукашенко тодрон, СССР тарсныг “ХХ зууны геополитикийн аугаа их сүйрэл” гэж нэрлэсэн нь түүнийг алдаршуулжээ. 1993-1994 онд А.Лукашенко Дээд Зөвлөлийн авлигатай тэмцэх түр комиссыг толгойлж ажилласны эцэст Ерөнхийлөгчөөр сонгогдсон.

Эдүгээ тус улсад улс төрийн 15 нам бүртгэлтэй гэсэн баримт байна. Тэдгээрээс А.Лукашенког дэмждэг нь Беларусийн коммунист нам, Хөдөлмөр шударга ёсны бүгд найрамдах нам, БНН, Беларусийн хөдөөгийн нам, Нийгэм-спортын нам, Беларусийн эх оронч нам бол дэмждэггүй нь “Шударга ертөнц” зүүний нам, Ногоон нам, Иргэний нэгдсэн нам, Беларусийн үндэсний фронт нам, Консерватив-христосын нам, Социал-демократ Грамада нам, Беларусийн Социал-демократ нам юм. Илт сөрөг хүчний үйл ажиллагаа явуулдаг нь Либерал-ардчилсан нам, Ард түмний зөвшилцлийн социал-демократ нам гэсэн мэдээлэл саяхныг болтол ил байв. Одоо яг ийм мэдээлэл алга.

Харин дээр жагсаасан намуудаас тэс хөндлөнгийн, чухам өнгөт хувьсгалын тугч гэмээр “Засгийн эрхийг шилжүүлэн авах, зохицуулах зөвлөл”, “Европын Беларусь”, “Беларусийн христосын ардчилгачид”, “Улс үндсээ аврах фронт”, “Хартия 97” гэхчлэн цоо шинэ хөдөлгөөн, холбоо буй болсон. Светлана Тихановская, Андрей Санников, Николай Статкевич, Павел Северинец, Сергей Тихановский, Виктор Бабарико, Валерий Цепкало, Светлана Алексиевич, Павел Латушко, Ольга Ковалькова, Мария Колесникова гээд сөрөг хүчний олон лидерийн нэр ярайна.

Тэд л өнгөт хувьсгалыг төлөвлөж хэрэгжүүлнэ хэмээн профессор В.Жарихин хардсан нь үнэн болж таарсан. Түүний ярьснаас үзэхэд өмнөх 15 намын лидер, мөрийн хөтөлбөр, түүхэн замнал оросуудад хэдийнэ танил болсон, тэднээс Москва ►

Түүнийг адрах харгислах тусам ард иргэд нь Москваг түгшээнэ. Ялангуяа тэдний тэмцэл ганц А.Лукашенкогийн эсрэг бус, түүнийг дэмжиж байгаа Кремлийн эсрэг чиглэх нь нэн аюултай

► сүрдэж балмагдаж байсангүй. Харин “Европын” гэгдсэн нөхдүүд (дээр дурдсан хүмүүс!) ноцтой балаг тарьна гэсэн нь чухам Оросын цор ганц зовнилыг хэлсэн хэрэг юм.

Тав. Цаашаа хэрхэх вэ?

Тус улсын дотоод, гадаадад цоо шинэ нөхцөл байдал үүслээ. Шинээр төрсөн оппозиц бүгд ялтан болохгүй байх. Ард түмэн гэнэт нэг өдөр А.Лукашенкод хайртай болно гэж бүр байхгүй. Түүний ялалтыг (Ерөнхийлөгчийн сонгуульд 80 хувиар ялсан) Европ, АНУ, ардчилсан ертөнцөд хүлээн зөвшөөрөхгүй нь нэн гачлантай. Ганц Орос дэмжээд юунд хүрэх вэ? ТУХН-ийн орнууд баяр хүргэчихээд дараа нь ус балгасан мэт таг чиг. Бүгд л төвийг сахья гэсэн байх. Евразийн эдийн засгийн

холбоо, ОДКБ, ШХАБ энэ улсад дорвитой тусалж чадах уу? Ард түмний тэмцэл хөдөлгөөнийг нухчин дарах тусам түүний нэр хүнд унана.

Хэчнээн эх оронч, тусгаар тогтнолын төлөө, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө хийлээ ч гэсэн хэлмэгдэл бол хэлмэгдлээр л, урсан их цусаар л дуусна. Тэрбээр түүхийн өмнө буруутнаар тодорно. НАТО-ийн

цэрэг, Польш, Балтийн гурван улсаар ард түмнээ айлгах, Украинаар жишээлж сүрдүүлэх нь нэг л явуургүй. Ихээхэн улиглавал хүүхэд нохойн доог болно. Итгэхээсээ итгэхгүй нь их болно.

Ингэж аяглах тусам нь өнгөт хувьсгалын технологид илүү суралцсан, илүү шийдмэг, илүү ухаалаг сөрөг хүчнийг бугшуулна гэдгээ тэрбээр мэдэхгүй байх шиг. Түүнийг адрах харгислах тусам ард иргэд нь Москваг түгшээнэ. Ялангуяа тэдний тэмцэл ганц А.Лукашенкогийн эсрэг бус, түүнийг дэмжиж байгаа Кремлийн эсрэг чиглэх нь нэн аюултай. Беларусийн ард түмнийг НАТО, Европын Холбоогоор айлгах Москвагийн тактик цаг үеэ өнгөрөөсөн, гэхдээ орос нөхөд үүнийгээ ойлгохгүй байгаад л асуудал оршино.

Тус улс дахь тэмцэл Украины сценараар явагдана хэмээн Москва урьдчилан төсөөлж, бэлтгэж байх шиг. Өнгөт хувьсгалд далдуур

бэлтгэж эхэллээ гэх хардлага оросуудад байгаа. Оросын цэрэг, техник, тусгайгийнхан тус улсад очлоо гэх мэдээ явж байна. Үнэн худал нь бүү мэд? А.Лукашенко дотооддоо хэрхэн дарангуйлах нь одоо нэн чухал. Тэсч тогтоод үлдэх (дэлхий зөвшөөрөхгүй ч засгийн эрхээ барьсаар үлдсэн Венесуэл хувилбар), эсвэл өөрийнхөө оронд Орост нэн үнэнч хайртай нэг нөхрийг олж тавиад зайлах, үүнээс өөр сонголтыг Орос харахыг ч үл хүснэ.

Проф.Жарихины сэрэмжлүүлэг, сануулга ч бас ноцтой. “Кремль 2012 онд дэндүү амар амгалан байсан ба “Янукович бол Шевардназе биш, тэр засгийн эрхийнхээ төлөө хоёр гараараа тулгуур хийж байна, унахгүй, юу ч болохгүй” хэмээн тайвширч суутал чинь юу болж дууслаа” хэмээн орос эрдэмтэн ам асуужээ.

Оросын улс төрч В.Жириновский бүр ил тод зарласан. “А.Лукашенкогийн халааг авах хүн Беларусийг Украины сценараар хөгжүүлж таарна, тэгэхээр Оросын тусламжгүйгээр чи хаашаа ч холдохгүй ээ, эцсийн аврал энэ болно гэдгийг Лукашенкод яс маханд нь тултал ойлгуулах хэрэгтэй. Беларусийг Өрнөдийн тал баримтлагч улс болгохын оронд Оросын бүрэлдэхүүнд бүхлээр нь авбал таарна. Тэрбээр Беларусь, Оросыг бэхжүүлж өгсөн түүхэн хүнээр дуурсагдана биз”. А.Жириновскийн мэргэн үгс!

Бүр үл таашаамаар прогноз ч Оросын сайтуудаар явж байна. А.Лукашенко Өрнөдийн хоригийг үл тооно, сөрөг хүчнээ үл сонсоно. Тэрбээр жагсаал цуглаан, хугацаагүй суулт акцыг хүчээр нухчин дарна. Хатуу нударгаар үзнэ. Цагдаа үл хүчирвэл цэрэг оруулна, Оросын хөлсний цэрэг ч очиж мэднэ, цус их урсгана, буулт хийхгүй, улс төрийн яриа хэлэлцээ хэзээ ч хийхгүй. Гэвч ард олны тэмцэл хавтгайрна, Киевийн "Майдан" шиг гудамжны баррикадын хоёр талаас үзэлцэнэ, Беларусийн арми, цагдаагийнхан тэмцэгчид рүү үй олноороо шилжиж орно, Засгийн газраа огцруулах гэж тэмцэнэ, онц байдал, байлдааны цагийн байдал зарлаад ч нэмэр болохгүй.

Эцэстээ А.Лукашенко баахан хүний амиар огцорно, Орос руу дүрвэнэ...Цаашаа яаж өрнөхийг тэнгэр мэдтүгэй гэх маягаар Оросын тэр сайтад бичжээ.

Яг хөөгдөөд буух дээрээ тулбал А.Лукашенко, В.Янукович хоёрт ялгаа юу байна вэ? Тэгээд хоёулаа Орос руу дүрвэбэл? ■

Беларусийн ард түмнийг НАТО, Европын Холбоогоор айлгах Москвагийн тактик цаг үеэ өнгөрөөсөн, гэхдээ орос нөхөд үүнийгээ ойлгохгүй байгаад л асуудал оршино

Хэл соёл

Аминаас үнэтэй эх хэл минь

“Өрөөлийн хэл бол багаж юм. Өөрийн хэл бол амь юм”. 2020-2021 оны хичээлийн жил эхэлснээс хойш сүүлийн арваад хоног Өвөр Монголд өрнөж буй эсэргүүцлийн хөдөлгөөний утга учир хийгээд үнэ цэн ерөөс товчхондоо энэ билээ. Наймдугаар сарын 30-аас хойш Өвөр Монголын Тонляо хотод дунд сургуулийн сурагч, Шилийн Гол аймгийн багш, Онниуд хошууны малчин, сүүлд Алшаа аймгийн намын хорооны гишүүн Сурнаа зэрэг дөрвөн хүн Хятадын Коммунист намын боловсролын шинэчлэлтийн хөтөлбөрийг эсэргүүцэж амиа хорлосон. Өвөр Монгол даяар эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд нь явуулахгүй, иргэд өргөх бичиг цуглуулж, жагсаал, цуглаан өрнөсөөр байна.

Түүхийн нугачаанд элэг нэгтнүүдээсээ тасарч өмнөд нутгийн нэг хэсэг болсон Өвөр Монголын 25 сая хүн амын ердөө тав орчим сая нь монголчууд. Оросын нөлөөнд кирилл бичигтэй болсон тусгаар Монгол Улсын гурван сая иргэнтэй харьцуулахад хүний нутагт амьдарч буй тэд түүх, соёл, тэр дундаа уламжлалт босоо бичгээ өнөөг хүртэл хадгалан, хэрэглэж ирсэн. Харин Хятадын Засгийн газрын сургалтын хөтөлбөрийн шинэ бодлого уйгаржин монгол бичгийг ирээдүйд устаж үгүй болох бичгийн нэгд оруулж мэдэх нь. ЮНЕСКО-ийн устах аюулд орсон хэлний атласаас харвал, 1950-2010 оны хооронд дэлхий даяар 230 гаруй хэл устжээ. Өнөөдөр дэлхийд 1000 гаруй хэл оршиж буйгаас хоёр долоо хоног тутамд нэг үндэстэн ястны хэл устан алга болж байна. Энэ зууны төгсгөл гэхэд эдгээр хэлний 50-90 хувь бүрмөсөн устах эрсдэлтэй байгааг хэл судлаачид анхааруулж байна.

Хэлний бодлого

Хэл бол тухайн үндэстэний оршин буйг тодорхойлох хамгийн гол хэмжүүр. Тиймээс



аливаа улсын албан ёсны хэлний бодлого нь үндсэрхэг үзлийг дэврээх, үндэстэн ястан хоорондын зөрчил, мөргөлдөөний шалтгаан болох нь бий.

БНХАУ байгуулагдсанаас хойш хил орчмын мужуудад хэрэгжүүлж байсан албан ёсны хэлний бодлого нь үндэстний цөөнхийн санаа бодлыг тусгасан, уян хатан байв. Гэвч 1990 оноос хойш энэ байдал өөрчлөгдөж, илүү тулган шаардсан шинжтэй, геополитикийн нөхцөл байдалтай уялдах болов. 2017 онд Хятадын Коммунист Нам улс орон даяар “Сурах бичгийг шинэчлэх хороо” гэгчийг байгуулжээ. Ийнхүү шинэчлэн боловсруулсан ном, сурах бичгүүдийг сүүлийн жилүүдэд улс орон даяар сургуулиудад нэвтрүүлэв. Тэгвэл энэ хичээлийн жилээс Өвөр Монголын сургуулиудад нэвтрүүлж буй шинэ хөтөлбөрийн хүрээнд бага, дунд ангийн сурагчдын “уран зохиол”-ын хичээлийг мандарин хэлээр үзэхээр болжээ. Ирэх жил “улс төр”, “ёс зүй”, 2022 оноос түүхийн хичээлийг хятад хэлээр үзэж эхэлнэ. Мөн Өвөр Монгол сурагчид хятад хэлийг өмнө нь хоёрдугаар ангиасаа үздэг байсан бол нэгдүгээр ангиасаа үзэх нь. ►

► Хятадын Засгийн газар ийм арга хэмжээг өмнө нь Төвөд, Шинжаанд хэрэгжүүлж байсан билээ. Хуучин Зөвлөлтийн цөөн тоот үндэстний хэл соёлыг дэмждэг бодлоготой харьцуулахад хятадууд хан үндэстний соёлыг түгээж, бусад үндэстнийг уусгах бодлогод үндэслэн боловсролын тогтолцоогоо өөрчлөх болсон. Ерөнхийлөгч Ши Жиньпин өмнө нь “Хэрэв хүмүүс нэг ижил хэлээр ярихгүй бол хоорондоо харилцахад хүндрэл үүсэж, ойлголцолд хүрч чадахгүй” гэж хэлсэн байдаг. 2014 онд зохион байгуулагдсан Төвийн үндэстний ажлын бага хурлын үеэр тэрбээр, “Үндэстний цөөнхийн сургуулиуд хятад хэлээр хичээллэж эхэлбэл ажлын байр нэмэгдэх, үндэстний цөөнх болсон иргэд орчин үеийн шинжлэх ухаан, соёлын мэдлэгийг олж авах, нийгмийн интеграцид оролцох боломж бүрдэнэ.” гэж байв.

2020-2024 оны хооронд хэрэгжих “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг эрчимжүүлэх нь өнөөдөр амь насаа хүртэл золин тэмцэж буй Өвөр Монголчуудын тэмцлийн гол зорилго хийгээд үр дүн болох учиртай

Өвөр Монголын Автономит мужид оршин суудаг хүн амын дийлэнх нь хан үндэстэн байдаг ч гэлээ, үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөн Шинжаан, Төвөдтэй адил хурц, ширүүн хэлбэрт хүрч байсангүй. Тэгвэл өдгөө өвөр монголчуудын тэмцэл эсэргүүцэл, мөргөлдөөн, амь насаа золих хэмжээнд хүртэл ширүүссэн учир эрх баригчид олон нийтийн сүлжээнд хатуу хяналт тавьж, энэ тухай мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхийг

хориглож байна. WeChat-тай адил “Байна уу” нэртэй монгол хэлээрх нийгмийн сүлжээний сайтыг өвөр монголчууд ихэд ашигладаг бөгөөд уг платформийг хүртэл хаажээ. Болж буй үйл явдлыг ажиглагчид ХКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгч Ши Жиньпиний удирдлаган дор хэрэгжиж буй “хоёр дахь үеийн үндэстэн ястны бодлого” хэмээн нэрийдэж байна.

Түүх давтагдах уу

2008 онд Шинжаан-Уйгарт өрнөсөн үймээн самууныг олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр террористуудын үйл ажиллагаатай холбон тайлбарлаж байлаа. Яг үнэндээ энэ үйл

явдал нь олон улсын терроризм гэхээс илүүтэй дотоодын зөрчилдөөн байсан. Бээжингийн орчин үеийн Хятад улсыг байгуулах, үндэстнийг уусгах бодлогын шилжилт нь Шинжаан-Уйгарт үндсэрхэг үзлийг дэвэргэж, салан тусгаарлагч жижиг бүлгүүдийн хөдөлгөөнийг өдөөсөн юм. Тухайн үед нэвтрүүлсэн хэлний бодлого нь боловсролын тогтолцоонд хятад хэлний нөлөөг нэмэгдүүлж, цөөнхийн хэл соёлын нөлөөг бууруулж, Уйгар өв соёлд шууд халдсан хэрэг хэмээн жирийн уйгар иргэд шүүмжилж байв. Гэхдээ уг бодлого нь бүс нутагт улстөрийн тогтвортой байдал бий болгох, эдийн засгийн хөгжлийг үргэлжлүүлэн явуулахад чухал алхам гэж Бээжин тайлбарласан.

2004 оны гуравдугаар сард ХКН болон мужийн Засгийн газар үндэстний цөөнхийн сургуулиудыг хятад сургуулиудтай нэгтгэх шийдвэр гаргав. Шинжааны сургуулиудад уйгар, хятад, казах, киргиз, монгол, сибэ зэрэг олон үндэстэн ажиллаж байгаа нь боловсролын тогтолцоог үр ашиггүй болгож байна гэж эрх баригчид тайлбарлаж байлаа. 1984 оноос Шинжааны Боловсролын хороо нь уйгар хэлний оролцоог боловсролын бүх түвшинд аажмаар бууруулж, 1990 он хүртэл хятад хэлийг үндэстний цөөнхийн дунд хоёр дахь хэл болгон зааж байлаа. Харин үүнээс хойш дунд сургуулийн гуравдугаар ангиас эхлэн бүх хичээлийг хятад хэлээр орох болжээ. Сургуулийн өмнөх боловсролыг уйгар хэлээр олгодог цэцэрлэгүүдийн тоо хүртэл багассан байна. 2002 оны есдүгээр сараас Шинжааны Их сургуульд уйгар хэлээр нэг ч хичээл орохоо больсон нь уйгар хэлийг боловсролын тогтолцооноос халах Хятадын Засгийн газрын сүүлчийн алхам байлаа. Одоо уйгар уран зохиол, яруу найргийг хүртэл хятад хэлээр зааж байна. Их сургууль зөвхөн хятад хэлээр хичээл орох болсноос хойш ажилчид, багш нар хятад хэлний түвшин тодорхойлох HSK шалгалтыг өгөх болов. 2002 онд хятад хэлний түвшин нь шаардлага хангахгүй гэсэн үндэслэлээр 140 гаруй багшийг хугацаанаас нь өмнө тэтгэвэрт гаргажээ. Дараа нь 2017 оноос ахлах, дунд сургуулиуд дотуур байртай болж, хүүхдүүд долоо хоногт нэг удаа л гэртээ очих болов. Мөн дахин боловсрол олгох түр хотхонуудыг Шинжаан даяар байгуулж, Хятадын коллежэд элсэх шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, уг шалгалтыг төрөлх хэлээрээ бус хятад хэлээр өгөх болов. Ийнхүү шинжаан-уйгарчуудад төрөлх

► хэлээ сурч, хойч үедээ өвлүүлэн үлдээх боломж бүрмөсөн үгүй болсон юм.


Хэрэв Шинжааны уйгарчуудад эх хэлээрээ боловсрол эзэмших боломж олгосон бол тэд хятад хэлийг сурч, хэрэглэхээс цааргалахгүй байсан. Яг л киргизүүд орос хэл сурч, малайчууд англи хэл сурсаар байгаатай адил. Хэл нь зөвхөн харилцааны хэрэглэгдэхүүн бус зан заншил, сэтгэл хөдлөл, урлагийн илэрхийлэл зэрэг соёлыг илэрхийлэх олон талт ойлголт билээ. “Хэл соёлын нөлөөг хязгаарлахаас илүү өргөжүүлэх нь Хятадын хөгжлөөр хоцрогдмол баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогын нэг хэсэг байх ёстой” гэж алтай язгуурын хэл судлаач, Вашингтоны Их сургуулийн профессор Арриэн Дуаер онцолжээ.

Эх хэлээ хамгаалъя

Өвөр Монголд өрнөж буй үйл явдал тэртээ XIII зуунд Чингис хаан дэлхийн талыг дайлаар мордох үед харийн нутагт үлдсэн монгол үндэстэн, X зуунд өрнөсөн даяарчлалын давлагаанд гаднын орныг зорьж, дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй монголчуудыг сэрээлээ. Японд амьдардаг монголчууд Шизуока Их сургуулийн профессор Ян Хайгаар удирдуулан эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлж байна. АНУ-д төвтэй Өмнөд Монголын хүний эрхийн мэдээллийн төвийн дарга Т.Энхбат, Хятадын Засгийн газрын шийдвэр нь Өвөр Монголд амьдарч буй монголчуудын эрхийг зөрчиж буй үйлдэл хэмээн олон улсын хэвлэлүүдэд ярьсан. Европын орнууд дахь Хятадын Элчин сайдын яамны гадна монголчууд өөрсдийн дуу хоолойгоо хүргэн жагсаж буй. Хэдийгээр эдийн засгийн хувьд урд хөршөөсөө хараат болсон ч гэлээ монгол иргэд Гадаад харилцааны яамны гадна өвөр монголчуудыг дэмжин, эх хэл, бичиг соёлоо хамгаалахыг уриаллаа. Мөн монгол хэл, соёлыг аварч үлдэх зорилготой гарын үсэг цуглуулах аян нийгмийн сүлжээний сувгуудаар олон улсын хэмжээнд өрнөж байна.

Их гүрний дотоод асуудалд гадны улсууд оролцох нь дипломат ёсонд зохимжгүй тул Монгол байтугай бусад улс ч энэ талаар байр сууриа илэрхийлэх боломжгүй. Олон нийт НҮБ-ын боловсрол, соёлын байгууллага болох ЮНЕСКО-г монгол үндэстний өвөрмөц хэл, бичгийг хамгаалах үйлсэд дуу хоолойгоо илэрхийлэх болов уу хэмээн

Дэлхийн хэлнүүдийн хэрэглээний байдал, 2010 он



Эх сурвалж: unesco.org

найдаж байна. Гэвч АНУ тус байгууллага дахь санхүүжилтээ бууруулж, 2018 оноос хойш албан ёсоор гишүүнчлэлээ татаж авснаас хойш БНХАУ гол санхүүжүүлэгч нь болж, тус байгууллагад ажиллаж буй хятад ажилчдынхаа тоог нэмсээр байгаа билээ.

Дэлхий даяар монголчуудын өрнүүлж буй эсэргүүцлийн хөдөлгөөн Хятадын бодлогыг өөрчилж чадахгүй ч, нэг үндэс угсаатай үндэстэн гэдгээ илэрхийлж буй хэрэг. Нөгөө талаас энэ тэмцлийн бодит үр дүн нь хэл, бичгээ аварч үлдэх явдал. Тэгвэл монгол үндэстнийг дэлхий дахинд оршин буй гэдгийг харуулж буй тусгаар Монгол Улсад өнөөдөр боловсролын салбар дахь шинэчлэлтийн тухай өргөн хүрээний мэтгэлцээн олон нийтийн дунд өрнөж буй. Энэ шинэчлэлтийн нэг хэсэг нь эх хэлээ хамгаалж үлдэх, босоо монгол бичгээ бүх нийтээрээ хэрэглэж, эзэмших явдал болж байна. 2020-2024 оны хооронд хэрэгжих “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг эрчимжүүлэх нь өнөөдөр амь насаа хүртэл золин тэмцэж буй Өвөр Монголчуудын тэмцлийн гол зорилго хийгээд үр дүн болох учиртай. ■

Санхүүгийн боловсрол

“Зарлагаа хэрхэн удирдаж буйгаар нь санхүүгийн сахилга баттай эсэхийг тодорхойлж болно”



Санхүүгийн хариуцлага, сахилга баттай байхын ач холбогдлын талаар “Ард Кредит” ББСБ ХК-ийн Гүйцэтгэх Захирал Г.Тэлмэн ийн ярьж байна.

-Санхүүгийн сахилга бат гэж их яригддаг болжээ. Та ямар хүнийг “санхүүгийн сахилга баттай” гэж тодорхойлох вэ?

-Товчхондоо, санхүүгийн тодорхой “дүрэм”-тэй хүнийг хэлнэ. Ямар ч үед түүнийгээ баримталдаг, үгүй ядаж баримтлах гэж хичээдэг хүнийг хэлэх болов уу. Хүмүүс орлого л нэмэгдчихвэл хүссэн зүйлээ авчих юм шиг боддог. Энэ нь мэдээж буруу биш, гэхдээ зарлагаа хэрхэн удирдаж буйгаар нь тэр хүнийг санхүүгийн сахилга баттай юу, үгүй юу гэдгийг тодорхойлно.

Саяхан миний найз өөрийн фэйсбүүк хуудастаа, ах дүүсээрээ цуглаад хэн хэр их хуримтлал үүсгэсэн тухай ярилцсанаа бичсэн байсан. Логикийн хувьд их орлоготой нь илүү их хуримтлал үүсгэсэн байж таарна. Гэтэл тэднээс хамгийн бага орлоготой нь хамгийн их хуримтлал үүсгэсэн тухайгаа ярьсан байсан. Энд л санхүүгийн сахилгатай болон сахилгагүй хүмүүсийн ялгаа гарч байгаа юм. Зарим найз нөхөд маань өндөр цалин, орлоготой мөртлөө байнга л цалингаас цалингийн хооронд амьдралаа залгуулж, зээл, өр төлбөртэй байдаг шүү дээ. Энэ нь тэдгээр хүмүүс

хэрэглээгээ хянадаггүйтэй холбоотой.

- Нийгэмд маш олон төрлийн мэргэжилтэй хүмүүс бий ч бүгд тодорхой хэмжээгээр санхүүгийн харилцаанд орж байдаг. Санхүүгийн бус мэргэжлийн хүмүүст санхүүгээ эрсдэлээс хамгаалахад нь туслах үүднээс та юу гэж зөвлөх вэ?

- Хамгийн түрүүнд өөрийн гэсэн санхүүгийн дүрэмтэй болох хэрэгтэй. Мэдээж хэрэг санхүүгийн зөвлөхөөс зөвлөгөө авч, ном уншиж, интернэтээс мэдээлэл хайж болно. 50/30/20-ийн дүрэм, 40/20/20/20-ийн дүрэм гэх мэт олон дүрэм гарч ирэх байх.

Мөн орлогоо хамгийн түрүүнд, юунд зарцуулахдаа анхаарал хандуулах хэрэгтэй. Улс орон, өрх гэр, хувь хүн ч бай энгийнээр тайлбарлахад Нийт Зардал = Орлого + Зээл байдаг. Зээл муу зүйл биш боловч хэт их хэрэглээг санхүүжүүлбэл муу, харин эсрэгээрээ орлого дэмжсэн үйл ажиллагаанд зарцуулж байвал сайн зүйл юм. Өөрөөр хэлбэл, зээл бол бид ирээдүйн орлогоосоо урьдчилан авч хэрэглэж буй нэг хэлбэр. Энд энгийн нэг зүйлийг санахад илүүдэхгүй. Тэр нь юу гэвэл зээлийн өсөлт таны орлогын өсөлтөөс хэрхэвч давж болохгүй. Хэрэв тэгвэл та ирээдүйн орлогоороо зээлээ төлж чадахгүйд хүрч мэднэ.

Үндсэн сэдэвтээ буцаад орёе. Та зардалдаа анхаарах хэрэгтэй. Таныг зардалаа үндсэн гурван

► хэсэгт хуваахыг зөвлөө.

Нэгдүгээрт, хоол хүнс, цахилгаан дулаан, орон байр (ипотекийн зээл), эрүүл мэндийн даатгал зэрэг нэн шаардлагатай хэрэгцээт зардлууд орно. Энэ нь таны зардлын нэлээд хэсгийг бүрдүүлнэ. Дээр дурдсан 50/30/20-ийн дүрмээр бол орлогын тань 50 хувь үүнд зарцуулагдана гэж тооцёё.

Хоёрдугаарт, шоппинг хийх буюу хааяа дэлгүүр хэсэж дуртай зүйлсээ авах, гадуур хооллох, өөрийн хобби зэргийг оруулж болох юм. Үүнд орлогынхоо 30 хувийг зарцуулдаг гэж бодъё. Үндсэндээ, энэ нь амьдралд нэн шаардлагатай хүнс, орон байртай адил зардал биш юм.

Гуравдугаарт, урт хугацааны тэтгэврийн сангийн хуримтлал, богино хугацааны хуримтлал, онцгой нөхцөл байдалд зориулсан хуримтлал, кредит картны зээл төлөх болон бусад зардлыг оруулж болно. Өрх гэрийн эдийн засгаа эрсдэлээс хамгаалахын тулд үндсэн хэрэглээгээ танах нь амаргүй шүү дээ. Тиймээс хүсэл сонирхлын зардлаа багасгаж, хуримтлалдаа илүү орлого төвлөрүүлэх нь үр дүнтэй.

Сахилга бат сайтай хүмүүс ихэвчлэн санхүүгийн зорилготой байдаг. Жишээ нь, онцгой үеийн хуримтлалдаа зориулж, 6-12 сарын цалингийн орлоготой дүйцэхүйц хуримтлал бүрдүүлнэ гэх зэргээр нарийн төлөвлөдөг. Энэ нь гэнэт ажил орлогогүй болоход дараагийн орлого, цалинтай золготол таныг болон гэр бүлийг тань эрсдэлээс хамгаалах юм. Мэдээж хэрэг төрөл бүрийн даатгалын хэрэгслүүдийг ашиглаж эрсдэлээ хааж болно.

- Санхүүгээ зөв удирдахыг хүсдэг хүн бүрийн мэдвэл зохих таван алхмыг нэрлэ гэвэл та юуг нэрлэх вэ?

-Юуны өмнө цэвэр орлогоо тооцож мэддэг байх ёстой. Өөрөөр хэлбэл, татварын дараах орлого гэсэн үг. Ихэнх хүн татварын дараа гар дээр авдаг цалингаа цээжээр хэлж мэддэггүй нь сонирхолтой санагддаг. Гэнэтийн орлогоо ч мөн тухайн сарын орлогодоо тооцох хэрэгтэй. Хоёрдугаарт, нэг сарын зардлаа тодорхой тэмдэглээд үз. Гуравдугаарт, тэрхүү сарын зардлаа ангил. Өмнө миний хэлсэн ангиллыг ашиглаж болох юм. Та ямар их үрэлгэн, хэрэггүй зүйлсэд зардал гаргадагаа ойлгох болно. Орлого, зардлаа тооцоод зардлаа ангилчихлаа. Үүний дараа буюу дөрөвдүгээрт, өөртөө санхүүгийн зорилго тавь. Би төдий хэмжээний мөнгөн хуримтлал үүсгэнэ гэх

зэргээр тодорхой тоо гарга. Түрүүн хэлсэнчлэн онцгой үеийн хуримтлалдаа 6-12 сарын цалинтай дүйцэх хуримтлал үүсгэнэ гэдэг ч юм уу.

Эцэст нь өөрийн гэсэн дүрэмтэй, санхүүгийн зорилготой болсон бол ямар ч үед түүнийгээ ягштал биелүүлэх гэж хичээн чармай. Үүнийг л хамгийн энгийнээр санхүүгийн сахилга бат гэж байгаа юм.

- Санхүүгийн хариуцлагатай байдал бидний амьдралд ямар үр дүн авчрах вэ?

-Коронавирусийн (COVID-19) цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн нэлээд таагүй үед бид амьдарч байгааг бүгд мэдэж байгаа. Саяхан буюу тавдугаар сард Дэлхийн Банк болон Үндэсний Статистикийн Хорооноос өрхийн судалгаа хийсэн. Тус судалгаанаас үзвэл 10 өрх тутмын нэг нь тэг орлоготой болж, 10 өрх тутмын долоо нь орлого буурсан гэж хариулсан бол нийт өрхийн 40 хувь нь ирэх сарын санхүүгийн байдалдаа санаа зовж байна гэжээ.

Бодоод үзье. Хэрэв та санхүүгийн сахилга баттай, орлого хэвийн байх үедээ эрсдэлтэй цаг үед зориулаад 6-12 сарын цалинтай дүйцэхүйц хуримтлал үүсгэсэн байсан бол энэ үеийг та болон танай гэр бүл ажрахгүй даваад гарна шүү дээ. Эдийн засгийн яг ийм уналттай үед өөрийгөө болон өрх гэрээ эрсдэлээс хамгаалахын тулд санхүүгийн сахилга батыг баримтлах нь чухал юм.

Хэрвээ та санхүүгийн ямар нэг дүрэм баримталдаггүй бол яг одоо орлого, зардлаа бүртгэж, тооцохоос эхлээрэй. Дараагийн ээлжинд өнөөдрийн хэрэгцээгээ зээлээр хэрхэн санхүүжүүлэх, даатгалын хэрэгслүүдийг хэрхэн ашиглах гэх мэт зүйлийг судлан мэдэж, хамгийн гол нь хэрэгжүүлж сурах хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд “Санхүүгийн хариуцлагагүй, сахилга батгүй хүн өөрийн хүссэн зүйлээ хэзээ ч худалдан авч чаддаггүй” гэсэн үг байдагийг сануулахад илүүдэхгүй биз ээ. ■

Хэрвээ та санхүүгийн ямар нэг дүрэм баримталдаггүй бол яг одоо орлого, зардлаа бүртгэж, тооцохоос эхлээрэй.

Дараагийн ээлжинд өнөөдрийн хэрэгцээгээ зээлээр хэрхэн санхүүжүүлэх, даатгалын хэрэгслүүдийг хэрхэн ашиглах гэх мэт зүйлийг судлан мэдэж, хамгийн гол нь хэрэгжүүлж сурах хэрэгтэй